

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар, Сүхбаатар, 2006-2007

ГАРЧИГ

ОРШИЛ _____	2
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ _____	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БҮСЧЛЭЛ, ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ _____	24
Газрын зураг 1: Сэлэнгэ аймгийн хөгжлийн бүсчлэл, хүн амын суурьшлын газрын байршил, төлөвлөлт _____	32
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ	33
Газрын зураг 2: Сэлэнгэ аймгийн дэд бүтцийн газрын байршил, төлөвлөлт _____	38
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. УСАН САНГИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ	39
Газрын зураг 3: Сэлэнгэ аймгийн усан сангийн газрын байршил, төлөвлөлт _____	45
Газрын зураг 4: Сэлэнгэ аймгийн бэлчээр усжуулалтын байдал, төлөвлөлт _____	46
ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ	47
Газрын зураг 5: Сэлэнгэ аймгийн хөдөө аж ахуйн газрын байршил, төлөвлөлт _____	71
Газрын зураг 6: Сэлэнгэ аймгийн хөрсний зураг _____	72
Газрын зураг 7: Сэлэнгэ аймгийн усалгаатай тариалангийн байршил, төлөвлөлт _____	73
ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ОЙН САНГИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ	74
Газрын зураг 8: Сэлэнгэ аймгийн ойн сангийн газрын байршил, төлөвлөлт _____	78
ДОЛДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ _____	79
Газрын зураг 9: Сэлэнгэ аймгийн тусгай хэрэгцээний газрын байршил, төлөвлөлт _____	84
Газрын зураг 10: Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн байршлын зураг _____	85
НАЙМДУГААР БҮЛЭГ. АМРАЛТ, РАШААН СУВИЛАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ _____	86
Газрын зураг 11: Сэлэнгэ аймгийн амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газрын байршил, төлөвлөлт _____	90
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. АШИГТ МАЛТМАЛ, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ _____	91
Газрын зураг 12: Сэлэнгэ аймгийн ашигт малтмал, үйлдвэржилтийн газрын байршил, төлөвлөлт _____	97
ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД _____	-100

ОРШИЛ

Аливаа улс, үндэстний оршин тогтнох үндэс нь газар нутаг бөгөөд түүхэнд улс гэдэг ойлголт ястан, үндэстэн, овог аймгуудын нийтлэгээр тодорхойлогддог байсан нь нийгмийн хөгжлийн явцад газар нутгаар харьяалагддаг болсноор газрын үнэлэмж асар өндөрт тавигдах болсон юм.

Төрөөс явуулж буй газрын харилцааны шинэтгэлийн бодлогын хүрээнд 2002 онд “Газрын тухай хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-иудыг батлан мөрдүүлснээр иргэдийн газарт хандах хандлага өөрчлөгдөж, өөрийн гэсэн өмчийн газартай болж түүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулах замаар амьдрал ахуйгаа дээшлүүлэх сонирхол ихээр нэмэгдэж байна. Тиймээс ч газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж улс, аймаг, орон нутгийн хөгжлийн алс хэтийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжиж, газрын нэгдмэл сангийн ангилал бүрд эдийн засгийн үр ашигтай цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох асуудал чухал юм. Үүний тулд газар нутгийг бүсчлэн хуваарилах аргаар аймгийн нутаг дэвсгэрийн газрын менежментийн бодлогыг:

- ✓ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2000,
- ✓ Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт, УИХ-ын тогтоол, дугаар 25, 2005,
- ✓ “Мянганы зам” төсөл, УИХ-ын тогтоол, дугаар 09, 2001
- ✓ Монгол Улсын хөгжлийн цогц бодлого, 2007
- ✓ Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 1999,
- ✓ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2003,
- ✓ Монгол Улсын уул, уурхайн салбарын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл, 2002,
- ✓ Монгол Улсын мэдээлэл, холбооны салбарын бодлого, зохицуулалтын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал (концепц), 2005,
- ✓ Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт, 2005
- ✓ Сэлэнгэ аймгийн 2001 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр, 2007 ба бусад чиглэлүүдтэй уялдуулан, 2006-2010, 2011-2015, 2016-2021 он гэсэн 3 үе шаттай боловсруулав.

Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажлын даалгаврыг Байгаль орчны сайдын 2002 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 151 тоот тушаалаар баталсны дагуу 2003 онд Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан билээ. Энэхүү улсын хэмжээний төлөвлөгөөг өөрийн

аймгийн онцлогт тулгуурлан нарийвчлан боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр Сэлэнгэ аймгийн ЗДТГ тендер зарлаж, уг тендерт “Гурван тайга” ХХК шалгарсан юм.

Газрыг зөв зохион байгуулах, зохистой төлөвлөж ашиглах, тууштай хамгаалах, хадгалах нь ард иргэдийн амьдралыг сайжруулах, улс орны хөгжлийг хангах үндэс болно. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа түүнийг тухайн аймгийн эдийн засаг-нийгмийн хөгжлийн ерөнхий хандлагатай нягт уялдаатай авч үзсэн болно. Бид газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөө 2005 оны сүүлч 2006 онд боловсруулсан боловч 2006 онд боловсруулж, 2007 онд батлуулах Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр гарахыг хүлээж, түүнтэй уялдуулан зохих засвар хийлээ.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлтийг газрын дараах ангиллаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Аймгийн хөгжлийн бүсчлэл, хүн амын суурьшлын газар,
- ✓ Дэд бүтцийн газар,
- ✓ Усан сангийн газар,
- ✓ Хөдөө аж ахуйн газар,
- ✓ Ойн сангийн газар,
- ✓ Тусгай хэрэгцээний газар,
- ✓ Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газар,
- ✓ Ашигт малтмал, үйлдвэржилтийн газар.

Төслийн гэрээнд:

- ✓ “Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” төслийн тайлан,
- ✓ Зургууд (аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний сэдэвчилсэн зургууд),
- ✓ Хүснэгт болон тооцоонууд,
- ✓ Төлөвлөлтийн талаар гүйцэтгэгчийн санал, хувилбарууд,
- ✓ Бүх мэдээллийг тоон хэлбэрт оруулсан компакт дискүүдийг захиалагчид нийлүүлнэ гэж заасны дагуу тайлан, бусад материалыг бэлтгэлээ.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлүүдийг онцолж анхаарсан болно. Үүнд:

- ✓ Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах явцад Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур баримт бичгүүд, тухайн салбар бүрийг хөгжүүлэх хэтийн чиглэл, бодлого, хууль эрх зүйн актуудыг суурь материал болгон авч үзсэн болно.

- ✓ Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээний дагуу ойрын 15-20 жилийн дотор газар, түүний үржил шим, баялгийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийг урьдчилан төсөөлөхийг оролдсон болно.
- ✓ Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны хэд хэдэн салбарын хөгжлийн ирээдүйтэй шууд холбоотой бөгөөд газар ашиглалтын системд гарах өөрчлөлтийг бүс нутаг, аймгийн түвшинд урьдчилан харсан газрын менежментийн бодлогыг онцлон анхаарлаа.
- ✓ Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлтийн явцад газрыг бүсчлэн хуваарилах аргаар газрын бодлогын нийтлэг ба тодорхой бүсүүдийг гаргав.
- ✓ Аймгийн нутаг дэвсгэрийн хаана, ямар зориулалтаар ашиглах, хичнээн га газар байхыг зураг, хүснэгт, өгүүлбэрээр харуулж, үүний үндсэн дээр тухайн салбарын хэрэгцээт газрын баланс, өөрчлөлтийг газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар тооцож гаргасан болно.
- ✓ Төлөвлөсөн, санал болгосон арга хэмжээ, объект бүрийн байршил, тархац, ареалыг М 1:100000-ны зургийн нарийвчлалаар харуулав.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хил хязгаарын доторхи газрын нөөц, экологи- эдийн засгийн даац, чадавхийг үнэлэхдээ мэдээллийг орон зайн мэдээллийн зарчмаар боловсруулж, Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан М1:100000-ны байр зүйн зураг дээрх үндсэн элементүүдийг газар зүйн мэдээллийн систем ашиглан тоон хэлбэрт оруулж, тэдгээрт харгалзсан атрибут мэдээллийг бүрдүүлэв. Энэ ажилд ашигласан техник, тоног төхөөрөмж, программ хангамж:

- ✓ Дижитайзер
- ✓ Сканнер
- ✓ PC P IV, Laptop Acer Mobil
- ✓ Плоттер HP DesignJet
- ✓ Принтерүүд Canon 6100, 6300 A3+ color, HP psc 1110 color, Canon LBP 1120 laserShot
- ✓ ArcView 3.22, Visio, Lindo simplex программуудыг хэрэглэв.

Төслийн зорилгыг биелүүлэхийн тулд бэлтгэл үе шат, орон нутгийн судалгаа, төлөвлөлтийн үе шат гэсэн 3 үе шатны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд уг ажлыг Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академитай хийсэн гэрээний дагуу ХААИС-д ажиллаж байгаа эрдэмтдээс татан оролцуулж гүйцэтгэлээ.

Бэлтгэл ажил, төлөвлөлтийн үе шатны ажлыг төслийн багийн удирдагч, доктор (Ph.D) Л.Нямбат, докторант Т.Эрдэнэчулуун, Д.Кадирбек, Ц.Ядмаа нар гүйцэтгэсэн

болно. Төлөвлөлтийн үе шатанд үнэтэй зөвлөлгөө өгсөн шинжлэх ухааны доктор Б.Дорж, шинжлэх ухааны доктор Н.Алтансүх нарт гүн талархлаа дэвшүүлж байна.

Хөдөө орон нутагт явж, төслийн хүрээнд хийгдээд байгаа ба цаашид хийгдэх ажлуудыг судлах, сумдын хөгжлийн цаашдын төлөв, түүнд шаардагдах эдэлбэр газрын нөөцийн талаар орон нутгаас барьж буй бодлоготой танилцаж, энэ талаар өмнө нь боловсруулсан төсөл, судалгаа, зураг, хурал, семинарын боломжтой бүх материалыг ашигласан болно.

Төслийг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлага, холбогдох мэдээллээр хангаж өгсөн Засгийн газрын тохируулагч агентлаг- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтэс, Сэлэнгэ аймгийн Газрын алба, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

Тайлан 9 бүлэг, хавсралт 3 хүснэгт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн сэдэвчилсэн 12 газрын зургаас бүрдэх ба нийт 100 хуудсанд бичигдсэн болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Сэлэнгэ аймаг нь Монгол орны хойд хэсэгт, баруун талаараа Булган, Орхон аймаг, өмнөд хэсгээрээ Төв, зүүн талаараа Хэнтий аймаг, хойд, зүүн хойд талаараа Оросын Холбооны Улстай хиллэдэг.

Аймгийн нийт нутаг дэвсгэр 4115.3 мянган га, 17 сум, 49 баг хороо, орон нутгийн зэрэглэлтэй Зүүнхараа, Хөтөл хотууд, аймгийн хэмжээнд нийт 99.8 мянган хүн (Статистикийн эмхтгэл-2005) амьдарч байна. Сэлэнгэ аймаг 1931 онд “Тариалангийн аймаг” гэсэн нэртэй байгуулагдаж төв нь Алтанбулаг байсан ба 1934 онд Сэлэнгэ аймаг гэж нэрлэгдэх болсон. Тус аймаг улсын бүх газар нутгийн 2.7 хувийг эзэлдэг боловч улсын ойн нөөцийн 10 гаруй, урсгал усны 55 шахам хувийг эзэлдэг. Сэлэнгэ аймаг ойт хээрийн агро-уур амьсгалын мужид багтах бөгөөд эдийн засгийн төв бүсэд хамаарагддаг.

Газрын нөөц. Сэлэнгэ аймаг хүн амын нягтшилаар дээгүүрт ордог. 2005 онд дэлхийн дунджаар нэг хүнд 2.7 га газар, Монгол Улсын дунджаар 61 га газар оногдож байхад Сэлэнгэ аймагт энэ үзүүлэлт 41 га байдаг.

Хүснэгт 1.1. Газрын нөөц, ангилал, сумаар, 2006

Газрын ангилал	Талбай, га	Дүнд эзлэх хувь
Нийт нутаг дэвсгэр	4115263	100.0
үүнээс: хөдөө аж ахуйн газар	2089090	50.8
хот, суурины газар	43450	1.0
зам, шугам сүлжээ	19177	0.5
усан сан	19442	0.5
ойн сан	1607462	39.0
улсын тусгай хэрэгцээний газар	336642	8.2
Нутаг дэвсгэр, сумаар		
Алтанбулаг	210030	5.1
Баруунбүрэн	281454	6.8
Баянгол	197628	4.8
Ерөө	820351	19.9
Жавхлант	118970	2.9
Зүүнбүрэн	120494	2.9
Мандал	484373	11.8
Орхон	130627	3.2
Орхонтуул	294083	7.1
Сайхан	131187	3.2
Сант	138706	3.4
Сүхбаатар	4535	0.1
Түшиг	249282	6.1
Хушаат	201015	4.9
Хидэр	283865	6.9
Цагааннуур	381472	9.3
Шаамар	67191	1.6


Эх үүсвэр- Аймгийн газрын нэгдмэл сангийн тайлан, 2005

Аймгийн нийт газрын тал илүү хувийг хөдөө аж ахуйн газар, 40-өөд хувийг ойн сан, 8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, үлдэх хэсгийг хотожсон газар буюу хот, суурин, зам, шугам сүлжээ, үйлдвэр, уурхайн газар эзэлж байна.

Сумуудын нутаг дэвсгэрийн хэмжээг авч үзвэл хамгийн том талбай буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 20 хувь нь Ерөө суманд, 12 хувь нь Мандал, 9 хувь нь Цагааннуур суманд байна.

Газрын ашиглалт. Монгол орны газрын нөөц, түүний ашиглалтын бүтэц, тогтолцоо нь нутаг дэвсгэрийн ялгаа ихтэй, түүнд газрын гадаргуугийн макро болон мезо түвшний орон зайн зүй тогтол ихээхэн нөлөөлсөн байдаг. Энэ байдал Сэлэнгэ аймгийн газрын ашиглалтад илэрч байна. Газар ашиглалтын эрчимжилт нь түүний ашиглалтын төрлөөс ихээхэн хамаардаг. Улсын хэмжээнд ашиглалтын эрчимжилтээрээ хамгийн үнэ цэнэтэйд ордог газар нь нийслэлийн газар, түүний дотроос хотын төв хэсэг, дараа нь Эрдэнэт, Дархан, Сүхбаатар хотууд ба бусад аймгийн төвүүд, дараа нь үйлдвэр уурхайн газар, зуслан, гэр хорооллын газар, харьцангуй эрчимжилт багатай ашиглагддаг нь тариалан, ой, хадлангийн газар, хамгийн эрчимжилт багатай нь бэлчээрийн талбай юм.

Зураг 1.1. Газар ашиглалтын эрчимжилт төрлөөс хамаарах нь



Тус аймаг бусад аймгийг бодвол газрыг нэлээд эрчимтэй ашигладаг онцлогтой. Тухайлбал, тус аймгийн нийт нутаг дэвсгэр улсын дүнд дөнгөж 2.6 хувийг эзэлдэг боловч эрчимтэй ашигладаг газрын төрлүүд, тухайлбал улсын нийт

тариалангийн эргэлтийн талбайн 44 хувь, түүний дотроос үр тариа тариалсан талбайн 42 хувь, төмс, хүнсний ногооны талбайн 15.8 хувь, түүний дотроос өрхийн зориулалттай төмс, хүнсний ногооны талбайн 56 хувийг тариалж байна.

Тэрчлэн ойн сангийн 11 хувь, үүний дотор шилмүүст ба навчит ойн 14 хувь, улсын нөөц хадлангийн талбайн 59 хувь, мөн хотожсон газрын 8 хувийг эзэлдгийн дотор уурхайн газрын 15 хувийг эзэлж байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд тус аймаг газрын нөөцийн ашиглалтын хувьд бусад аймгуудаас илт давуу байгааг харуулж байна.

Хүснэгт 1.2. Газар ашиглалт, төрлөөр мян.га

Газрын ангилал	Улсын дүн	Сэлэнгэ аймаг	Улсын дүнд эзлэх хувь
Нийт нутаг дэвсгэр	156411.6	4115.3	2.6
үүнээс: хөдөө аж ахуйн газар	115232.6	2089.1	1.8
үүнээс: бэлчээр	110929.6	1653.3	1.5
хадлан	1822.8	123.4	6.8
тариалангийн талбай	697.0	304.8	43.7
үүнээс үр тариа	194.3	80.9	41.6
төмс, хүнсний ногоо	19.4	2.0	10.3
тэжээлийн ургамал	10.2	4.0	39.2
уринш	137.6	67.4	49.0
өнжөөсөн талбай	334.2	150.6	45.1
атаржсан талбай	478.4	6.7	1.4
хот, суурины газар	466.0	43.5	9.3
үүнээс: ахуйн зориулалттай төмс, ногооны талбай	2.7	1.5	55.6
зам, шугам сүлжээ	355.4	19.2	5.4
усны сан	967.6	19.4	2.0
ойн сан	14748.1	1607.5	10.9
үүнээс: шилмүүст ба навчит ой	11856.5	1607.5	13.6
ойн бэлчээр	3687.0	401.9	10.9
улсын тусгай хэрэгцээний газар	24641.8	336.6	1.4
үүнээс: бэлчээрт ашиглах боломжтой	20864.8	95.6	0.5
улсын нөөцийн хадлангийн талбай	112.9	66.3	58.7

Сэлэнгэ аймгийн тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг авч үзвэл элэгдэл эвдрэлд орж ашиглах боломжгүй болсон атаржсан талбай бусад аймгуудаас бага байна. Улсын хэмжээнд атаржсан тариалангийн талбай 478 мянган га байхад Сэлэнгэ аймагт 7 мянган га байна. Харин эргэлтийн хөрөнгийн хүрэлцээгүйгээс түр өнжөөгөөд байгаа талбай 151 мянган га байгаа нь улсын дүнгээрх өнжөөсөн талбайн 45 хувийг эзэлж байгаа нь цаашид эргэлтэд оруулах боломжтой тариалангийн талбайн нөөц үлэмж хэмжээтэй байгааг илэрхийлж байна.

Зураг 1.2. Аймгийн хөдөө аж ахуйн газар ашиглалтын эрчимжилт ба үр дүн

дундажаар 800 мянган шоо метр, 2000 онд 520, 2001 онд 593, 2005 онд 400 мянган шоо метр мод бэлтгэж, жил ирэх тутам буурч байгаа нь ой нөхөн сэргэх боломжийг бүрдүүлж байна. Сүүлийн 5 жилд ойн түймэрт 6.4 сая га талбай өртсөний 20 гаруй хувь нь тус аймагт ногдож байна. Сүүлийн жилүүдэд жил бүр 8-10 мянган га талбайд ойн нөхөн сэргээлтийн ажил хийж байгаа нь мод бэлтгэсэн нийт талбайн гуравны нэгийг эзэлж байна.

Улсын хэмжээгээр байгалийн ил задгай усны доорхи ба мөнх цас, мөсөн голын доорхи газар нийт 968 мянган га байгаа бөгөөд түүний 2.0 хувь буюу 19.4 мянган га нь тус аймагт байна.

Тус аймаг байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлүүд болон газар зүйн байрлалаараа улс дотроо сайнд тооцогдоно. Хөдөө аж ахуйн зориулалтын газрууд нь нэг ижил уур амьсгал, хөрс, ургамал, байгалийн нөхцөл бүхий ойт-хээрийн мужид оршдог. Ерөө, Алтанбулаг, Зүүнбүрэн, Сант, Түшиг, Цагааннуур, Хүдэр сумууд нь илүү сайн байгалийн нөхцөлтэй. Энэ давуутай нөхцлийг газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн өмнө буюу 1989 онд Сэлэнгэ аймгийн хүн ам 90.0 мянга, үүнээс хот суурин газарт 53.7 хувь, хөдөөд 46.3 хувь нь амьдарч байсан бол 2002 онд 102.2 мянга болтлоо өсөж, харин 2005 онд 99.8 болж буурч, хот суурин газарт 30.7 хувь нь, хөдөөд 69.3 хувь нь амьдарч байна. Аймгийн төв нь Сүхбаатар хот, нийслэл Улаанбаатар хотоос 335 км зайд оршдог.

Тус аймгийн эдийн засагт төмөр зам, авто зам чухал нөлөө үзүүлдэг. Аймгийн нутаг дундуур Монгол улсыг ОХУ-тай холбосон Монголын төмөр зам, асфальтан авто зам, Дархан хотыг Эрдэнэт хоттой холбосон асфальтан авто зам дайрч өнгөрдөг.

Байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөц. Байгаль нутаг дэвсгэрийн нөхцлийг ялгавартайгаар тогтоохын тулд байгаль-ландшафтын цогц байдлаар нь үнэлэн мужлах явдал чухал юм. Энэ мужлал нь газар орны байгалийн бүхий л нөхцөл буюу уур амьсгал, ус зүй, газрын гадарга, инженер геологийн нөхцөл, хөрс, ургамал, амьтны аймгийг цогцоор нь авч үзэхийг шаарддаг.

Газар нутгийг газар зүйн үүднээс мужлах ажлын эцэст мужлалын зургийг зохиох явдал бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг илрүүлэн тогтоосноор байгаль нутаг дэвсгэрийн нөөц, нөхцлийн байдалд тулгуурласан хөгжлийн чиглэл тогтоогдоно. Ингэснээр газрын нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх, байгалаас шалтгаалах олон янзын нөлөөллийг зохицуулах, түүнчлэн газрын нэгдмэл сангийн ашиглалтын түвшин, цаашдын

төлөвийг тооцох, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад суурь болдог.

Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан физик газар зүй, ландшафт-топологи, ландшафт-экологи, байгалийн мужлалын зургууд янз бүрийн масштабтайгаар зохиогдсон байдаг. Эдгээрийн дотроос байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлөөр нь 4 муж, 20 тойрогт хуваасан мужлал (Г.Пүрэвцэрэн,1989), түүнийг боловсронгуй болгон аж ахуйн ашиглалтын түвшин, цаашдын хандлагыг харгалзсан хувилбар (Монгол улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Газрын өнөөгийн байдал, төлөв байдлын үнэлгээ, 2003)-ыг тус аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад ашиглав.


Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн тойргуудын мужлалаар Сэлэнгэ аймгийн нутаг нь Туулын (Хараа, Ерөө голын сав энд хамаарна) савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог-Х6, Сэлэнгэ-Орхоны хөндийн хээр бүхий тойрог-Х7-д хамаарагдана.

Сэлэнгэ-Орхоны хөндийн хээр бүхий тойрог-Х7 нь Хангай ба Хэнтийн уулт мужийн завсар орших бөгөөд гадаргын байдал нь жигд биш, бэсрэг болон нам уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хослон оршино. Өөрөөр хэлбэл, энэхүү тойрогт Сэлэнгэ, Орхон голуудын адаг орчмын газар хамарна. Сэлэнгэ мөрний хөндий нь өргөн, нарийн хэсгүүдтэй бөгөөд өргөн нь 2-оос 25-30 км хүртэл байдаг. Сэлэнгэ мөрний хөндий нь хээр боловч голыг хүрээлж орших уулс нь зарим газар ой модтой. Сэлэнгэ мөрний хөндийн өргөн газруудад мөрөн олон салаалах бөгөөд энэ нь тус голын өвөрмөц шинж болох шугуйтай олон арлыг бүрдүүлдэг.

Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж нь гүний болоод гадаргын усны нөөц их, манай улсын хамгийн их устай Сэлэнгэ мөрөн түүний цутгал голууд урсах тул голын сүлжээ нягт хөгжсөнөөс гадна байран болон хормойн хурдаст уулсын хажуу, уулс хоорондын хотгорт гүний усны нөөц их байдаг.

Аймгийн байгаль нутаг дэвсгэрийн нөхцлийг авч үзэхдээ дараах чиглэлд голлож анхаарсан болно.

Зураг 1.3. Аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл



Уур амьсгал. Тус аймаг нь Монгол орны тариалангийн гол бүс нутаг юм. 7 дугаар сарын дундаж агаарын температур нь $+17+20^{\circ}\text{C}$, хоногийн дундаж агаарын температур $+10^{\circ}\text{C}$ -ийн заагийг хавар 5 дугаар сарын сүүлч, намар 9 дүгээр сарын дунд үед тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 111-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд $1750-2250^{\circ}\text{C}$ -ийн нийлбэр дулаан хуримтлагддаг. Хаврын цочир хүйтрэл олон жилийн дунджаар 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын эхээр шувтарч, намрын анхны цочир хүйтрэл 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр тохиолддог. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 280 мм, 1960-1990 онуудад дунджаар 277 мм, 1990-2005 онд 274 мм хур тунадас оржээ. Сүүлийн 5 жилд аадар болон хур тунадастай өдрийн тоо 8-аар нэмэгдсэн. Ургамлын ургалтын эхний хагас нь үндсэндээ хур тунадасаар муу хангагддаг. Хавар гандуу, ургамлын ургалтын эхний ба дунд үе шатад хур тунадас орохгүй байх магадлал ихтэй. Олон жилийн ажиглалтаас ургац бууруулж болох гандуу нөхцөл 10 жилийн 2-5-д нь тохиолдож байна. Энэ бүсэд тогтвортой сайн ургац авахын тулд гантай тэмцэх, ургамлын чийг хангамжийг сайжруулахад түлхүү анхаарах шаардлагатай юм.

Олон жилийн цаг агаарын мэдээнээс үзэхэд аймгийн нутагт ургамал ургах хугацаанд 30 хэмээс давж халсан өдрийн тоо 1960-1989 онуудад 13 өдөр, 1990-2005 онд 21 өдөр, 2000-2005 онуудад 28 өдөр болж нэмэгдэж байна.

Зураг 1.4. Сүүлийн жилүүдийн агаарын дундаж температур



Ер нь дэлхийн цаг агаарын дулаарал тус аймгийн нутагт ажиглагдаж байна. Тухайлбал, сүүлийн 45 жилийн хугацаанд жилийн дундаж агаарын температур 1.05°C , дулааны улиралд 1.04°C , хүйтний улиралд 1.53°C -ээр тус тус нэмэгджээ.

Аймгийн нутгийн хөрсний гадаргын жилийн дундаж температур 2°C , сүүлийн 15 жилийн хугацаанд өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад 0.8°C -ээр дулаарсан байна. Аймгийн дундажаар хөрсний 0-50 см-ийн гүний ашигтай нөөц чийгшил багасах хандлагатай байгаа бөгөөд олон жилийн дундаж хэмжээг хөрсний чийг багтаамжийн доод хязгаартай жишиж үзэхэд аймгийн дундажаар дунд зэргийн чийгийн хангамжтай байна. 2002, 2005 онд улаан буудайн бутлалт, голлолтын үе шатанд 20-22 градус дулаан байсан нь бусад жилүүдийнхээс 1-5 градусаар нэмэгдсэн.


2000-2005 оны цаг агаарын мэдээг харьцуулан үзэхэд ургамлын ургах хугацаанд орсон хамгийн бага хур тунадас 2002 онд 105 мм, хамгийн их нь 2004 онд 158 мм орсон байна. Сэлэнгэ аймаг 2004 онд хамгийн их ургац авсан бөгөөд улаанбуудайн ургалтын бутлалт-голлолтын үе шатанд 27.7 мм тунадас орсон, хөрсний 0-20 см гүндэх чийг 30 мм, 50 см гүнд 70 мм, 100 см гүнд 121 мм байсан бол харин хамгийн бага ургац авсан 2002 онд 9.3 мм, 2005 онд маш бага буюу 3.0 мм тунадас орж хөрсний 0-20 см гүнд хөрсний чийг 18 мм, 0-50 см гүнд 48 мм, 0-100 см гүнд 94 мм байжээ.

Хүснэгт 1.3. Сэлэнгэ аймгийн улаанбуудайн ургалтын хугацаанд ажиглагдсан цаг уурын зарим үзүүлэлтүүд (аймгийн төв)


Он	Агаарын дундаж температур	Хур тунадасны нийлбэр, мм	30°-аас дулаан өдрийн тоо	10°-аас дээш дулаан өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо
2000	19.3	141	60	107	
2001	20.2	132	49	88	24
2002	20.3	105	58	92	

2003	18.3	113	19	93	
2004	18.6	158	22	107	
2005	19.0	114	26	105	

Зураг 1.5. Хур тунадас



Зураг 1.6. Хөрсний чийгшил



Ус хангамж. Монгол орны гол мөрөн Төв Азийн үлэмж өндөрлөг, хур чийглэг ихтэй уулсаас эх авч Хойд мөсөн далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд усаа юүлдэг. Монгол улсын 21 аймгийн нутгийг ай саваар барагцаалан хуваавал 10 аймгийн нутгаар Хойд мөсөн далайн ай савын гол мөрөн, 2 аймгийн нутгаар Номхон далайн ай сав, 9 аймгийн нутгаар Төв Азийн гадагш урсгалгүй ай савын голууд урсана. Сэлэнгэ мөрөн түүний цутгалууд нь Хойд мөсөн далайн ай сав газарт хамаарагдана.

Сэлэнгэ аймаг нь усан хангамжийн хувьд сайн, Сэлэнгэ, Орхон, Туул голууд, тэдгээрийн цутгал Хараа, Ерөө голууд болон бусад олон тооны жижиг гол, горхиуд,

Ишгэнт, Шарын цагаан, Цагаан, Гүн нуур зэрэг нууруудтай. Тус аймагт 2962 км нийлбэр урттай 180 гол, горхи, 23 нуур, 137 булаг шанд байдаг.

Сэлэнгэ мөрний усны эрдэсжилт нь 0.3-0.15 гр/л бөгөөд аж ахуйн хэрэгцээ, мал услах, газар тариалангийн усалгаанд тохиромжтой.

Гадаргын усны нийт нөөц нь 3.2 км³ үүнээс ашиглаж болох 1.77 км³ нөөцтэйгээс газрын доорх усны нөөц 0.97 км³ (ул хөрсний), үүнээс ашиглаж болох нөөц нь 0.39 км³.

Тус аймаг 2000 онд нийт 10.2 мянган шоо метр ус хэрэглэсний 45.2 хувийг хүн амын ахуйн хэрэгцээнд, 35.7 хувийг аж үйлдвэрт, 18.9 хувийг мал аж ахуйд, 0.2 хувийг газар тариаланд хэрэглэсэн байна ("Байгаль орчны статистик мэдээ" сэтгүүл, 2000). Тус аймагт газрын доорхи усны 9 том орд байдаг.

Хүснэгт 1.4. Сэлэнгэ аймгийн томоохон голуудын шинж чанар

Голын нэр	Эх авдаг газар	Цутгал	Ус цуглуулгын талбай, км ²	Урт, км	Гүн, м	Урсгалын хурд, м/сек	Дундаж налуу	Жилийн урсацын норм, м ³ /сек	Хуурай үлдэц, мг/л
Сэлэнгэ	Хангайн нуруу	Байгал нуур	425245	152	0,5-5	1-2,5	-	164	0,176
Орхон	Хангайн нуруу	Сэлэнгэ мөрөн	132800	310	0,2-3,5	0,5-3,0	0,004-0,0076	100	0,180
Хараа	Хэнтийн нуруу	Орхон гол	15050	208	0,3-2,5	0,6-1,7	-	5,23	0,154
Ерөө	Хэнтийн нуруу	Орхон гол	11860	199	0,2-3,0	1-2,5	-	35	0,090

Газрын гадарга. Сэлэнгэ аймгийн нутаг нь дунд зэргийн уул нурууд, намхан уулс, уулс хоорондын өргөн, нарийн хөндий, нам хотос бүхий гадаргатай бөгөөд Бүрэн, Жид, Хэнтийн нурууны салбар уулсаас тогтоно.

Тус аймгийн уулсын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 2223 м, хамгийн нам цэг нь Сэлэнгэ мөрний адагт далайн түвшнээс дээш 600 метрт өргөгдсөн. Орхон Сэлэнгийн сав газрын нам хотос, өргөн хөндийнүүд далайн түвшнээс дээш 750-1300 метрт өргөгдсөн байна. Бүрэнхаан, Товхонхаан, Дулаанхаан, Дэлгэрхаан, Баянхаан, Түнхэлийн хөх нуруу, Сонгоол, Ноён уул зэрэг томоохон уул нуруудтай.

Нутгийн хойд хэсэгт ой модоор бүрхэгдсэн Жидийн нурууны салбар уулс, Бүтээлийн нуруу орших ба тэдгээрийн дундуур Сэлэнгэ, Зэлтэрийн голын цутгалууд урсдаг. Зэлтэрийн голын хөндийнүүд нь нарийн бөгөөд сөөг бүхий ургамалтай, намагтай. Харин Сэлэнгэ мөрний хөндийнүүд нь өргөн, далайн түвшнээс дээш 650-870 метрт өргөгдсөн. Энд Цагааннуур, Зүүнбүрэн сумын тариалан, хадлангийн газрууд байрладаг.

Нутгийн зүүн ба зүүн өмнөд хэсэг нь арай өндөрлөг бөгөөд Хэнтий нурууны салбар уулсаар хүрээлэгдэнэ. Уулсын хооронд өргөн, нарийн хөндийнүүд, гол горхиудтай. Уулс нь нэлэнхүйдээ ой модтой.

Аймгийн баруун хэсэг Баруунбүрэн, Сант сумдын нутагт Бүрэнгийн нуруу орших бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1986 метр, шовх оройгүй, тэгшивтэр гадарга бүхий хавтгай орой, хяртай, гадарга нь нэлээд хэрчигдсэн, уул нурууд нь ихэвчлэн гүний хагарлуудын чиглэл дагуу тогтсон байдаг. Орхон голын сав дагуу өргөн хөндийнүүд байх бөгөөд энэ хэсэгт тариалангийн газрууд байрладаг.

Газрын гадаргын хэрчигдлийн онцлогоос хамаарч салхины хүч, чиглэл сумдад харилцан адилгүй байдаг. Хотгор гүдгэрийн хувьд нэн тааламжтай нөхцөлтэй тул манай орны агро-үйлдвэрлэлийн гол бүс болон хөгжиж ирсэн. Түүнчлэн инженер хайгуулын ажил, зам тавих, усжуулалт зэрэг ажилд байгалийн аятай нөхцөл бүхий нутаг болно.

Инженер геологийн нөхцөл. Тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн одоогийн төлөв байдлыг хот, байгуулалтын зориулалтаар үнэлж, суурьшлын бүсийн газрыг зохистой ашиглах чиглэлийг тодорхойлох, аймгийн нутагшилтын тогтолцооны цаашдын хөгжилд таатай нөхцлийг бүрдүүлэх, газар нутгийн хувьд тэлж өргөжих болон шинээр үүсэх хот, суурин газруудад барилга байгууламж барихад хэр тохиромжтойг илрүүлэхэд байгалийн нөхцлийн байдлын судалгаа чухал үүрэгтэй.

Хот байгуулалтын нөхцлөөр нь хот суурингуудыг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромж муутай гэж ангилж үздэг. Энэ үнэлгээгээр тус аймгийн инженер геологийн нөхцлийг хот суурин барьж байгуулахад нэлээд хүндэвтэр гэж тодорхойлсон байна. Үүний зэрэгцээ аймгийн нутаг дэвсгэрийн хүн амын багтаамжийг тооцсоноор 100, 30, 6, 2 мянган хүн амтай хот суурин байх боломжийг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой гэж гаргасан юм.

Хот байгуулалтын үнэлгээгээр газрын чичирхийллийн хүчин зүйлийг 6 ба түүнээс доош баллд хамрагдаж байгаа бол нэн тохиромжтой, 7-8 баллд хязгаарлагдмал тохиромжтой, 9 ба түүнээс дээш баллын ангилалд тохиромжгүй гэж үздэг. Энэ үнэлгээгээр тус аймгийн нийт суурьшлын бүс нутаг газар чичирхийллийн хувьд хязгаарлагдмал тохиромжтой байна.

Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газарт барилга, байгууламж, зам талбай, инженерийн шугам сүлжээг барьж байгуулахад 8 градус хүртэл налуутай бол тохиромжтой, 8-20 хувьд хязгаарлагдмал, 20 градусаас дээш бол тохиромж муутай байдаг бөгөөд энэ хүчин зүйлээр үнэлэхэд аймгийн төв тохиромж муутай, харин бусад хот суурин газрууд нь тохиромжтой зэрэглэлд байна.

Хот байгуулалтын хувьд хөрсний усны түвшин 3 метрээс доош бол нэн тохиромжтой, 1-3 метр бол хязгаарлагдмал тохиромжтой, 1 метрээс дээш бол тохиромж муутай ангилалд тооцогдоно. Сэлэнгэ аймгийн бүх суурин газрууд хот байгуулалтын хувьд нэн тохиромжтой, тохиромжтой ангилалд багтаж байна.

Геоморфологийн нөхцлүүд: хөрсөн бүрхэвч. Сэлэнгэ аймаг нь газар зүйн байршил болон хөрс үүссэн нөхцлөөрөө ойт хээрийн бүсэд хамаарагдана. Нийт нутгаар бүсийн шинж чанар илэрсэн хүрэн хөрсний хэв шинжүүд тархдаг. Тус аймгийн нутагт уулын тайгын ширэгт, цэвдэгт хөрс, уулын тайгын ширэгт, ойн бараан хөрс, уулын хар шороон хөрс, уулын хар хүрэн хөрс, уулын хүрэн хөрс, хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, нугын хүрэн, нугын хужирлаг, мараалаг, аллювийн нугын хөрсний хэв шинжүүд тохиолдоно. Нийт хөрсний дөрөвний нэгийг уулын хар хүрэн, тавны нэгийг уулын тайгын ширэгт, ойн бараан хөрс, мөн тавны нэгийг уулын хар шороон, аллювийн нугын хөрс эзэлдэг.

Ан амьтан. Сэлэнгэ аймгийн нутгийг хамрах байгаль-нутаг дэвсгэрийн нөхцлийн тойрогт 5 ангид хамаарагдах 310 зүйлийн сээр нуруутан амьтад оршин амьдардаг байна. 6 багт хамаарах 58 зүйл одоогоор тэмдэглэгдсэний дотор шавьжтан 5, далавчтан 5, туулайтан 6, мэрэгчтэн 28, махчин 12, туурайтан 5 зүйл байна. Чоно, шилүүс, дорго, булга, мануул, хярс, үнэг, шар үнэг, бор гөрөөс, нохой зээх, модны үен, усчин гэрэлзгэнэ, асганы огодой, улаан ойго, шивэр алагдаага, дагуур огодой, бор туулай зэрэг амьтад тохиолдоно. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад ихээхэн тохиолдох ба хун, галуу, тогоруу, тоодог зэрэг нэлээд олон зүйл шувуу тааралдана. Сэлэнгийн савын бэсрэг уул, ойт хээр хосолсон нутаг дэвсгэрт 4 багийн 163 зүйл шувуу амьдардаг. Эдгээрээс 44 зүйл нь суурин, 157 нь нүүдэллэн өндөглөдөг, 27 нь дайрч өнгөрдөг, өвөл орж ирдэг 8 зүйл байдаг. Монгол улсын улаан номонд орсон шувуудаас цасч дэглий, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, байгалийн нугас, хошуу галуу, байгалийн нугас, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, цэн тогоруу, тоодог, ураг шувуу тааралдана. Түүнчлэн Монгол болон олон улсын бусад хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан 36 зүйл (усны бух, цагаан элэгт, үлэг харцгай, шунгаач харцгай, тарлан сар, шалийн сар, талын сар, бахим бүргэд, тарваж бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, тас, идлэг шонхор, шuumан шонхор, хайргууна шонхор, амарын турамдай шонхор, зээрд шонхор, начин шонхор, хархираа тогоруу, цэн тогоруу, өвөгт тогоруу, хилэн жигүүрт, азийн цууцаль, цэвдгийн ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүтээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, уран шувуу...) амьдардаг. Тус

аймаг агнуурын ач холбогдолтой зүйл шувуудаар баян бөгөөд спорт агнуурыг хөгжүүлэх боломжтой.


Мөлхөгч амьтдаас Шаамар суманд усны могой, Цагаантолгой орчимд нарийн могой амьдардаг. Энэ нь Монгол улсын улаан номонд орсон. Ус намаг бүхий газраар 4 зүйлийн хоёр нутагтан бүртгэгдсэнээс шивэр мэлхий, монгол бах өргөн тохиолдоно. Энэ аймгийн гол мөрөнд 6 баг, 11 овгийн 24 зүйл загас тэмдэглэжээ. Эдгээрээс спорт, агнуурын ач холбогдолтой 14 зүйл загас байгаагийн дотор зэвэг, алгана, цурхай, хайруул, гутаарь элбэг. Мөн Монгол улсын улаан номонд орсон шивэр хилэм, тул зэрэг нэн ховор, ховор загас бий.

Байгаль орчны байдал. 2005 оны байдлаар 17 томоохон хот, сууринд агаарын бохирдлын 20 харуул ажиллаж байна. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолоор орчны цацраг идэвхжилийн хяналт шинжилгээг Үндэсний ус цаг уурын албанд хариуцуулсны дагуу 2000 оны байдлаар орчны цацраг идэвхжилийн 4 өртөө, 32 харуул ажиллаж байна.

Агаарын бохирдлын аюултай эх үүсвэрт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдол нэлээд хувийг эзэлдэг. Энэ нь ихэвчлэн үйлдвэрлэлтэй холбоотой. Дэгдэмхий, хорт хийн бохирдлын эх үүсвэрүүдэд дулааны цахилгаан станц, дулааны станц, халаалтын зуух, тээврийн хэрэгслүүд, гэрийн ба галладаг орон сууцны зуух, үйлдвэрийн газрууд, газрын хөрс, цардаагүй авто зам зэрэг хамаардаг.

Хот суурин газрын агаарын бохирдлын төлөв байдлыг 2004-2005 онд хийгдсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод бохирдолт бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. .

Зураг 1.7. Томоохон хотуудын агаарын бохирдол



Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2005

Сүхбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж азотын давхар ислийн агууламж 4-5 орчим мкг/м³ байгаа ба хүхэрлэг хийн агууламж 24 орчим мкг/м³ байна. Сэлэнгэ аймагт агаар бохирдуулах эх үүсвэр 70 мянга байгаагийн

(тээврийн хэрэгсэл ороод) 90 хувь нь суурин боловч үнс, тоос барих, хий цэвэрлэх төхөөрөмж дөнгөж 6 байна. Тээврийн хэрэгслүүдээс ашиглалтын явцдаа гаргаж байгаа утаа нь амьсгал боогдуулагч, хорт хавдар үүсгэгч хортой бодис ялгаруулж байдаг. Нэг автомашин 100 км явахад хүний жилийн амьсгалах хэмжээний хүчилтөрөгчийг устгаж цагт 3-6 мг/м хорт хий ялгаруулан явган зорчигчийн амьсгалын бүсийг бохирдуулж байдаг. Энэ тооцооноос үзэхэд 1 суудлын автомашин жил дутам дунджаар 4 тн гаруй хүчилтөрөгчийг хий мандлын агаараас авч 800 кг нүүрстөрөгчийн исэл, 40 кг азотын ислүүд 200 кг төрөл бүрийн нүүрстөрөгчийн утаатай хамт агаарт цацдаг байна.

Агаарын бохирдлыг бууруулахад юуны өмнө түлшний бодлого, орчин бохирдуулсны төлбөрийн механизмыг боловсронгуй болгох, байгаль орчинд халгүй техник, технологи нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Мөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа, хууль сахих явдал туйлын чухал. Хууль тогтоомжийг мөрдүүлэх, хяналтын механизмыг боловсронгуй болгох шаардлага ч бас байна.

Агаарын бохирдлыг бууруулах талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгаа нөхцөл байдал үүссэнийг харгалзан байгаль орчинд халгүй технологийг ашиглан шахмал түлшний үйлдвэрийг төв суурин газруудад байгуулах нь зүйтэй. Хотын агаарын бохирдлыг багасгах талаар шахмал түлш үйлдвэрлэн борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ. Гэр хорооллын айл өрхийг шахмал түлшээр хангах арга хэмжээ авч турших ажил хийх шаардлагатай.

Усны бохирдолт. Сэлэнгэ аймгийн ихэнх төв суурин газрууд гол мөрний ойролцоо буюу түүний дагуу байрладаг. Хот суурингаас гарсан бохир усыг эргүүлээд голын усанд, эсвэл хөрсөнд шингээх байдлаар зайлуулдаг. Тухайлбал, бохир усаа Дархан хот, Баянгол сумын төв Хараа голд зохиомол биологийн аргаар цэвэрлэж оруулдаг байхад зарим суурин газар бохир усаа цэвэрлэлгүйгээр шууд голд оруулж байна.

2004 оны хяналт-шинжилгээний дүнгээр бохирдлын индексийг бодож, усны чанарын зэргийг тогтоон 6 ангиллаар үнэлгээ өгсөн байна. Бохирдлын индексийг бодохдоо бохирдуулах бодисын тархац, хор хөнөөлийн зэрэг, бохирдлыг тодорхойлогч болж чадах хүчин зүйлүүдийг нь үндэслэн усан дахь ууссан хүчилтөрөгч, хялбар исэлдэх органик бодис, эрдэс азот болон фосфор, хром, зэс зэрэг металл зэрэг 6-аас доошгүй үзүүлэлтүүдийг сонгон жилийн дундаж агууламжийг нь хүснэгтэд толилуулав.

Хүснэгт 1.5. Усны чанарын үнэлгээ

Гол мөрөн- харуулын нэр	Бохирдлын индекс	Бохирдлын зэрэг	Чанарын ангилал
Сэлэнгэ-Зүүнбүрэн	0.52	II	цэвэр
Орхон-Сүхбаатар	0.68	II	цэвэр
Хараа-Зүүнхараа	1.09	III	бага бохирдолтой
Ерөө-Дулаанхаан	0.58	II	цэвэр
Зэлтэр-Цагааннуур	0.31	II	цэвэр
Хүдэр-Хүдэр	0.37	II	цэвэр
Хиагт-Алтанбулаг	5.61	Y	бохир

Байгаль орчны статистик мэдээлэл, 2002

Тус аймгийн судалгаанд хамрагдсан дээрх голуудын 71.4 хувь нь цэвэр, 14.3 хувь бага бохирдолтой, мөн 14.3 хувь бохирдолтой байна. Ялангуяа хүн ам, үйлдвэрийн нягтрал ихтэй суурин газрын ойролцоох Туул, Ерөө, Хараа, Бороо, Сэлэнгэ, Орхон голууд нь хүний үйл ажиллагааны улмаас усны нөөц нь хомсдох, бохирдох, гольдролыг нь өөрчилснөөс урсгалын хурд саарч, өөрийгээ цэвэршүүлэх чадамж нь буурч байна.


Хүснэгт 1.6. Гол мөрний усан дахь биоидэвхт элемент ба бохирдол

Гол мөрөн- харуул	Ph		Үзүүлэлт									
			БХХ ¹ , мгО/л		ПИЧ ² , мгО/л		NH ₄ , мгО/л		NO ₂ , мгN/л		NO ₃ , мгN/л	
	дундаж	хамгийн их	дундаж	хамгийн их	дундаж	хамгийн их	дундаж	хамгийн их	дундаж	хамгийн их	дундаж	хамгийн их
Сэлэнгэ-Сүхбаатар	7.78	8.61	1.70	3.40	2.0	4.3	0.43	1.08	0.015	0.054	0.31	0.93
Хараа-Зүүнхараа	7.99	8.82	-	-	7.8	26.2	1.29	5.27	0.023	0.058	0.24	0.44
Ерөө-Дулаанхаан	7.50	8.35	-	-	2.5	5.1	0.27	0.72	0.008	0.026	0.42	0.70
Хиагт-Алтанбулаг	7.84	8.20	4.09	6.80	6.3	13.1	1.97	3.70	0.387	1.125	2.14	4.07


Хатуу хог хаягдал. Хатуу хог хаягдлыг ил задгай шатааснаас хорт хийн ялгарлыг нэмэгдүүлж байна. Энэ нь агаарын бохирдол, ялангуяа хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Хатуу хог хаягдал, үүний дотор эмнэлгийн хорт хаягдал, нохойн сэг, амьтны яс, мах зэрэг хаягдлыг ил задгай хаяж байна. Хогийг нэг дор тусгай хашлага, таггүй хогийн цэгүүдэд хаядгаас гадна аль тааралдсан нүх жалганд хаях нь элбэг байна. Химийн бодисын болон бактери агуулсан хог хаягдлууд суурин газарт хаа сайгүй байна. Хог хаягдлын зориулалтын цэг байгуулах, түүнийг техникээр тээвэрлэх асуудалд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах менежмент хангалтгүй байгаагаас хот суурин газрын орчныг бохирдуулж байгааг таслан зогсоох, хүн амын эрүүл мэнд, амьдралын нөхцөлд муугаар нөлөөлөхөөс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Даяаршиж байгаа эдийн засгийн системд Монгол орны онцлогийг хадгалж үлдэхэд тогтвортой хөгжлийн тухай Брутландын комиссоос гаргасан тодорхойлолтыг үндэслэж явч болохгүй нь. Байгалийн баялаг, нар, салхины эрчим хүч зэрэг биосферийн болон экологийн шавхагдашгүй нөөцтэй Сэлэнгэ аймгийн хувьд байгалийн эдийн засагт суурилсан хөгжлийн чиг хандлага нь эдийн засгийн ашигтай, экологийн аюулгүй, нийгмийн дэвшлийг хангасан концепци байх болно. Энэ нь байгалийн нөөцөд тулгуурласан бодлого биш, харин шавхагдах нөөц баялгийг ашигласан хөрөнгийг нийгмийн салбарт түлхүү оруулж хөгжлийн тулгуур болсон хүний нөөц, чадавхийг дээшлүүлэх, үүний тулд 2015 он хүртэл боловсрол, эрүүл мэнд, орон сууц гэсэн ирээдүйд тогтвортой хөгжлийг бүтээж бий болгох, хүнд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Учир нь 2015-2021 онд Монгол улс оюунлаг хөгжлийн загварт орохын тулд ийм суурь нөхцлийг бий болгох нь ядуурлыг бууруулах, хот руу чиглэсэн нүүдлийг багасгах, экологийн тэнцвэрийг алдахгүй байх үндэс болно.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн орчны тогтвортой байдлыг Япон Улстай харьцуулан радар индекс ашиглан 2005 оны байдлаар тооцож үзсэн дүнг аймгийн хөгжилд анхаарах нь ач холбогдолтой. Эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлдэг ихээхэн чухал 5 үзүүлэлтийн индекс дараах байдалтай байна.



■ Í ýãõ¿í ä ííí ääí õ GNI 690 àì .äí èèàð, 2005



■ Í ýãõ¿í ä ííí ääí õ GNI 38980 àì .äí èèàð, 2005

1. Байгаль орчны систем (environmental systems)
2. Амгалан тайван орчин (reducing stress)
3. Хүний амьдралын эмзэг биш байдал (reducing human vulnerability)
4. Нийгэм, институцийн чадамж (social and institutional capacity)
5. Дэлхийд сонирхогдох боломж (global stewardship).

Манай Улсад байгаль орчны таатай нөлөөлөл, амгалан тайван стрессгүй орчин Японыхоос 2 дахин өндөр байгаа нь тэдний шинжлэх ухаан, техникийн өндөр хөгжил, хотжилт, хүн амын нягтралаас шалтгаалж буй биз. Харин хүний амьдралын эмзэг биш байдал 2.5 дахин, нийгэм, институцын чадамж 1.8 дахин доогуур байгаа нь нийгмийн салбарт илүү анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Манай Улсын дэлхийд сонирхогдох боломж Японыхоос 1.4 дахин илүү байгааг бид цаашдын хөгжилдөө мөн ашиглах ёстой.

Дараачийн бүлгүүдэд газрын ангилал тус бүрээр түүний ашиглалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, ойрын 15 жилд ашиглах хэлбэр, эрчимжилт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн асуудлыг авч үзлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БҮСЧЛЭЛ, ХҮН АМЫН
СУУРЬШЛЫН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Эдийн засгийн өсөлт. Сэлэнгэ аймгийн эдийн засгийн одоогийн гол тулгуур салбар нь хөдөө аж ахуй гэдэг нь хүснэгтээс харагдаж байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний тал хувийг энэ салбар эзэлж байна. Цаашид Төмөртэйн орд ашиглагдаж эхэлснээр эдийн засагт бүтцийн өөрчлөлт орох нь мэдээж. Гэвч тус аймгийн хувьд хөдөө аж ахуй чухал салбар байсаар байх болно.

Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт тус аймагт эрчимтэй байна. Энэ үзүүлэлт 2000 оны зэрэгцүүлэх үнээр улсын дүнгээр 3.5 хувь байдаг бол Сэлэнгэ аймагт 4.9 хувь байна. Гэхдээ Сэлэнгэ аймгийн нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл улсын дундажаас доогуур байгааг анхаарах шаардлагатай. Тус аймагт улсын нийт алтны нөөцийн 52%, төмрийн хүдрийн нөөцийн 76% байгаа нь улсаас явуулж буй уул уурхайн бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулахад аймгийн хүн амын амьдралыг сайжруулах боломж байгааг харуулж байна.

Хүснэгт 2.1. Аймгийн эдийн засгийн өсөлтийн гол үзүүлэлтүүд

	2002	2003	2004	2005
Аймгийн хүн ам, мян.хүн	102.2	101.8	100.8	99.8
Дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төг	37.8	33.2	43.1	52.4
Нэг хүнд оногдох ДНБ, оны үнээр, мян.төг	369.9	326.1	427.6	525.1
Нэг хүнд оногдох ДНБ, улсын дундаж	504.6	586.8	758.2	899.3
Улсын дундажтай харьцуулсан хувь	73.3	55.6	56.4	58.4
Аймгийн ДНБ салбараар, %: ХАА	37.3	53.2	48.0	47.2
АҮ, барилга	28.1	6.4	16.4	18.9
Үйлчилгээ	34.6	40.4	35.6	33.9

Бүсчлэл. “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх арга замыг боловсруулж бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах үүднээс төвийн бүсэд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувилалын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр заажээ.

Сэлэнгэ аймгийн ирээдүйн хөгжлийн баримжааг тогтооход дараах давуу талуудыг харгалзан үзэж оновчтой ашиглах нь зүйтэй.

1. Унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн байгалийн өвөрмөц цогцолбор, ховор амьтан ургамлын төрөл, зүйл бүхий өргөн уудам газар нутаг,
2. Тариалангийн зориулалтаар ашиглаж болох үржил шимтэй газрын харьцангуй их нөөц,
3. Байгаль орчиндоо тохирсон дэлхийд ховор бэлчээрийн уламжлалт мал аж ахуй, түүнд зохицсон нүүдлийн амьдралын өвөрмөц хэв маяг, соёл иргэншил,
4. Алт, төмөр, нүүрсний баялаг нөөц,
5. Хил залгаа ОХУ-ын зах зээлийн багтаамжийг ашиглах боломж,
6. Дэд бүтцийн сайн хангамж зэрэг болно.

Сэлэнгэ аймгийн дэд бүтцийн давуутай талыг ашиглан Ази, Европыг дамжсан улс хоорондын худалдаа, тээврийн харилцааны гол салбар болгох зорилтыг тавьж Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлээр Азийн авто болон төмөр замын олон улсын сүлжээнд холбогдоно. Одоо ажиллаж буй уул уурхайн үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэн, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, экспортод чиглэсэн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Ингэснээр үйлдвэржилтийн шинэ бүсийг даган хот суурин газар бий болно.

Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийн дагуу нутаг дэвсгэрийг цаашдын хөгжлийн хандлагаар нь 5 бүсэд хамааруулан авч үзсэн байна (Аймгийн хөгжлийн бүсчлэл, хүн амын суурьшлын газрын байршил, төлөвлөлтийн зураг). Үүнд:

БЭЛЧИРИЙН БҮСЭД Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумууд, Дулаанхаан орно. Бүсийн төв нь Сүхбаатар юм. Энэ бүсэд аж үйлдвэр, бизнес, дэд бүтэц идэвхтэй хөгжихөөс гадна гадаад худалдаа, усалгаатай тариалан, эрчимжсэн мал аж ахуй, загасны аж ахуй, аялал жуулчлал түлхүү хөгжинө. Аймагтаа дээд ба мэргэжлийн боловсрол хөгжүүлэх төв нь болно.

ЕРӨӨГИЙН БҮСЭД Ерөө, Хүдэр, Жавхлант сумууд, шинээр бий болох Төмөртэй суурин орно. Бүсийн төв нь Ерөө сумын төв юм. Энэ бүсэд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, бэлчээрийн ба эрчимсэн мал аж ахуй, усалгаатай ба богарын тариалан, модон эдлэлийн ба байгалийн баялаг ашиглах үйлдвэрлэл, аялал жуулчлал түлхүү хөгжинө. Энд 30 мянга орчим хүн амтай Төмөртэй суурин шинээр байгуулагдах төлөвтэй байна.

СЭЛЭНГИЙН БҮСЭД Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн сумууд ордог. Бүсийн төв нь Цагааннуур сумын төв юм. Энэ бүсэд усалгаатай ба богарын тариалан, бэлчээрийн ба эрчимжсэн мал аж ахуй, уул уурхай, байгалийн баялаг ашиглах

үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт сувиллын салбар түлхүү хөгжинө. Тус бүсэд 5 мянга орчим хүн амтай Улаан-Овоо тосгон шинээр байгуулагдах төлөвтэй байна.

ОРХОНЫ БҮСЭД Сайхан, Орхонтуул, Баруунбүрэн, Орхон, Сант, Хушаат сумууд, Хөтөл хот ордог. Бүсийн төв нь Сайхан сумын төв юм. Энэ бүсэд барилгын материалын үйлдвэрлэл, бэлчээрийн ба эрчимсэн мал аж ахуй, усалгаатай ба богарын тариалан, уул уурхай, байгалийн баялаг ашиглах үйлдвэрлэл, аялал жуулчлал түлхүү хөгжинө.

ХАРААГИЙН БҮСЭД Баянгол, Мандал сумууд, Зүүнхараа хот, Түнхэл тосгон ордог. Бүсийн төв нь Зүүнхараа юм. Энэ бүсэд эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай ба богарын тариалан, уул уурхай, модон эдлэлийн ба байгалийн баялаг ашиглах үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт сувиллын салбар түлхүү хөгжинө.

Хүн ам зүй. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх 15 жилийн хугацаанд Сэлэнгэ аймгийн хүн амын өсөлтийн ерөнхий хандлага, хүн ам зүйн өөрчлөлтийг урьдчилан төсөөлөх, энэ үндсэн дээр ажиллах хүч, нийгмийн үйлчилгээний хөгжлийн ерөнхий өөрчлөлтийг гаргах зорилгоор 1989-2005 оны хүн амын тооллогын материал дээр үндэслэн Сэлэнгэ аймгийн хүн амын өсөлт, нас хүйсний бүтэц, төрөлт, байршил, шилжилт, ажил эрхлэлт, хөдөлмөрийн нөөц, боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээний зарим үзүүлэлтийг 2021 он хүртэл математик загварчлалын аргаар тооцоолов.

Сэлэнгэ аймагт 2005 оны байдлаар 99.8 мянган хүн амьдарч байгаа нь Монгол улсын нийт хүн амын 3.9 хувь юм. Тус аймгийн хот, суурины газар 43450 га байгаа бөгөөд 846 га нь барилга байгууламжийн доорхи газар, 4227 га нь гэр хорооллын газар, 23354.га нь нийтийн эзэмшлийн газар, 327 га нь үйлдвэр, 14696 га нь уурхайн газар байна.

Хүн амын тооллогын дүн мэдээнээс харахад сүүлийн 16 жилд (1989-2005) Сэлэнгэ аймгийн хүн ам 9 мянган хүнээр нэмэгдсэн дүнтэй байгаа боловч 2002-2005 онуудад 2.4 мянган хүнээр багассан байна. Гэхдээ тус аймгийн хүн амын жирийн өсөлтөөс гадна шинээр байгуулагдах үйлдвэр, уурхайн сууринг дагаж хүн амын тоо нэмэгдэж, 2021 он гэхэд 160 гаруй мянган хүнтэй болох прогноз гарч байна.

Хүснэгт 2.2. Хүн ам, хот суурины газрын прогноз

Хүн амын жирийн өсөлт, мян.хүн	Шинээр байгуулагдах сууринг дагах механик өсөлт	Нийт хүн ам, мян.хүн	Барилга, байгууламжийн доорх газар, га	Нийтийн эзэмшлийн газар, га	Үйлдвэрийн газар, га	Уурхайн газар	Гэр хорооллын газар, га	Хот суурины газрын дүн, га
--------------------------------	---	----------------------	--	-----------------------------	----------------------	---------------	-------------------------	----------------------------

	1	2	3=1+2	4	5	6	7	8	9
2005	99.8		99.8	846	23354	327	14696	4227	43450
2006	101.0		101.0	856	23641	327	16166	4142	45133
2007	102.3	1.0	103.3	867	23932	800	17782	4060	47441
2008	103.5	12.0	115.5	878	24226	1300	19560	3978	49943
2009	104.8	18.0	122.8	888	24524	1800	21516	3899	52628
2010	106.1	24.0	130.1	899	24826	2300	23668	3821	55514
2011	107.4	30.0	137.4	910	25131	2800	26035	3744	58621
2012	108.7	35.0	143.7	922	25441	2800	28638	3670	61470
2013	110.1	35.4	145.5	933	25753	2800	31502	3596	64585
2014	111.4	35.9	147.3	944	26070	2800	34652	3524	67991
2015	112.8	36.3	149.1	956	26391	2800	38118	3454	71718
2016	114.2	36.8	150.9	968	26715	2800	40024	3385	73891
2017	115.6	37.2	152.8	980	27044	2800	42025	3317	76165
2018	117.0	37.7	154.7	992	27377	2800	44126	3251	78545
2019	118.4	38.1	156.6	1004	27713	2800	46332	3186	81035
2020	119.9	38.6	158.5	1016	28054	2800	48649	3122	83641
2021	121.4	39.1	160.4	1029	28399	2800	51081	3059	86369

Аймгийн хүн амын тоог хот, хөдөөгийн харьцаагаар авч үзвэл 2000 оноос хойш хөдөөд суурьших хүний тоо ихээр нэмэгдсэн нь улсын хэмжээнд ажиглагдаж байгаа ерөнхий хандлагаас эсрэгээр байна. Улсын хэмжээнд хот суурин газар амьдардаг хүмүүсийн тоо жил тутам нэмэгдэж байхад тус аймагт хөдөөд амьдардаг хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа нь нэн сайшаалтай юм. Одоогийн байдлаар аймгийн суурин газарт хүн амын 30.7 %, хөдөөд 69.3 % нь амьдарч байна.

Хүснэгт 2.3. Хүн амын бүтэц

	Сэлэнгэ аймаг		Улсын дүн	
	хот	хөдөө	хот	хөдөө
2002	49.3	50.7	57.4	42.6
2003	31.8	68.2	58.5	41.5
2004	28.2	71.8	59.1	40.9
2005	30.7	69.3	60.2	39.8

Хөдөөд амьдрах хүмүүсийн тоо нэмэгдсэн нь алслагдсан аймгуудаас нүүн ирж суурьших хүн амын тоо нэмэгдсэн, мөн хөдөөд амьдарч мал аж ахуй, газар тариалан эрхлэх сонирхол нэмэгдсэнээр тайлбарлаж болох юм.

Хүн амын нягтрал нь улсын хэмжээнд 1 км² нутаг дэвсгэрт дунджаар 1.5 хүн байдаг бол, Сэлэнгэ аймагт 1 км² –д 2.4 хүн ногдож байна. Хүн амын нягтшил хамгийн шигүү суудаг сум нь Сүхбаатар хот бөгөөд нэг хавтгай дөрвөлжин километр 423 хүн, Сайхан суманд 6 хүн, Мандал суманд 5 хүн амьдардаг байна. Нийгмийн амьдралын хүрээнд гарч байгаа олон өөрчлөлтүүд, зах зээлийн эдийн засаг нь хүмүүсийн амьдралд шинээр сэтгэх, амьдрах арга замыг эрэлхийлэхэд хүргэж байна.

Санаа нийлсэн хамт олон ах дүү, гэр бүлүүд хоршоолол, фермерийн аж ахуй, хувийн үйлдвэр зохион байгуулж, хамгийн хэрэгцээтэй, ашигтай ургамал тариалах, өвс, тэжээл бэлтгэх, хүн ам олноор суурьшсан болон зам дагуух газруудад зоогийн газар, зочид буудал, засварын газар ажиллуулах, төлбөрт үйлчилгээ явуулах зэрэг үйлдвэрлэл, жижиг бизнес эрхлэх болно.

Ажиллах хүчээр хэр зэрэг хангагдсан байгаа нь нийгмийн үйлчилгээний хэрэгцээг тооцоход чухал суурь болдог. Хүснэгтээс харахад тус аймгийн эдийн засгийн идэвхтэй насны хүн ам 36 мянган хүн байгаа нь 2002 оноос даруй 300 хүнээр нэмэгдсэн байна. Үүнээс одоо ажил эрхэлж байгаа нь 35 мянга, үүнээс төрийн албан хаагч аймгийн хэмжээнд 4.1 мянга байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүд 1176 байгаагаас дээд боловсролтой 134, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн 56, тусгай дунд боловсролтой 112, мэргэжилгүй 874 хүн ажил эрхлээгүй байна. Нийгмийн үйлчилгээний хүрээ, хэрэгцээ нэмэгдэхэд ажиллах хүчний хангамж, нийлүүлэлт өсөх зүй тогтолтой. Иймээс Сэлэнгэ аймагт материаллаг үйлдвэрлэлийн салбарт ажиллах нөөц бололцоо бүхий хөдөлмөрийн насны хүн ам хангалттай байна.

Хүснэгт 2.4. Ажил эрхлэлтийн байдал


	2002	2003	2004	2005
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	35800	37300	35300	36100
Ажиллагсадын тоо	35000	36400	35000	34900
Төрийн албан хаагч		4100	4100	4100
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	822	864	1258	1176
Дээд боловсролтой, ажилгүйчүүд	75	125	121	134
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн, ажилгүйчүүд	28	67	50	56
Тусгай дунд боловсролтой, ажилгүйчүүд	71	92	100	112
Мэргэжилгүй, ажилгүйчүүд	648	580	987	874

Төрөөс хүн амыг нэмэгдүүлэх, төрөлтийг дэмжих бодлого барьж байгаа хэдий ч зах зээлийн нөхцлөөс шалтгаалж төрөлтийн түвшин буурах хандлагатай болсон. Сэлэнгэ аймагт нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн тоо 2000 онд 18 байсан бол 2005 онд буурсаар 17 болсон байна. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн, мөн тусгай болон их дээд суралцагсдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нэмэгдсэн зэргээс үүдэн гэрлэх нас аажмаар хойшилсон, нийгмийн идэвхтэй амьдралд шимтсэн эмэгтэйчүүд олон хүүхэдтэй байх сонирхол, нөхцөл буурсан зэрэг нь төрөлтөд нөлөөлсөн. Улсын хэмжээнд 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшинг авч үзвэл Улаанбаатар, төвийн бүсийн аймгууд (Дархан-Уул, Булган, Төв, Сэлэнгэ)-д улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

2005 онд тус аймагт 1708 хүүхэд төрсний 838 буюу 49.0 хувь нь эмэгтэй хүүхэд байв. Шинээр төрсөн хүүхдийн 59 хувь нь хотод, 41 хувь нь хөдөөд байлаа. Төрөлтийн нийлбэр итгэлцүүр 2005 оны байдлаар хөдөө (сумын төвөөс цааш)-д аймаг, сумын төвийг бодвол бага байна.

Улсын хэмжээнд хүн амын дундаж наслалт 2002 оны байдлаар 63.5 байсан бол 2005 онд 65.2 болтлоо өссөн бол, Сэлэнгэ аймагт 2002 онд 64.6-аас 2005 онд 66.1 болж өссөн нь улсын дундажаас дээгүүр байна.

Зураг 2.1. Дундаж наслалт



Хүн амын тооллогын 1989-2005 оны мэдээн дээр тулгуурлан Сэлэнгэ аймгийн хүн амын хэтийн төлөвийг 2021 он хүртэл тодорхойлоход 160 гаруй мянган хүнтэй болохоор байна. Хүн амын өсөлтөд ердийн өсөлт зонхилох үүрэгтэй байх боловч үйлдвэржилттэй уялдан хүн амын механик өсөлт нэмэгдэх хандлагатай юм. Ашигт малтмалын нөөцөд тулгуурласан уул уурхайн үйлдвэрлэл хөгжихийн хэрээр түүнийг даган хүн амын суурьшил шинээр бий болно. Бороогийн алтны үндсэн ордыг түшиглүүлэн жилд 4 тонн алт олборлох уул уурхайн үйлдвэр байгуулж байна. Баянгол сумын нутаг дахь алтны үндсэн ордыг ашиглах уул уурхайн үйлдвэрийн эхний ээлж ашиглалтад орж уул уурхайн баяжуулах үйлдвэр байгуулан ажиллаж байна. Мөн Хүдэр, Ерөө сумын нутгийг дамнан орших Төмөртэйн төмрийн ордыг ашиглахад 110 км төмөр зам тавьж 30-аад мянган хүнтэй тосгон шинээр буй болно. Энэ нутагт Төмөртэйн төмрийн ордын бүс газар гэсэн үйлдвэржилтийн шинэ бүс газар 2010 онд бий болно. Түүнчлэн Түшиг суманд нүүрсний шинэ уурхай ашиглалтад орж, түүнийг дагасан 5 орчим мянган хүнтэй Улаан-Овоо тосгон бий болно.

Хүснэгт 2.5. Сэлэнгэ аймгийн хот байгуулалтын нөхцлийн үнэлгээ

Хот, суурины нэр	Усан хангамж	Газар чичирхийлэл, балл	Ул хөрсний норматив ачаалал, кг/см ²	Хөрсний усны түвшин, м	Газрын гадаргын налуулал, %	Барилгын уур амьсгалын бүс	Далайн түвшнээс өргөгдсөн байдал, м	Бусад нөхцөл
Сүхбаатар	+	7	0.68	3.1-5.6	20-24	IV	500-1000	гуу, жалга, элс
Алтанбулаг	+	7	2.5-3.0	2.6-2.8	3-5	III	1080-1116	
Шаамар	+	7		1-2	8	III	1188-1206	намаг, элс
Хонд	+	7				III		
Дулаанхаан	+	7		2.8-3.0	3.0-6.0	III	500-1000	
Зүүнбүрэн	+	6		3	3	III	600-1452	үер хам
Цагааннуур	+	7-8		1.4-5.0	2.0-3.0	III	750-800	
Зэлтэр	+	7-8		2.0-3.0	8	III	1085-1087	
Дархан	+	7		0.5-10.0	5	II	690-740	үер хам
Салхит	+	7			3	II	500-1000	
Хонгор	+	7			3	II	500-1000	
Баянхараат	+	7				II	500-1000	
Шарын гол	+	7		11.0	8	II	913-925	гуу, жалга
Орхон хороо	+	7		3.0-4.0	3	II	500-1000	
Ерөө	+	7		7.0-10.0	8	II	660	
Хүдэр	+	7		2.0-3.5	0.01	II	500-1000	
Бугант	+	7		6.0-10.0	8		1500-2000	
Хөтөл	+	7	1.0-3.0	10	1.0-2.0	II	800-1000	
Орхон	+	7		0.65-4.5	2.0-5.0	II	770	
Орхонтуул	+	7		8.0-10.0		II	780-810	
Номгон	+	7			3.0-5.0	II	1088	
Сант	+	7		5.0-8.0		II	500-1000	
Баруунбүрэн	+	7		2.0-7.0	5	II	820	
Зүүнхараа	+	7			8	II	850-1000	
Мандал	+	7		8.0		II	1500	
Баянгол	+	7			8	II	1174-1206	
Түнхэл	+	7			2.8	II	1500	

Эдийн засгийн чөлөөт бүсийг Улаанбаатар, Алтанбулаг, Замын Үүд, Цагааннуур, Багахангайд байгуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эхний ээлжинд Алтанбулагт 520 га, Замын-Үүдэд 840 га талбайг чөлөөт бүс байгуулахад тохиромжтой гэж үзсэн юм. Улс орны хөгжилд чөлөөт бүсийн ач холбогдол асар өндөр, түүгээр дамжин эдийн засгийн өндөр хөгжилд хүрч болохыг Хятад Улс (Гуанжоу, Тяньжин г.м.) харуулсан.

Аймгийн хот, суурин байгуулалтын үйл ажиллагааг орон нутгийн байгаль орчны нөхцөл, иргэдийн үүсгэл санаачлагад тулгуурлан нэгдсэн бодлоготой явуулах шаардлагатай.

Хүн ам, суурьшлын газрын төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам:

- Аймгаа бүсчлэн хөгжүүлэх,
- Аймгийн төв, бүсийн болон сумдын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг олон нийтийн оролцоотой шинэчилэн боловсруулах ажлыг зохион байгуулах,

- Бүх суурин газрын гэр хорооллын эмх цэгц, нийтийн эдэлбэр газрын тохижилтыг сайжруулах, гэр хорооллыг багасгах,
- Хүн амын тогтвор суурьшлыг хангах,
- Шинээр буй болж байгаа тосгон сууринд хүн амын төвлөрлийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх,
- Газрын болон байгаль орчны албадыг шинэ техник, технологиор ханган, газрын харилцааны талаарх мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлган, үйлчилгээг шуурхай болгож, газрыг айл өрх бүрд үнэгүй өмчлүүлэх ажлыг хуулийн заалтанд тохируулан зохион байгуулах,
- Барилга, хот байгуулалт, газар өмчлөх, эзэмших, ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг аймгийн хэмжээнд бий болгох,
- Аймгийн төв, бүх сумдын төвүүдийн суурьшлын бүс газрын хил заагийг бусад зориулалтын ангиллын газраас нарийвчлан зааглаж тогтоох,
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах,
- Сум, багийн төв, уурхайн суурин газруудын орчмын хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах, талхлагдалт, элэгдэл эвдрэл, автоген, техногенээс хамгаалах,
- Монгол улсын Засгийн газрын “40000 айлын орон сууц барих” хөтөлбөрийг аймгийн төв, сумын төвүүдэд хэрэгжүүлэх,
- Хямд төсөр сүрлэн орон сууцаар хангах нөхцөл бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүтцийн газрын хэмжээ. Газрын нэгдмэл сангийн энэ ангиллын газарт автозам, төмөр зам, агаарын тээврийн газар, шугам сүлжээний доорх талбай хамаарна.

Сэлэнгэ аймаг нь нийт 19177 га дэд бүтцийн газартай, үүнээс автозамын газар 12564 га, төмөр замын газар 1117 га, агаарын тээврийн газар 331 га, шугам сүлжээний доорх талбай 5462 га байна. Шугам сүлжээний доорх талбайн 89.5 хувийг цахилгааны шугамын доорх талбай, 9.3 хувийг холбооны шугамын газар, 0.3 хувийг ус, дулаан дамжуулах хоолойн доорх талбай эзэлж байна.

Хүснэгт 3.1. Дэд бүтцийн газрын хэмжээ, га

Сумын нэр	Автозамын газар	Төмөр замын газар	Агаарын тээврийн газар	Шугам сүлжээний доорх талбай	Дэд бүтцийн газрын дүн
Алтанбулаг	556		35	210	801
Баруунбүрэн	745	61		294	1101
Баянгол	1196	189		588	1974
Ерөө	1341			457	1798
Жавхлант	650			384	1034
Зүүнбүрэн	783			151	934
Мандал	787	141		305	1233
Орхон	970	134		507	1610
Орхонтуул	886	242		740	1868
Сайхан	765	119		507	1391
Сант	654			191	845
Сүхбаатар	48	32		53	133
Түшиг	470			67	537
Хушаат	650	0		81	731
Хүдэр	529			133	662
Цагааннуур	842			323	1165
Шаамар	692	199		416	1307
Аймгийн дүн	12564	1117	35	5406	19122

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 09 дүгээр тогтоолоор “Мянганы зам болон дэд бүтцийн босоо чиглэлийн замын чиглэл” батлагдсан билээ. Энэхүү тогтоолд: Монгол улс хөрш зэргэлдээ болон бүс нутгийн орнуудтай хамгийн дөт замаар харьцах, далайд гарцтай болох боломж бүрдүүлэх, дотоодын дэд бүтцийн нэгдмэл сүлжээ бий болгохоор зааж, Монгол улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг, дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлүүдийг баталжээ.

Дэд бүтцийн хэвтээ болон босоо тэнхлэгүүдийг нутаг дэвсгэрийн болон салбарын дараах бүрдэл хэсгүүдтэй байхаар зохион байгуулахыг зохистой гэж үзсэн. Хэвтээ тэнхлэг нь аймаг, сум, нийслэл, хот тосгон бүсийн төвүүд, худалдаа эдийн засгийн чөлөөт бүсүүд, ашигт малтмал олборлолт, боловсруулалтын болон аялал

жуулчлалын бүс нутгууд, түргэн хөгжих ирээдүйтэй бусад бүс нутаг, тэдгээрийг улс орны дотоод, гадаад зах зээлтэй холбосон эрчим хүч, зам харилцаа, орчин үеийн холбоо мэдээлэл, бөөний худалдааны сүлжээг хамарсан нутаг дэвсгэрийн бүрдэл хэсгүүдтэй. Энэ тэнхлэгт хамрагдах бүс нутгуудад Зүүн хойд Азийг Япон, Солонгос, Хятадын зүүн хойд хэсэг, ОХУ-ын Алс дорнодыг баруун тийш Казахстан, Ойрхи дорнод, цаашид Европын орнуудын зах зээлтэй холбох, мөн зүүн хойд Азиас хүнд даацын авто машинуудаар хийх контейнерийн тээвэр хөгжүүлэх ач холбогдолтой.

Босоо тэнхлэг нь хувийн хэвшилд түшиглэн, зах зээлд өрсөлдөн тогтвортой хөгжих чадвар бүхий аж ахуй нэгж байгууллагын тогтолцоо, тэдгээрийн дотоод, гадаад хүрээний үйлдвэрлэл, үйлчилгээ, технологийн дагналт хоршилт, банк, санхүү, удирдлага, төлөвлөлт, бүртгэл мэдээлэл, тооцооллын урсгал, хүрээлэн байгаа орчны зохилдоог хамарсан салбарын бүрдэл хэсгүүдтэй. Энэ тэнхлэгт хамрагдах нутгууд нь эдийн засгийн 4 бүсийг хойд, урд хөршийн зах зээлтэй холбох, мөн улс дотроо хангай, говийн аймгуудыг холбох, ОХУ, БНХАУ-ын ачаа тээврийг богино замаар дамжин өнгөрүүлэх ач холбогдолтой.

Эрчим хүчний газар ашиглалт. Монгол Улсын эрчим хүчний салбар нь тус улсын дэд бүтэц, эдийн засаг нийгмийн чухал хэсэг бөгөөд эрчим хүчний салбарын үйл ажиллагаанаас бусад салбарын үйл ажиллагаа ихээхэн шалтгаалдаг. Сэлэнгэ аймгийн хувьд эрчим хүчээр харьцангуй сайн хангагдсан боловч экологийн хувьд ээлтэй эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлэхэд ус, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах зүй ёсны шаардлага бий.

Одоогийн байдлаар Түшиг-Зүүнбүрэн, Баруунбүрэн-Орхоны 20 кВт-ын шугам, Сүхбаатар-Алтанбулаг, Сүхбаатар-Зүүнбүрэн, Дархан-Хушаат, Орхон-Сант, Ерөө-Хүдэрийн 35 кВт-ын шугам, Сүхбаатар-Орхон, Ерөө-уулзвар, Дархан-Баянгол-Зүүнхараа-Улаанбаатар, Сүхбаатар-ОХУ-ын 110 кВт-ын шугам, Сүхбаатар-Эрдэнэт, Сүхбаатар-Улаанбаатар, Эрдэнэт-Улаанбаатар, Сүхбаатар-ОХУ-ын 220 кВт-ын шугам үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид Зүүнбүрэнгээс Улаан-Овооруу, Дарханаас Төмөртэйрүү шинэ шугам татах шаардлагатай болно. Энэ нь одоо байгаа хүчин чадлын 10-аад хувьтай тэнцэнэ.

Замын газрын ашиглалт. Монгол Улсын Их Хурлын “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай” 2001 оны 09 тоот тогтоолоор дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийг, Алтанбулагийн боомтоос Сүхбаатар- Дархан-Улаанбаатар-Чойрыг дамжин Мандалговь-Тавантолгой-Даланзадгадыг хамран Сайншанд, Замын үүдийн боомтоор гарах тэнхлэг байна гэж баталсан. Энэ

чиглэлийн дагуух газрууд Азийн авто болон төмөр замын олон улсын сүлжээнд холбогдож, Ази-Европыг дамжсан улс хоорондын худалдаа, тээврийн харилцааны гол салбар болгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Хүснэгт 3.2. Дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл

Босоо тэнхлэгийн замын чиглэл	Хамрагдах нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.км ²	Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.км ²	Хамрагдах засаг захиргааны нэгжийн тоо	Аймгуудын нийт хүн амын тоо, мян.хүн	Үйлчлэх хүрээний хүн, ам, мян.хүн	Аймгуудын малын тоо, мян.толгой	Үйлчлэх хүрээний малын тоо, мян.толгой	Аймгуудын ажилгүйдлийн тоо	Үйлчлэх хүрээний ажилгүйдлийн тоо
Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар-Сайншанд-Замын Үүд	309.6	203.1	60	1030.7	959.1	6432	2714.3	12045	5083

Сүхбаатар-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн замын үйлчлэх хүрээнд шинээр Сэлэнгэ аймгийн хөдөөгийн 9 төв суурингууд хамрагдаж байгаа бөгөөд энэ хүрээнд 43 орчим мянган хүн үйлчлүүлэх боломжтой болох юм. Энэ чиглэлд шинээр 643 км хөнгөвчилсэн хар хучилттай зам тавигдах ба замын нийт төсөвт өртөг 85 сая ам. доллар болно.

Аймгийн доторх замыг сайжруулахаар Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрт заасан байна. Энэ нь Ерөө-Хүдэр чиглэлийн 180 км, Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшигийн 134 км, Хушаат чиглэлийн хайрган хучилттай замыг шинэчилж ба шинээр тавих болно. Баянгол-Мандал, Мандал-0410 чиглэлийн замыг эхлээд хайрган хучилттай, дараа нь асфальтан хучилттай болгоно. Мөн Дулаанхааны уулзвараас Төмөртэй хүртэл 100 км замыг асфальтан хучилттай болгоно.

Мөн Сүхбаатар хот, Алтанбулаг сумын төвийн ойролцоо онгоцны буудал, Сэлэнгэ мөрний дагуу Сүхбаатар хот, Зүүнбүрэн сумын төвд, Орхон мөрний дагуу Орхон сумын төв, Дулаанхаан тосгонд аялал жуулчлалын зориулалттай усан онгоцны зогсоол шинээр байгуулна.

Дулаанхаан-Ерөө-Төмөртэй хүртэл 100 км, Шаамар-Түшиг-Улаан-Овоо хүртэл 140 км төмөр зам барина. Мөн хэд хэдэн өртөөг тохижуулах, тоноглох, шинээр байгуулах ажлыг төлөвлөж байна.

Мэдээлэл холбооны газрын ашиглалт. Сэлэнгэ аймгийн цахилгаан холбооны суурь сүлжээ нь Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийг холбосон 2100 гаруй км

аналог, 900 шахам км тоон технологийн радио релейний шугам, 3000 гаруй км шилэн кабелийн сүлжээ болон аймгийн төв, сум, суурин газруудыг холбосон 30 шахам мянган км агаарын шугам, сансрын холбооны 21 ВСАТ станц (зурвасын өргөн 10 Мбит), олон улсын сансрын холбооны газрын Интерсат станц, нийт 135.2 гаруй мянган телефон цэгийн багтаамж бүхий 332 холболтын байгууламжид багтаж байна.

Сэлэнгэ аймаг нь Мобиком, Скайтел, Юнител үүрэн телефон холбооны үйлчилгээнд хамрагдсан. Манай улс хот хоорондын сүлжээнд шилэн кабелийг 2000 оноос анх ашиглаж эхлэхэд Сэлэнгэ аймаг холбогджээ. Энэ шилэн кабель нь 1402 км урт бөгөөд Монголын төмөр зам дагуу, гол шугам нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг өртөөнөөс, Дорноговь аймгийн Замын-Үүд өртөө хүртэл, салбар шугам нь Салхит-Орхон, Багахангай-Багануур хооронд үргэлжилдэг.

Дэд бүтцийн газрын төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам:

1. Эрчим хүч, харилцаа холбоо, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтцийн давуутай талуудыг эрчимжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож хөгжүүлэх,
2. Хөдөөд эрчим хүч, зам тээвэр, холбоо, мэдээллийн технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх үндсэн дээр дэд бүтцийн нэгдсэн сүлжээ бий болгох (бүх сум, суурин газруудын цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг түлш бага зарцуулдаг, ашиглалтын зардал багатай, бага оврын эх үүсвэрээр солих),
3. Аймаг, сумдыг эрчим хүчээр найдвартай хангах, аюулгүй байдлыг баталгаатай болгох,
4. Бүс нутгийг дотоод, гадаад зах зээлтэй дэд бүтцийн сүлжээгээр холбож, нутаг дэвсгэрийн хөгжлийн боломжийг хангах,
5. Зам барих, дэд бүтэц хөгжүүлэх үйл ажиллагаанд байгаль орчинд ээлтэй менежментийг хөгжүүлэх,
6. Төв суурин газрын агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын төвд бага чадлын нам даралтын зуух ашиглуулахгүй байх бодлого барина.
7. Баянгол сумаас Мандал сумын төв, Дулаанхааны уулзвараас Төмөртэй хүртэл хатуу хучилттай замыг барьж дуусгах,
8. Экологийн тэнцвэрийг хангаж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах шаардлагад зохицуулан тээврийн хэрэгсэл, шатахууны төрлийг зөв сонгон тогтоох,
9. Сэлэнгэ, Орхон, Хараа, Ерөө голоор жижиг оврын усан тээврийн хэрэгслийг аялал жуулчлалд ашиглах,

10. Аймгийн төв, сум, суурин газруудад хүн тээврийн үйлчилгээг сайжруулах, автобусны паркыг шинэчлэх зэрэг арга хэмжээ авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
УСАН САНГИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Усан сан бүхий газрын хэмжээ. Газрын нэгдмэл сангийн энэ ангиллын газарт нуур, цөөрөм, тойром, мөрөн гол, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газар хамаарна.

Сэлэнгэ аймаг нь нийт 19442 га усан сан бүхий газартай, үүнээс гол мөрний эзлэх газар 18222 га, нуур, цөөрмийн эзлэх газар 889 га, горхи, булаг, шандны эзлэх газар 331 га байна.

Хүснэгт 4.1. Усны сангийн газар, га

Сумын нэр	Гол мөрний доорх талбай	Нуур, цөөрөм, тойрмын доорх талбай	Горхи, булаг, шандны доорх талбай	Усан сангийн газрын дүн
Алтанбулаг	245	-	129	374
Баруунбүрэн	320	14	-	334
Баянгол	278	4	-	282
Ерөө	5088	180	-	5268
Жавхлант	710	37	2	749
Зүүнбүрэн	772	30	-	802
Мандал	2260	-	-	2260
Орхон	446	14	-	460
Орхонтуул	1647	27	-	1674
Сайхан	249	-	-	249
Сант	200	150	-	350
Сүхбаатар	-	-	-	-
Түшиг	380	107	200	687
Хушаат	166	9	-	175
Хүдэр	545	44	-	589
Цагааннуур	3945	273	-	4218
Шаамар	971	-	-	971
Аймгийн дүн	18222	889	331	19442

Тус аймаг усны хангамжаар улсдаа тэргүүлдэг. Цаашид гадагш урсгалтай голуудыг услалтын системд боломжит дээд хэмжээгээр ашиглах явдал нэн чухал. Ялангуяа Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар сумдад усалгаатай буудайн тариалан хөгжүүлэх нь манай улсын хувьд стратегийн ач холбогдолтой юм.

Газрын доорх усны нөөц. Усны институтээс гаргасан ангиллаар газрын доорх усны нөөцийг 5 шатлалаар ангилдаг (усны нөөц бага, багавтар, дунд зэрэг, сайн, маш сайн). Тус аймгийн хувьд эхний ангилал буюу газрын доорх усны нөөц бага гэсэн ангилалд орох газар үгүй байна. Ой мод ихтэй

Хэнтийн нуруунаас эх авсан Хараа, Ерөө голын сав, Сэлэнгэ, Орхон мөрөн, Туул голын адгаар газрын доорх усны нөөц маш сайн, бусад жижиг голуудын сав нутгаар усны нөөц сайн, Хүдэр, Алтанбулаг, Зэлтэр, Ерөө, Баруунбүрэн сумдын бусад нутгаар усны нөөц дунд зэрэг, бусад нутгаар газрын доорх усны нөөц багавтар гэж тогтоогдсон байна.

Хүснэгт 4.2. Газрын доорх усны нөөцийн ангилал

	Талбай, га	Дүнд эзлэх хувь
Нөөц багавтар	2172692	52.8
Дунд зэрэг	1336929	32.5
Сайн	456391	11.1
Маш сайн	149250	3.6
ДҮН	4115263	100.0

Нийт нутгийн тал илүү буюу 52.8 хувь нь газрын доорх усны нөөц багавтар, 32.5 хувь нь дунд зэрэг, харин 14.7 хувь нь л нөөц сайн, их сайн гэсэн ангилалд хамрагджээ. Тус аймагт газрын доорх усны 8 орд байна.

Хүснэгт 4.3. Сэлэнгэ аймгийн нутагт илрүүлсэн газрын доорх цэвэр усны орд

Ордуудын нэр	Усны нөөцийн зэрэглэл, хэмжээ м3/хоногт	Усны эрдэсжилт, г/л	Ордын байршлын координат					
			Өргөрөг			Уртраг		
			Г	М	С	Г	М	С
Орхон гол (Сүхбаатар)	A + B – 9206		50	15	0	106	9	30
Орхоны САА	A + B – 4600	M - 0.3	49	47	30	106	6	30
Бажгар улаан (Энх тал)	A + C - 1987	M - 0.3	49	14	30	105	20	30
Номгон	C – 501	M - 0.3	49	15	21	105	45	0
Бороо гол	A + B + C + 4180	M - 0.4	48	43	0	106	18	20
Хараа	A + B + C - 17280	M - 0.1	48	50	0	106	24	0
Хараа (Мандал)	A + C < 432		48	49	0	106	24	0
Хөтөл	A + B - 500		49	5	0	105	35	0

Газрын доорх усны нөөц, ордуудыг түшиглэн усалгаатай тариаланг хөгжүүлэх, бэлчээр усжуулах талаар бодлого боловсруулан ажиллах шаардлагатай.

Бэлчээр усжуулалт. Тус аймагт албан ёсоор бэлчээрийн ангилалд бүртгэгдсэн талбай 1653.3 мянган га, ойн сангаас бэлчээрт ашиглагдах талбай 160.7 мянган га, дархан цаазат болон хилийн зурвас газраас бэлчээрт ашиглагдах талбай 33.7 мянган га, нийт бэлчээрт ашиглагдах талбай 1847.7 мянган га байгаагаас усан хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн талбай 54.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.4. Бэлчээр усжуулалт

	Талбай, га	Дүнд эзлэх хувь
Бэлчээрийн талбай	1653289	
Ойн сангаас бэлчээрт ашиглагдах	160746	
Тусгай зориулалтын газраас бэлчээрт ашиглагдах	33664	
Бэлчээрт ашиглагдах талбай, бүгд	1847699	100.0
Үүнээс усжуулагдсан	1010434	54.7
усжуулагдаагүй	837265	45.3

Усжуулалт хангалтгүй байгаа бэлчээрийн ихэнх нь Орхонтуул, Сайхан, Хушаат, Цагааннуур, Ерөө, Жавхлант сумдын нутагт байна. Сүүлийн жилүүдэд тус аймагт худаг шинээр гаргах, засварлах ажил эрчимтэй хийгдэж, инженерийн хийцтэй 100 гаруй худаг шинээр гаргаж, 80 гаруй худаг засварласан байна. Цаашид бэлчээр усжуулалтын ажлыг үе шаттай, тодорхой тавьсан зорилго, төлөвлөгөөний дагуу явуулбал мал аж ахуй, түүний дотроос эрчимжсэн үхэр, хонины аж ахуйг хөгжүүлэх боломж сайжирна.

Хүснэгт 4.5. Бэлчээр усжуулах хэтийн төлөвлөгөө

	Шинээр гаргах инженерийн хийцтэй худаг	Усжуулагдах бэлчээрийн талбайн өссөн дүн, га	Бэлчээр усжуулалтын хувь
2006	18	50868	57.4
2007	18	101736	60.2
2008	18	152604	62.9
2009	18	203472	65.7
2010	18	254340	68.5
2011	18	305208	71.2
2012	18	356076	74.0
2013	18	406944	76.7
2014	18	457812	79.5
2015	18	508680	82.2
2016	18	559548	85.0
2017	18	610416	87.7

2018	18	661284	90.5
2019	18	712152	93.2
2020	18	763020	96.0
2021	18	813888	98.7
	288		

Бэлчээрт усжуулалт хангалтгүй байгаа сумуудад жил бүр инженерийн хийцтэй 18 худаг гаргаад байхад 2021 он гэхэд аймгийн бэлчээрийг бүрэн усжуулах боломж байна.

Усан сангийн газрын төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам:

Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжил хөтөлбөрт усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар хүн амын нутагшилт, суурьшилтыг байгаль орчны даацтай нь уялдуулан усны нөөц баялгийг зохистой ашиглах, нөөцийг нь зөв тооцох, арвижуулах, бохирдлоос хамгаалах, нөхөн сэргээх зорилтыг дэвшүүлж дараах үйл ажиллагааг явуулах талаар тусгасан байна. Үүнд:

- Хүн ам, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн усан хангамжийг зохицуулах, бүх төрлийн барилга байгууламжийн усны хангамж, ашиглалтыг тухайн орчны нөхцөлд тохируулан шинэчлэл хийх,
- Усны мэдээг хүлээн авах, дамжуулах, боловсруулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлыг автоматжуулах,
- Усны нөөцийг хуримтлуулан ашигтай, зөв хуваарилан гамтай хэрэглэх, гол мөрний усны хэмжээг бууруулахгүйгээр ус дутагдалтай нутаг руу шилжүүлэх,
- Аймаг, сумдын төвүүдийн усан хангамжийн өсөн нэмэгдэх хэрэгцээг найдвартай хангахын зэрэгцээ, томоохон голуудын сав газар, экологийг хамгаалах арга хэмжээ авсны үндсэн дээр урсацын тохируулга хийх;
- Борооны болон хаврын шар усны үед томоохон голуудын үерийн усыг хуримтлуулах замаар зохицуулалт хийх,
- Голын урсац хорогдож, бохирдохоос сэргийлэх хамгаалах арга хэмжээ авах,
- Байгаль, экологийн нөхцлийг судалж, үнэлгээ хийсний үндсэн дээр Хараа, Ерөө, Орхон, Сэлэнгэ, Туул голын усны нөөцийг сэлбэж арвижуулан унд, ахуй, малын усан хангамжинд хэрэглэхээс гадна голын хөндий орчмын байгалийн нөхцлийг сайжруулах,
- Газрын доорх усны эрдэсжилтийн хэмжээг бууруулах, ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх талаар үндэсний технологи, үйлдвэрлэл бий болгох,
- Усны нөөц ашиглалт, хамгаалалтын хяналт-шинжилгээний оновчтой сүлжээ бий болгох,

- Бэлчээрийн мал аж ахуйн усан хангамжийг эрс сайжруулах зорилгоор уст цэг, худгийг сэргээн засварлах, шинээр байгуулах, ашиглалт, эзэмшилтийг сайжруулах,
- Усны хэрэглэгч бүрд байгалийн усны чанарыг бууруулахгүйгээр цэвэрлэх систем барих,
- Усны ач холбогдол, түүнийг хамгаалах талаар олон түмэнд сурталчлах.

Усны нөөцийг бусад зориулалтаар ашиглах талаар:

Орхон-Сэлэнгийн сав нутгийн усны нөөц нь усны эрчим хүчийг ашиглах, усан хангамж, бэлчээр усжуулалтыг сайжруулах, загас үржүүлэх, усалгаатай газар тариалан эрхлэх зэрэг нийгэм эдийн засгийн бүхий л салбарын усны хэрэгцээг иж бүрнээр шийдэх боломжтой юм. Үүнд:

- Загасны аж ахуй хөгжүүлэх,
- Усан аялалыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх.

Сэлэнгэ аймгийн голуудаар усан аялал хийх боломжтой хугацаа нь 5 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 15 хүртэлх хугацаа юм. Гэхдээ гол мөрний усны гүн, урсац зэргээс шалтгаална. Спортын болон каноэ завь чөлөөтэй урсаж болох хамгийн бага гүн нь 30 см, голын өргөн 2.5 м-ээс доошгүй байх шаардлагатай.

Усан спорт аялалд ганцаарчилсан болон олон хүний суудалтай завиудыг хэрэглэдэг бөгөөд эдгээрээс каяак, катараман, каноэ, байдарк, моторт завь, далбаат завь зэрэг нь голлон ашиглагддаг. Аяллын төхөөрмжийн хувьд манайд каяак, катараман, каноэгийн төрлийн завиудыг аль ч голд ашиглаж болох ба Сэлэнгэ гол дээр моторт завийг хэрэглэж болох нь туршлагаар тогтоогдсон байна. Иймд катараман болон катарафтын төрөл, түүнчлэн олимпын хөтөлбөрт ордог болсон каяк, мөн каноэгийн төрлүүдийн аль нь ч хөгжих үндэслэлтэй юм.

Загас үржүүлэх боломжийн талаар: Зах зээлийн нөхцөлд байгалийн баялгийг ашиглах хэрэгцээ, сонирхол өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд загас агнуурын нөөц багатай манай орны хувьд загасыг зориудын аргаар үржүүлэх, нөөцийг нь арвижуулах, тархалт байршлыг тэлэн нутагшуулах, услалтын системийн ашиглагдахгүй байгаа усан сан, цөөрмүүдэд таваарын чиглэлээр загас өсгөж үржүүлэх боломжийг судлах шаардлага гарч байна. Иймээс зарим голууд, услалтын системийн усан сан, цөөрмийн эргийн бүс, гүн, усны горим, урсац, нөөц, ёроолын хэв шинж, хурдас, гадаргуугийн ууршилт, тэжээгдэх байдал, байгаль цаг уурын нөхцөл, усны химийн найрлага, хөвөгч болон ёроолын амьтдын бүрэлдэхүүн, биомасс, ургамал, амьтны аймгийн баялгийг нарийвчлан тодорхойлох нь чухал байна.

Усан сангийн газрыг үр ашигтай ашиглах талаар тэргүүлэх зорилт-Аймгийн хэмжээнд усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгааллыг сайжруулна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Гадаргын ус, уст цэгийн үзлэг тооллого явуулж, усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох,
- Төв, суурины усны бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх,
- Бэлчээрийг усжуулах, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах,
- Бэлчээрийн даац сайтай нутгуудад уст цэгийн хайгуул хийж, усжуулах арга хэмжээ авах,
- Орон нутгийн том, бага голуудын усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх,
- Аймаг, сумын хэмжээнд усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх, мониторингийн бүтэц бий болгох,
- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан хамгаалах, усны нөөцийн нөхөн сэргээх чадварыг сайжруулах арга хэмжээ авах,
- Уст цэг, гадаргуугийн усанд ариун цэвэр, эрүүл ахуйн бүс тогтоох, усны чанарын бохирдолтод тогтмол шинжилгээ хийх журамд шилжих,
- Томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэх,
- Зарим голын усыг хуримтлуулах цогцолборыг барьж байгуулах замаар гадаргын усны нөөц, хангамжийг нэмэгдүүлэх,
- Гол, нууруудын эрэг орчмыг хамгаалах, тэдгээрийн ус, намгархаг орчныг хамгаалах, голын хөндий, эрэг орчмын бургас, мод, сөөгийг түлш бэлтгэх зэрэг ахуйн хэрэглээнд ашиглахыг зогсоох,
- Аймгийн хэмжээнд ширгэсэн гэж усны улсын тооллогод бүртгэгдсэн гол, горхи, булаг шандаас боломжтой заримыг сэргээх арга хэмжээ авах шаардлагатай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Хөдөө аж ахуйн газрын хэмжээ. Тус аймагт 2005 оны эцсийн байдлаар хөдөө аж ахуйн зориулалттай газар 2089.1 мянган га байгаагийн 14.6 хувь нь тариалангийн эргэлтийн, 6.0 хувь нь хадлангийн, 79.1 хувь нь бэлчээрийн талбай байна. Үүнээс гадна ахуйн зориулалтаар төмс, хүнсний ногоо тариалдаг гэр хорооллын газар 1500 га байгаа нь үйлдвэрлэлийн чиглэлээр төмс, хүнсний ногоо тариалдаг 1969 га талбайтай дүйж очихоор (1:1.31) болсон байна.

Хүдэр, Шаамар, Орхонтуул сумын нутагт голчлон байгаа улсын нөөцийн хадлангийн 66.3 мянган га талбайгаас жил бүр 30 гаруй мянган тонн өвс бэлтгэж, хадлан багатай аймгуудад хүргүүлэх боломжтой юм. Мөн ойн сангийн талбайгаас ойн цоорхой зэрэг бэлчээрт ашиглах боломжтой талбай 160 гаруй мянган га, дархан цаазат болон хилийн зурвас газраас бэлчээрт ашиглах талбай 30 гаруй мянган га байна.

Хүснэгт 5.1. Хөдөө аж ахуйн газрын хэмжээ, 2006

	Га	Дүнд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар, бүгд	2089090	100.0
Бэлчээрийн талбай	1653289	79.1
өвөл-хаврын	787930	
зун-намрын	865359	
Хадлангийн талбай	123410	6.0
Тариалангийн талбай	304785	14.6
үр тариа тариалсан	80915	
төмс, хүнсний ногоо	1969	
тэжээлийн ургамал	3969	
жимс, жимсгэнэ	14	
Уринш	67358	
өнжөөсөн талбай	150560	
Атаржсан талбай	6722	0.3
ХАА-н барилга, байгууламж	877	0.0
Ахуйн зориулалттай төмс, ногоо тариалсан гэр хорооллын газар	1500	
Хөдөө аж ахуйн сорилт, туршилтын талбай	326	
Улсын нөөцийн хадлан	66279	
Ойн бэлчээр (ойн сангаас)	160746	
Тусгай хэрэгцээний газраас бэлчээрт ашиглагдах талбай	33664	

Цаашид хот суурин, үйлдвэр, уурхайн газрын нэмэгдэх хэмжээгээр хөдөө аж ахуйн газар, түүний дотроос бэлчээрийн талбай багасах нь тодорхой. Гэхдээ энэ нь аймгийн газар тариалан, мал аж ахуйн хөгжилд хортойгоор нөлөөлөхгүй.

Хүснэгт 5.2. Газрын трансформац өөрчлөлтийн төлөвлөгөө

	Хот суурин, уул уурхай, үйлдвэрийн газрын дүн, га	Хот суурины газрын өөрчлөлт, га	Бэлчээрийн талбай, га	Хөдөө аж ахуйн газрын дүн, га
2005	43450		1653289	2089090
2006	45133	1683	1651606	2087407
2007	47441	2308	1649298	2085099
2008	49943	2502	1646796	2082597
2009	52628	2685	1644111	2079912
2010	55514	2886	1641225	2077026
2011	58621	3107	1638118	2073919
2012	61470	2849	1635269	2071070
2013	64585	3115	1632154	2067955
2014	67991	3407	1628748	2064549
2015	71718	3727	1625021	2060822
2016	73891	2173	1622848	2058649
2017	76165	2274	1620574	2056375
2018	78545	2380	1618194	2053995
2019	81035	2490	1615704	2051505
2020	83641	2606	1613098	2048899
2021	86369	2728	1610370	2046171

Газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ, тариалангийн талбайн ашиглалтын төлөвлөлт. Тус аймаг сүүлийн жилүүдэд тариалангийн эргэлтийн талбайнхаа 53.7-73.2 хувийг тариалж, уриншилж ирлээ.

Хүснэгт 5.3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн гол үзүүлэлтүүд

	2000	2001	2002	2003	2004	2005
Үр тариа тариалсан талбай, га	94360	98707	122906	101799	85843	84877
Хураасан ургац, т	76143.0	67107.0	43992.6	81149.6	70734.7	34348.1
Га-гийн ургац, ц/га	8.1	6.8	3.6	8.0	8.2	4.0
Төмс тариалсан талбай, га	972.3	985.2	1124.4	1168.4	1308.0	1398.0
Хураасан ургац, т	8792.0	7292.0	9170.2	14046.9	15354.6	16536.0
Га-гийн ургац, ц/га	90.4	74.0	81.6	120.2	117.4	118.3
Хүнсний ногоо тариалсан талбай, га	623.4	772.3	932.8	1033.4	984.1	1062.4
Хураасан ургац, т	8788.6	9315.2	9218.8	13485.8	12528.2	15575.0
Га-гийн ургац, ц/га	141.0	120.6	98.8	130.5	127.3	146.6
Уриншилсан талбай, га	93218	127517	113619	70807	75231	76434
Бэлтгэсэн хадлан, т	105649.0	121353.0	115817.0	123554.0	126025.1	124360.0

Жил бүр тус аймагт 84.8-122.9 мянган га-д үр тариа тариалж ирсэн нь улсын хэмжээгээр үр тариа тариалсан талбайн тал хувийг (46.7-50.9) эзэлж байна. Үр тариагаар тэргүүлэх сумд нь Цагааннуур (25.1%), Сайхан (9.3%), Ерөө (8.7%) байна. Сүүлийн 6 жилийн дундажаар хураасан ургацынхаа хэмжээгээр ч Цагааннуур (33.2%), Ерөө (9.2%), Сайхан (8.7%) сумууд тэргүүлж байна.

Хүснэгт 5.4. Үр тариа тариалсан талбай, га

	2000	2001	2002	2003	2004	2005	Дундаж	Дүнд эзлэх %
Алтанбулаг	2028	2774	4001	3244	3203	2211	2910	3.0
Ерөө	5871	9456	11458	10302	7708	6690	8581	8.7
Мандал	4552	5330	6333	3723	3004	3135	4346	4.4
Зүүнбүрэн	2417	3661	4858	4843	3444	3189	3735	3.8
Орхон	8034	4449	9274	5405	3470	4445	5846	6.0
Сант	1441	2152	1700	968	870	681	1302	1.3
Түшиг	7522	7762	5421	4943	4426	4311	5731	5.8
Баянгол	5108	3917	5814	3563	1865	2769	3839	3.9
Сайхан	8358	10898	11451	9116	7907	7176	9151	9.3
Жавхлант	3292	3627	7585	6054	4735	4350	4941	5.0
Орхонтуул	6550	5861	7513	7267	6067	6741	6667	6.8
Цагааннуур	26296	23866	24097	23057	24194	25968	24580	25.1
Баруунбүрэн	3137	4655	8461	6301	5277	4601	5405	5.5
Хушаат	6448	7075	9800	7589	5513	4728	6859	7.0
Шаамар	1500	1100	1240	1340	1200	1060	1240	1.3
Хүдэр	1806	2124	3900	4084	2960	2822	2949	3.0
Аймгийн дүн	94360	98707	122906	101799	85843	84877	98082	100.0

Хүснэгт 5.5. Хураасан үр тариа, тонн


	2000	2001	2002	2003	2004	2005	Дундаж	Дүнд эзлэх %
Алтанбулаг	2553.0	1110.0	2876.0	2074.3	2970.3	1011.5	2099.2	3.4
Ерөө	6831.0	6254.0	6365.3	5227.6	7120.0	2401.2	5699.9	9.2
Мандал	3921.0	2460.0	2143.5	3007.0	2543.0	2024.0	2683.1	4.3
Зүүнбүрэн	2608.0	3480.0	2066.5	3138.0	2408.9	1450.0	2525.2	4.1
Орхон	4141.0	2027.0	1609.0	3609.0	2367.0	614.1	2394.5	3.8
Сант	1087.0	425.0	78.7	936.2	164.0	258.4	491.6	0.8
Түшиг	7423.0	3420.0	2579.6	3662.0	2275.8	1535.5	3482.7	5.6
Баянгол	1925.0	1622.0	725.5	3010.3	1825.0	629.1	1622.8	2.6
Сайхан	8085.0	7562.0	2307.5	5180.3	6727.6	2811.6	5445.7	8.7
Жавхлант	2648.0	2925.0	2715.0	3083.0	2794.0	785.6	2491.8	4.0
Орхонтуул	4286.0	5995.0	1784.7	8012.8	5224.2	1275.0	4429.6	7.1
Цагааннуур	20544.0	19300.0	13604.0	28500.0	25825.0	16104.1	20646.2	33.2
Баруунбүрэн	1255.0	1782.0	160.3	3473.1	2582.9	608.0	1643.6	2.6
Хушаат	5080.0	5500.0	1515.0	4919.0	2342.0	1842.0	3533.0	5.7
Шаамар	1336.0	795.0	347.0	810.0	630.0	420.0	723.0	1.2
Хүдэр	2420.0	2450.0	3115.0	2507.0	2935.0	578.0	2334.2	3.7
Аймгийн дүн	76143.0	67107.0	43992.6	81149.6	70734.7	34348.1	62245.8	100.0

Сүүлийн 6 жилийн дундажаар хамгийн өндөр ургац авсан нь Цагааннуур (8.4ц/га), Хүдэр (7.9 ц/га), Алтанбулаг (7.2ц/га) сумууд байна. Үнэмлэхүй өндөр ургацыг 2000 онд Хүдэр (13.4 ц/га), мөн 2000 онд Алтанбулаг (12.6 ц/га), 2003 онд Цагааннуур (12.4 ц/га) авсан байна.

Хүснэгт 5.6. Үр тарианы га-гийн ургац, ц/га

	2000	2001	2002	2003	2004	2005	Дундаж
Алтанбулаг	12.6	4.0	7.2	6.4	9.3	4.6	7.2
Ерөө	11.6	6.6	5.6	5.1	9.2	3.6	6.6
Мандал	8.6	4.6	3.4	8.1	8.5	6.5	6.2
Зүүнбүрэн	10.8	9.5	4.3	6.5	7.0	4.5	6.8
Орхон	5.2	4.6	1.7	6.7	6.8	1.4	4.1
Сант	7.5	2.0	0.5	9.7	1.9	3.8	3.8
Түшиг	9.9	4.4	4.8	7.4	5.1	3.6	6.1
Баянгол	3.8	4.1	1.2	8.4	9.8	2.3	4.2
Сайхан	9.7	6.9	2.0	5.7	8.5	3.9	6.0
Жавхлант	8.0	8.1	3.6	5.1	5.9	1.8	5.0
Орхонтуул	6.5	10.2	2.4	11.0	8.6	1.9	6.6
Цагааннуур	7.8	8.1	5.6	12.4	10.7	6.2	8.4
Баруунбүрэн	4.0	3.8	0.2	5.5	4.9	1.3	3.0
Хушаат	7.9	7.8	1.5	6.5	4.2	3.9	5.2
Шаамар	8.9	7.2	2.8	6.0	5.3	4.0	5.8
Хүдэр	13.4	11.5	8.0	6.1	9.9	2.0	7.9
Аймгийн дундаж	8.1	6.8	3.6	8.0	8.2	4.0	6.3

Зураг 5.1. Үр тарианы га-гийн ургац, ц/га



Аймгийн түүхэнд үр тарианы га-гаас хамгийн өндөр ургацыг 1988 онд 17.9 ц/га, 1983, 1985, 1986 онуудад 15.4-15.6 ц/га, 1975 онд 14.1 ц/га, 1960, 1971, 1973 онуудад 12.3-12.8 ц/га ургац авч байсан байна.

Цаашид ургацыг тогтвортой болгох үүднээс усалгаатай нөхцөлд үр тариа эрхлэх талбайг нэмэгдүүлэх, ингэхдээ усалгаатай нөхцөлд тохирсон сортын үрээр тариалж, агротехникийн нэмэлт арга хэмжээнүүдийг авах замаар өндөр ургац авч,

усалгааныхаа зардлыг нөхөн ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Усалгаатай үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах усны нөөцтэй бүсээр Орхон, Сэлэнгэ мөрний адаг хавиар буюу Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдын сайн чанарын хөрстэй талбайнуудыг төлөвлөж байна. Гэхдээ одоо ашиглагдаж байгаа ба бүрэн ашиглагдахгүй байгаа Мандал сумын Зүүнхараа-1, Зүүнхараа-2, Баянгол сумын Загдалын голын, Баяны өврийн, Зүүнбүрэнгийн Гачуурт, мөн хуучин ашиглаж байсан Шаамарын, Алтанбулаг сумын Хяраан голын, Төхөмийн систем, Ерөө, Жавхлант, Цагааннуур сумууд дахь усалгаатай талбайг бүрэн ашиглах шаардлагатай байна

Хүснэгт 5.7. Усалгаатай талбайн байршил, хэмжээ, га

Сумдын нэр	Газрын нэр	Усалгаатай талбай, бүгд	үүнээс: зориулалтаар	
			үр тариа	төмс, хүнсний ногоо
Алтанбулаг	Хяраан голын, Төхөмийн	286	274	12
Ерөө		52		52
Мандал	Зүүнхараа-1, 2	105		105
Зүүнбүрэн	Хуучин	157	100	57
Зүүнбүрэн	Гачуурт	1800	1800	
Сант	Төвийн урд	380	320	60
Түшиг		5		5
Баянгол	Загдалын, Баяны өврийн	105		105
Сайхан	Бүрэнтолгойн	100	76	24
Жавхлант		42		42
Орхонтуул		5		5
Цагааннуур		150		150
Шаамар	Шаамарын	87		87
Хүдэр		22		22
Аймгийн дүн		3296	2570	726

Үр тарианы талбай дахь усалгаатай талбайн эзлэх хувийн жин одоо 2.9 хувь байгааг 15 жилийн дараа 5.3 хувь болгож 10.7 мянган га-д хүргэх, богарын тариаланг өвсөн талбайн сэлгээт системд шилжүүлэх, эргэлтийн талбайг бүрэн ашиглах зорилтыг хэрэгжүүлэх замаар үр тарианы үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Сүүлийн жилүүдэд тус аймагт төмс, хүнсний тариалсан талбай, авсан ургац тогтвортой нэмэгдэж ирлээ. Гэр хорооллын айлуудын хашаандаа тариалж байгаа төмс, хүнсний ногоог статистик мэдээнд бүрэн хамруулж чадвал үүнээс ч илүү өсөлт харагдах юм. 2003-2005 онуудад Сэлэнгэ аймагт улсын нийт төмсний 17.7-20.1 хувийг үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 5.8. Үр тариа үйлдвэрлэлийн төлөвлөгөө

	Үр тариа тариалах талбай, га				Хураан авах үр тариа, тонн		
	бүгд	богар	усалгаа- тай	усалгаа- тай талбайн эзлэх %	бүгд	богар	усалгаа- тай
2006	87447	84877	2570	2.9	101075	93365	7710
2007	97244	94417	2827	2.9	112339	103858	8481
2008	107380	104270	3110	2.9	124026	114697	9329
2009	117817	114397	3421	2.9	136098	125836	10262
2010	128556	124793	3763	2.9	136081	124793	11288
2011	139595	135456	4139	3.0	147873	135456	12417
2012	150936	146383	4553	3.0	145403	131745	13659
2013	162577	157569	5008	3.1	156836	141812	15025
2014	174518	169009	5509	3.2	168636	152108	16527
2015	186760	180700	6060	3.2	180810	162630	18180
2016	193631	186965	6666	3.4	188266	168269	19998
2017	196692	189360	7333	3.7	192421	170424	21998
2018	199752	191686	8066	4.0	196714	172517	24197
2019	202808	193936	8872	4.4	201159	174542	26617
2020	204128	194369	9760	4.8	204211	174932	29279
2021	204295	193560	10736	5.3	206410	174204	32207

Хүснэгт 5.9. Төмс үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд

	Тариалсан талбай, га			Хураасан ургац, тонн			Га-гийн ургац, ц/га		
	2003	2004	2005	2003	2004	2005	2003	2004	2005
Алтанбулаг	70.0	70.5	72.1	805.0	671.3	1000.0	115.0	95.2	138.7
Ерөө	58.0	75.0	76.4	696.0	918.0	1001.0	120.0	122.4	131.0
Мандал	450.0	490.0	464.0	5848.0	6379.0	6398.0	130.0	130.2	137.9
Зүүнбүрэн	38.0	55.8	50.0	450.0	550.0	560.0	118.4	98.6	112.0
Орхон	90.0	123.3	132.0	801.0	903.3	527.0	89.0	73.3	39.9
Сант	41.0	61.5	106.5	456.0	804.7	1384.0	111.2	130.8	130.0
Түшиг	6.8	9.3	15.0	86.2	126.0	135.0	126.8	135.5	90.0
Баянгол	46.8	48.5	54.7	573.2	595.1	750.0	122.5	122.7	137.1
Сайхан	17.4	40.0	46.0	174.0	736.5	414.0	100.0	184.1	90.0
Жавхлант	31.5	56.8	45.2	362.2	466.0	384.2	115.0	82.0	85.0
Орхонтуул	40.0	30.4	41.9	512.0	330.0	444.1	128.0	108.6	106.0
Цагааннуур	21.7	22.5	28.5	271.5	285.2	304.8	125.1	126.8	106.9
Баруунбүрэн	51.0	53.4	57.1	551.0	603.7	628.1	108.0	113.1	110.0
Хушаат	23.0	40.6	46.5	220.8	401.0	595.0	96.0	98.8	128.0
Шаамар	37.0	53.2	72.8	370.0	619.8	840.0	100.0	116.6	115.4
Хүдэр	26.2	28.0	37.0	270.0	245.0	450.0	103.1	87.5	121.6
Сүхбаатар	120.0	49.2	52.3	1600.0	720.0	720.8	133.3	146.3	137.8
Аймгийн дүн	1168.4	1308.0	1398.0	14046.9	15354.6	16536.0	120.2	117.4	118.3

Аймгийн нийт төмсний 40.5 хувийг Мандал, 5.4-6.6 хувийг Алтанбулаг, Ерөө, Сант, Сүхбаатар сумууд үйлдвэрлэж байна. Тус аймаг 1989 онд 46.8, 1987 онд 39.7, 1988 онд 31.6, 1990 29.8 мянган тонн төмс, 2003-2005 онд 12.5-15.5 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь хамгийн өндөр ургац байлаа.

Хүснэгт 5.10. Хүнсний ногоо үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд

	Тариалсан талбай, га			Хураасан ургац, тонн			Га-гийн ургац, ц/га		
	2003	2004	2005	2003	2004	2005	2003	2004	2005
Алтанбулаг	47.0	48.0	47.0	852.0	718.9	1409.0	181.3	149.8	299.8
Ерөө	48.0	54.0	62.0	610.0	577.0	580.0	127.1	106.9	93.5
Мандал	328.0	302.0	250.0	4097.0	4117.0	4134.2	124.9	136.3	165.4
Зүүнбүрэн	42.6	52.7	50.0	500.0	538.0	575.0	117.4	102.1	115.0
Орхон	43.0	26.6	35.6	525.0	399.2	423.0	122.1	150.1	118.8
Сант	40.5	21.9	27.3	745.5	228.1	456.6	184.1	104.2	167.3
Түшиг	6.1	6.8	8.0	95.4	94.5	178.0	156.4	139.0	222.5
Баянгол	66.2	67.7	69.5	1449.7	1430.6	1530.0	219.0	211.3	220.1
Сайхан	36.7	32.3	36.0	477.2	313.6	410.0	130.0	97.1	113.9
Жавхлант	70.1	94.2	107.3	792.4	1000.0	1511.9	113.0	106.1	140.9
Орхонтуул	38.2	31.4	41.0	453.6	350.0	451.0	118.7	111.5	110.0
Цагааннуур	51.3	51.4	62.2	589.9	599.7	621.0	115.0	116.7	99.8
Баруунбүрэн	23.5	25.0	30.3	270.0	227.2	333.3	114.9	90.9	110.0
Хушаат	45.9	37.4	46.2	504.9	212.0	629.0	110.0	56.7	136.1
Шаамар	89.8	82.1	130.1	898.0	1210.0	1756.4	100.0	147.3	135.0
Хүдэр	15.3	16.0	20.0	157.2	156.0	220.0	102.7	97.5	110.0
Сүхбаатар	41.2	34.6	39.9	468.0	356.4	356.6	113.6	103.0	89.4
Аймгийн дүн	1033.4	984.1	1062.4	13485.8	12528.2	15575.0	130.5	127.3	146.6

Тус аймаг сүүлийн 3 жилд улсын нийт хүнсний ногооны 22.9-25.8 хувийг үйлдвэрлэсэн байна. Аймгийн нийт хүнсний ногооны 29.7 хувийг Мандал, 10.6 хувийг Баянгол, 9.3 хувийг Шаамар, 7.2-7.9 хувийг Алтанбулаг, Жавхлант сумд үйлдвэрлэж байна.

Хүснэгт 5.11. Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэлийн төлөвлөлт

	Төмс, хүнсний ногоо тариалах талбай, га					Авах ургац, тонн	
	төмс	хүнсний ногоо	дүн	үүнээс усалгаатай	усалгаатай талбайн эзлэх %	төмс	хүнсний ногоо
2006	1398	1062	2460	726	29.5	16776.0	12744.0
2007	1433	1089	2522	799	31.7	17911.9	13606.9
2008	1469	1116	2585	878	34.0	19094.1	14504.9
2009	1505	1144	2649	966	36.5	20324.2	15439.4
2010	1543	1172	2715	1063	39.1	21603.8	16411.5
2011	1582	1202	2783	1169	42.0	22934.8	17422.6
2012	1621	1232	2853	1286	45.1	24318.8	18473.9
2013	1662	1262	2924	1415	48.4	25757.6	19567.0
2014	1703	1294	2997	1556	51.9	27253.2	20703.1
2015	1746	1326	3072	1712	55.7	28807.5	21883.8
2016	1790	1359	3149	1883	59.8	30422.5	23110.6
2017	1834	1393	3228	2071	64.2	32100.2	24385.1
2018	1880	1428	3308	2278	68.9	33842.8	25708.9
2019	1927	1464	3391	2506	73.9	35652.4	27083.6
2020	1975	1501	3476	2757	79.3	37531.4	28511.0
2021	2025	1538	3563	3033	85.1	39482.1	29992.8

2005 онд 726 га төмс, хүнсний ногоог усалгаатай нөхцөлд эрхэлсэн нь нийт талбайн 29.5 хувийг эзэлж байна. Цаашид энгийн аргаар, өрхийн үйлдвэрлэлд

усалгаа нэвтрүүлэх замаар тус аймгийн төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн эзлэх хувийн жинг 2021 он гэхэд 85 хувьд хүргэж болно. Ингэснээр төмс хүнсний ногооны га-гийн ургац тогтворжиж, төмсний ургац 200 ц/га-д хүрэх боломжтой гэж төлөвлөв.

Түүнчлэн тус аймагт эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх зорилттой уялдаж тэжээлийн ургамал, түүний дотроос даршны ба уураг ихтэй буурцагт ургамал тэжээлд тариалах талбай нэмэгдэнэ. Тэжээлийн ургамлын талбай одоо 380 га байгааг 1600 га-д хүргэнэ гэж төсөөлж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн суурь болсон хөрсний нөөц, чанарын байдал тус аймагт ямар байгааг авч үзье.

Сэлэнгэ аймгийн хөрсний нөөц, түүний ашиглалт. Хөдөө аж ахуйн газрын ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын төлөвийг тодорхойлоход юуны өмнө хөрсний ашиглалт, түүний хэв шинж, үнэлгээ, элэгдэл эвдрэлийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх дараах хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь өөрөө газрын хөрсийг, тэр тусмаа хөрсний үржил шимтэй хэсгийг үйлдвэрлэлийн хэрэгсэл ба үйлдвэрлэл явуулах үндсэн нөхцөл болгодог юм. Тэгэхлээр хүн амын хүнсний хангамжийн гол эх үүсвэр болсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэтийн төлөвийг тодорхойлохдоо энэ үйлдвэрлэлийг явуулах газрын нөөц буюу хөрсний нөөц байгаа эсэхийг тогтоох шаардлагатай.

2. Хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын гол нөхцөл нь хөдөө аж ахуйн байгалийн цогцолбор нөхцлийн бүсчлэлийг зөв тогтоох явдал юм. Ийм бүсчлэлийн нэг гол үзүүлэлт нь хөрс гэдгийг эрдэмтэд судлан тогтоосон байдаг. Хөрс судлалын шинжлэх ухааныг үндэслэгч В.В.Докучаевын тодорхойлсноор хөрс бол амьгүй ба амьд байгаль, уур амьсгал, эх чулуулаг, ургамал, амьтан, гадаргуугийн хотгор гүдгэр, өндөршил болон геологийн насжилтын харилцан үйлчлэлийн үр дүнд үүссэн байгалийн онцгой биет гэжээ (Докучаев В.В., Почвы и почвоведение, 1953, х 250). Үүнээс үзэхэд хөрсний шинж чанар бол ургамал ургах олон нөхцлийн нийлбэр цогц үзүүлэлт юм.

Монгол орны бүх нутгийг хамарсан хөрсний судалгааг Н.Д.Беспалов 1951 онд анх гүйцэтгэжээ. Монгол орны хөрсний 1:2500000 масштабтай зургийг Д.Доржготов, Д.Батбаяр, Г.Ундрал нар 1974 онд зохиож хэвлүүлснээс гадна Монгол орны хөрсний газар зүйн мужлалыг Д.Доржготов 1976 онд боловсруулсан нь одоо болтол үнэ цэнэтэй, энэ талаар хийгдсэн системчилсэн суурь бүтээл юм.

Сүүлийн үед манай оронд төдийлэн тааламжтай бус цаг уурын глобаль өөрчлөлт, хуурайшилтын үр дүнд хөрсний үндсэн шинж чанар, үржил шимд ихээхэн өөрчлөлт гарч, түүний элэгдэл эвдрэл нэмэгдэх байна.

Сэлэнгэ аймагт тархсан 11 үндсэн хэв шинжийн хөрс байгаа бөгөөд тэдгээрийн нийт талбай нь 40.9 мянган хавтгай дөрвөлжин километр буюу 4095.8 мянган га талбайг эзэлж байгаа юм (Хүснэгт 27). Аймгийн хөрсний энэхүү талбайд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн гол нөөц болох хөрсний үржил шимт ялзмагийн нийт эзлэхүүн 11.3 тэрбум куб метр, түүнд агуулагдах ялзмагийн нийт нөөц 414.8 сая тонн байна.

Тус аймагт тархсан үндсэн хэв шинжийн хөрсний дотроос ялзмагийн үеийн дундаж зузаан ба ялзмагийн агууламжаараа хамгийн баялаг нь уулын тайгын ширэгт, уулын тайгын цэвдэгт хөрс (30 см, 6.5%), уулын ойн бараан хөрс (26 см, 6.2%), уулын хар шороон хөрс (25 см, 6.0%), хар хүрэн хөрс (45 см, 4.5%) байна.

Уулын тайгын ширэгт, уулын тайгын цэвдэгт хөрсний 86 хувь нь Ерөө, Түшиг, Мандал сумын нутагт, уулын ойн бараан хөрсний 81 хувь нь Ерөө, Мандал, Хүдэр суманд, уулын хар шороон хөрсний 74 хувь нь Мандал, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Сант, Түшиг, Баянгол сумын нутагт байна.

Харин хөрсний чанарын үзүүлэлтээр хамгийн ядмаг нь нугын хужирлаг, мараалаг хам хөрс (10 см, 0.5%), цайвар хүрэн хөрс (18 см, 1.2%) болно. Нугын хужирлаг, мараалаг хам хөрс зөвхөн Орхонтуул суманд, цайвар хүрэн хөрс Цагааннуур, Мандал, Баянгол суманд сумын нутагт байдаг байна.

Сэлэнгэ аймагт талбайн хэмжээгээрээ хамгийн их тархалттай хөрс нь уулын хар хүрэн, хүрэн хөрс (24.0%), уулын ойн бараан хөрс (20.3%), аллювийн нугын хөрс (12.2%), уулын хар шороон хөрс (11.6%) байна.

Гэвч ялзмагийн нөөцөөрөө хамгийн их хувийн жин эзэлж байгаа нь уулын ойн бараан хөрс (16.6%), уулын нугат хээрийн заримдаг тагийн хөрс (12.8%), хүрэн хөрс (12.4%) байна. Өөрөөр хэлбэл эдгээр гурван хэв шинжийн хөрс аймгийн нийт ялзмагийн нөөцийн 40 гаруй хувийг эзэлж байна. Ийм хэмжээний хөрсний нөөц байгаа боловч зарим хэсэг нь газрын гадаргуу болоод бусад нөхцөл шалтгаанаар хөдөө аж ахуйд ашиглагддаггүй, мөн бусад үйлдвэрлэл, салбарын зориулалтаар ашиглагдаж байгаа юм. Цаашид ч хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, суурьшлын нөлөөлөл ихсэж хөдөө аж ахуйн зориулалтын талбай жилээс жилд буурах хандлагатай болно.

Хүснэгт 5.12. Сэлэнгэ аймгийн хөрсний нөөц

Хөрсний код	Хөрсний хэв шинж	Талбай, га	Дүнд эзлэх хувь	Ялзмагт үеийн эзлэхүүн, сая куб метр	Ялзмагийн дундаж хувь	Ялзмагийн нийт нөөц, сая тонн
2	Аллювийн нугын хөрс	501690	12.2	1162.7	2.7	24.1
17	Уулын хар хүрэн, хүрэн хөрс	982201	24.0	2940.6	2.5	56.5
23	Хар хүрэн хөрс	170648	4.2	827.4	4.5	28.6
14	Хүрэн хөрс	18204	0.4	54.9	2.5	1.1
13	Нугын хүрэн хөрс	332659	8.1	1160.5	3.2	29.6
20	Цайвар хүрэн хөрс	84003	2.1	181.0	1.2	1.7
4	Уулын цайвар хүрэн хөрс	259149	6.3	698.1	2.7	14.5
18	Уулын хар шороон хөрс	476916	11.6	1798.5	6.0	83.0
21	Уулын ойн бараан хөрс	832723	20.3	2243.1	6.2	107.0
19	Уулын тайгын ширэгт, цэвдэгт хөрс	424677	10.4	1372.7	6.5	68.6
8	Нугын хужирлаг, мараалаг хөрс	12950	0.3	14.0	0.5	0.1
ДҮН		4095821	100.0	11290.8	4.2	414.8

Тус аймгийн нутгийн хөрсөн бүрхэвчийг 3 бүлэгт хувааж дэлгэрэнгүй авч үзье.

а/ Уулын хөрс. Уулын хөрсний бүлэгт далайн түвшнээс дээш 800-900 м өргөгдсөн нам уул, ухаа толгодоос авахуулаад түүнээс дээш өндөрт орших ууланд тархсан бүхий л хөрсийг багтаана. Уулын хөрсний тархалт нь өндрийн бүсшлийн зүй тогтлоос шалтгаалан өндрийн тодорхой түвшинд өөр өөр хөрстэй байдаг. Өөрөөр хэлбэл, уулын оройгоос хормойг хүртэл өндрийн түвшин өөрчлөгдөхөд нэг янзын хөрс нөгөөгөөр солигдоно гэсэн үг.

Сэлэнгэ аймагт тархсан уулын хөрс нь нийт хөрсний талбайн 72 хувийг эзэлж байна. Уулын хөрсний бүлэгт уулын тайгийн ширэгт, ойн бараан хөрс, уулын тайгийн цэвдэгт, уулын хар шороон, уулын хар хүрэн, уулын хүрэн хөрсний хэв шинжүүдийг багтаав.

Уулын тайгийн ширэгт, ойн бараан хөрс, уулын тайгийн цэвдэгт хөрс нь газрын гадаргад олон жилийн цэвдэг ойрхон орших нөхцөлд тогтворжих бөгөөд цэвдгийн улирлын гэсэлтийн гүн 1-1.2 метрээс хэтрэхгүй. Хөрсөн дэх цэвдгийн гэсэлт орой эхэлж удаан үргэлжилдэг онцлогтой. Иймээс энэ хөрсөнд цэвдэгт-угаагдлын шинжтэй өвөрмөц чийгийн горим үйлчилнэ. Хөрсний гадарга дээр хөвдлөг-хүлрэнцэр маягийн органик үлдэгдлээс тогтсон нэлээд зузаан хучаас байнга байх бөгөөд тэр нь дулаан тусгаарлагчийн үүрэг гүйцэтгэж хөрсний дулаан хангамжид сөргөөр

нөлөөлнө. Энэ хөрс чийгээр байнга хангалттай байх хэдий ч сайр чулуурхаг, бас нунтаг шороон үе нь нимгэвтэр учраас ус барьж тогтоох чадвараар сайн биш байна. Нөгөөтэйгүүр олон жилийн цэвдгийн үзэгдэл овойлт, суулт, олон талт ан цав, асган хүрээ, чулуун тогоо, асга чулуун толбо, удаан, түргэн зуурын хөрсний гулсалт үүсгэх нь цөөнгүй.

Уулын тайгийн ширэгт хөрсний ердийн профиль O-A(ABf)-Bf(B)-BC-C гэсэн үе давхаргуудтай байна. Хөрсний гадарга дээрх өвслөг ургамлын хагас ялзарсан үлдэгдэл бүхий ойн дэвсгэр хучаасны (O) зузаан дунджаар 2.6 см (хамгийн нимгэн нь 1 см, хамгийн зузаан нь 5 см), түүний доорх боровтор саарал өнгөтэй, бөөмөрхөг буюу бөөмөрхөг-үрлэнцэр бүтэцтэй ширэгт-ялзмаг хуримтлалын давхаргын (A) зузаан дунджаар 7 см (хамгийн бага нь 3 см, хамгийн зузаан нь 14 см) байна. Түүний доор нэлээд тохиолдолд сааралдуу бор өнгөтэй шилжилтийн ялзмагжсан АВ давхарга байх ба зузаан нь дунджаар 13 см, заримдаа энэ давхарга төмрийн исэлжсэн (ABf) шинжтэй байдаг. Ялзмагт үеэс доош хоорондоо өнгөөр муу ялгарах төмрийн ислийн хурц бор, улаавтар бор, бор шаргал өнгөтэй нунтаг шороон үе үргэлжилж гүн рүүгээ өнгө нь аажим бүдгэрнэ. Хөдөлгөөнт төмрийн хуримтлал бүхий Bf давхаргын зузаан дунджаар 19 см, BC давхаргын зузаан 20-40 см байна. Хөрсний урвалын орчин бүх давхаргадаа хүчиллэг шинжтэй. Ялзмагийн агууламж ялзмаг хуримтлалын A давхаргад 6-15.8 хувь, Bf давхаргад 1.5-2.6 болтлоо эрс багасна.

Уулын тайгийн цэвдэгт хөрсний үе давхаргууд нь O(OT)-OA-(ABf)-Bf-BCf-(BC)C гэсэн тогтоцтой байна. Хөвд органик үлдэгдлээс тогтсон, заримдаа хүлрэнцэр шинжтэй байдаг ойн дэвсгэр хучаасны зузаан дунджаар 7.5 см, түүний дотор байрлах сааралдуу бараан бор, хүрэвтэр бор, хүрэвтэр саарал жигд биш халтар өнгөтэй, бүдүүн ялзмагийн зүйл ихтэй, органик хуримтлалын зузаан дунджаар 6 см байна. Энэ давхаргаас доош хоорондоо сайн ялгарахгүй хурц улаавтар бор, зосорхог бор, ухаа өнгөтэй, гол төлөв шавранцар бүрэлдэхүүнтэй эрдэс чулуулгийн (Bf, BCf) давхаргууд дараалан байрлаж эх чулуулагт шилжинэ. Эдгээр давхаргууд нь хэмхдэс сайр чулуу ихтэй, эзлэхүүний 30-80% хүртэл хэсгийг чулуу эзэлнэ. Дээд давхаргууд нь ихэнхи тохиолдолд жижиг бөөмөрхөг, үрлэнцэр бүтэцтэй, ойн түймрийн ул мөр болох модны нүүрс, үнс, мөн шаталтаас үүдэлтэй улаан, ухаа өнгөтэй толбууд үзэгдэнэ. Ширхэгийн бүрэлдэхүүнээр шавранцар, хөнгөн шавранцар хөрс зонхилж, тэдгээрийн найрлагад элс, бүдүүн тоосны фракци илүү агуулагдана.

Уулын тайгийн цэвдэгт хөрс ерөнхийдээ нимгэн, хөрсний нийт зузаан 60-80 см-ээс хэтрэхгүй. Хөрсний урвалын орчин бүх үе давхаргад хүчиллэг шинжтэй, ялзмагийн агууламж 6.5%, доошоогоо эрс буурч 2.4-3.5 хувь, түүнээс ч бага байна.

Хөрсөн дэх солилцох сууриуд үе давхаргуудаар хуримтлагдах байдал нь ялзмагийнхтай адил доошлох тусам буурдаг зүй тогтол ажиглагдана. Дээр дурьдсан хөрсний ялзмагийн нийт нөөц 175.6 сая тонн байгаа боловч хөдөө аж ахуйд бараг ашиглагддаггүй.

Уулын хар шороон хөрс уулын ойт хээрийн бүсийг бүрдүүлэгч гол хөрсний нэг бөгөөд ойтой хиллэх газраар уулын өвөр хажууд, хуурай хээртэй хиллэх газраар уулын ар хажууд, нугат хээрийн болон алаг өвст-үетэнт чийгэрхэг хээрийн ургамалшил дор тогтворжино. Хөрсөн дээрх ургамлан бүрхэвч хурдас чулуулгийн ширхэгийн бүрэлдэхүүн, сайр чулуурхаг байдлаас хамаарч 50-90 хүртэл хувь шигүү ургасан байдаг. Энэ хөрс нь ус нэвтрүүлэх чадвар сайтай учраас зуны хур борооны нөлөөнд нэвт угаагдах чийгийн горимтой, түүнчлэн хатуу суурь чулуу нь гүн биш орших учраас эгц хажуугийн урсац үүсэх нөхцөл бүрдэж хөрсний шинж байдалд нөлөөлнө. Эдгээр хөрс өвөл 2.5-3 м хүртэл гүн хөлдөж, хавар харьцангуй түргэн гэсдэг. Энэ хөрсний үе давхарга А-АВ-В(V_{Ca})-BC (BC_{Ca})-C(C_{Ca}) гэсэн давхаргуудтай. Хар шороон хөрсний үе давхаргыг тодорхойлогч нь А давхарга юм. Тэр нь хүрэвтэр бараан өнгөөрөө бусад давхаргаас тод ялгардаг, бөөмөрхөг бүтэцтэй, дээд хэсэгтээ сайн ширэгжсэн, зузаан нь 13-24 см, АВ давхарга нь дээд үеэсээ арай сааралдуу хүрэн бор, бараавтар хүрэн, бор өнгөтэй, жижиг сайргархаг, зузаан нь 14-22 см, В давхарга нь бор, боровтор шар өнгөтэй, гүн рүүгээ ялзмаг нь аажмаар буурдаг, сайр чулуу ихтэй, зузаан нь 20-25 см, BC үеүд нь бор шар, шар өнгөтэй, сайр чулуу ихтэй, нунтаг шороо нь хөрсний эзэлхүүний 5-20 хувь орчим, сайр чулууны доор хальслаг хучаас үүссэн байна. Доод давхаргууддаа нунтаг карбонатлагийн хуримтлал байх нь элбэг. Хөрсний нийт давхарга зузаан биш, 50-60 см-ээс хатуу суурь чулууны хэмхдэс дэвсэж тогтсон байдаг. Тэгэхдээ ургамлын үндэс хэмхдэс чулууны завсраар шургалан орж нунтаг шорооны хамт хавчуулагдан орших тул ялзмагжилт нилээн гүнийг хамарсан байдаг онцлогтой. Уулын хар шороон хөрс ихэнхдээ хөнгөн шавранцар, дунд шавранцар бүрэлдэхүүнтэй. А давхарга дахь ялзмагийн агууламж 6-12 хувь байснаа АВ давхаргад 5.8 болтлоо буурч доошоогоо эрс багасч байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр дунджаар 20-30 мг-экв байна.

Уулын хар шороон хөрсний биологийн бүтээмж өндөр тул сайн чанарын бэлчээр тэжээлийн нөөцийг буй болгодог. Энэ хөрсний ялзмагийн нийт нөөц 83 сая тонн хүрнэ.

Уулын хар хүрэн хөрс нь нунтаг карбонатын хэвийн хуримтлалтай, А-В-BC_{Ca} - C_{Ca} гэсэн үе давхаргуудтай. Бараан хүрэн өнгөтэй, ялзмаг хуримтлалын А давхаргадаа 3.5-4.5 хувийн ялзмагтай, зузаан нь дунджаар 16 см, В давхарга нь 2-3

хувийн ялзмаг агууламжтай, зузаанаар 14 см, энэ 2 давхарагад карбонатын хуримтлал байхгүй. Давсны хүчлийн нөлөөнд А+В үеийн доороос хааяа а давхаргын доороос эхэлж бургиж буцалдаг. Хөрсний гадаргаас эхлэн сайр чулуутай. Гол төлөв хагас метрийн гүнд суурь чулуулгийн элюви-делювийн хурдас оршино. Карбонатын агууламж ихэвчлэн 6-7% хүрнэ. Шингээгдсэн сууриудын нийлбэр А давхаргад 100 гр хөрсөнд 15-20 мг-экв, урвалын хөрсний орчин сулхан хүчиллэг шинжтэй байна. Энэ хөрс нь байгалийн үржил шимээр сайн, өвслөг ургамлын бүрхэц 50-70% хүрнэ. Хөрсний ялзмагийн нийт нөөц (уулын хүрэн хөрстэй нийлээд) 83 сая тонн байгаа юм.

Ийм хөрстэй газрыг жилийн турш бэлчээрт ашиглахаас гадна зарим газар хадланд ашиглаж байна.

Уулын хүрэн хөрсийг хар хүрэн хөрстэй харьцуулбал ялзмагийн агууламж багатай, ялзмаг хуримтлалын үе нь арай нимгэн, өнгөөр мэдэгдэхүйц гэгээтэй, карбонатын давхарга нэлээд дээр байдгаараа ялгаатай. Үе давхарга нь А-(В)-В_{Ca} - ВС_{Ca} -С_{Ca} гэсэн бүтэцтэй. Тод хүрэн өнгөтэй, ялзмаг хуримтлалын давхарга нь дунджаар 14 см, 2-3 хувийн ялзмаг агууламжтай. Ихэнхи тохиолдолд А давхаргын дор карбонатын хуримтлалын В_{Ca} давхарга залгана. Давсны хүчилд голдуу А давхаргын дороос эхлэн буцална. Солилцох сууриудын шингээх чадвар тааруу, 100 грамм хөрсөнд 7-13 мг-экв байна. Ширхэгийн бүрэлдэхүүнээр ихэвчлэн хөнгөн шавранцар, дунд шавранцар, элсэнцэр хөрс зонхилно. Карбонатын хуримтлалын давхаргуудад СаСО₃ нэвчмэл цайвар толботой, СО₂-ын хэмжээ 2-5% байна. Урвалын орчин хөрсний дээд давхаргуудад саармаг доошоогоо шүлтлэг байна.

Уулын хүрэн хөрс байгалийн үржил шимээр хангалттай, ургамлын бүрхэц 30-50%-д хүрнэ. Ийм хөрстэй бэлчээрийг жилийн 4 улиралд малын бэлчээрт сэлгэж ашиглах боломжтой.

б/ Тал хөндийн хөрс. Аймгийн хойд, өмнөд, баруун, зүүн хэсгийн долгиорхог гүвээт тал, уул нуруудын хоорондох хөндий, хотгоруудаар 15.2 хувийг эзлэн тархсан байдаг.

Уулын ам хөндий, жалга судаг, хотос хонхорын ероол, нуга тойрмын ойр ус чийгтэй нуга, намгархаг газраар чийгт гарлын хөрсүүд тохиолддог. Ийм хөрс нь тэгшдүү төвгөр газар оршдог ердийн хөрсийг бодвол ямагт илүү чийглэг нөхцөлд тогтворждогоороо онцлогтой.

Хар хүрэн хөрс нь алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамалшил дор тогтворжих бөгөөд өвслөг ургамлын бүрхэц газрын гадаргын 50-80 хувийг эзэлнэ. Өвлийн улиралд 3.4-4 м хүртэл гүн хөлдөж, -10 хэмийн температур 80-90 см гүн нэвтэрнэ. Чийг багатай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учраас улирлын цэвдэг нь мөсгүй

байдаг онцлогтой. Дулааны улиралд хөрсний үе давхаргууд сайн халж ургамлын ургалтын хугацаанд +10 хэмийн температур хөрсөнд 160-170 см хүртэл гүн нэвтэрдэг. Хөрсний чийгийн хангамж агаарын хур тунадасны хэмжээ хуваарилалтаас шууд хамаарах тул зуны хур борооны үед хамгийн их чийгтэй байна. Хар хүрэн хөрсний ялзмаг хуримтлалын зузаан дунджаар 23 см, бараавтар бор өнгөтэй, өнгөөрөө тод ялгарна. Хар хүрэн хөрсний дээд үе давхарга дахь ялзмагийн агууламж дунд ба хөнгөн шавранцар хөрсөнд 3-5%, элсэн ба элсэнцэр хөрсөнд 2-3% хүрч доошоогоо хурдан буурна. Ялзмагийн бодисын агууламж тогтвортой бус, зарим тохиолдолд гумины хүчил давамгайлж, нөгөө тохиолдолд фульвохүчлийн хэмжээ илүү байх жишээтэй. Энэ нь хар хүрэн хөрсний олон янзын үүсэлтэйг гэрчилж байгаа юм. Урвалын орчин дээд давхаргад сулхан хүчиллэг буюу саармаг, гүн рүүгээ шүлтлэг болж байна. Ялзмагийн агууламж бага, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд шингээх багтаамжийн хэмжээ их биш, шингээгдсэн сууриудын нийлбэр хөнгөн хөрсөнд 16-26 мг-экв, элсэн болон элсэнцэр хөрсөнд 6-16 мг-экв, дунд шавранцар хөрсөнд 25-35 мг-экв байна.

Хар хүрэн хөрс агрохимийн шинжээр харьцангуй сайн, шим тэжээлийн элементийн агууламж хангалттай тул тус аймгийн газар тариаланд өргөн ашиглагддаг. Ялзмагийн нийт нөөц 28.6 сая тонн байна.

Хүрэн хөрс харгана бүхий үетэнт, агь-үетэнт ургамалтай уудам хотгоруудаар тархах бөгөөд ургамлын бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их ус чийгтэй үед хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл нэвчдэг тул түүнээс доошхи хэсэг нь голдуу хуурай байдаг. Хөрсний гадарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрс өвлийн улиралд 2.8-3.5 м хүртэл гүн хөлдөх боловч -10 хэмийн температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй ажээ. Үүнээс үзэхэд хар хүрэн хөрснөөс чийг, дулааны хувьд ялгаатай. Хүрэн хөрс хар хүрэн хөрсийг бодвол нимгэн, өнгөөр мэдэгдэхүйц ялгаатай, карбонатын давхарга арай дээрээс эхэлдэг. А давхаргын зузаан дунджаар 16 см, нийт ялзмагт үеийн зузаан дунджаар 33 см байна. Карбонатын хуримтлалын давхарга ихэнхидээ А давхаргатай зууд залган оршино. Хүрэн хөрсний ялзмагийн хэмжээ 3 хувиас хэтрэхгүй, хөнгөн шавранцар хөрсөнд 2-3%, элсэнцэр хөрсөнд 1.5-2, орчим байна. Ялзмагийн бодисын найрлагад фульво хүчлийн хэмжээ байнга илүү байх тул ялзмаг нь тогтвортой гумат-фульвот шинжтэй байдгаараа онцлогтой. Урвалын орчин карбонатын давхаргаас дээш хэсэгт саармаг буюу түүнтэй ойролцоо, доод давхаргуудад шүлтлэг шинжтэй байна. Шингээх багтаамж их биш, хөнгөн шавранцар хөрсөнд 100 гр хөрсөнд 12-23 мг-экв, элсэнцэр хөрсөнд 6-12 мг-экв, солилцоот сууриудын бүрэлдэхүүнд кальци давамгайлна.

Агрохимийн үзүүлэлтээр хар хүрэн хөрсийг гүйцэхгүй, хөрсний нийт ялзмагийн нөөц 1.1 сая тоннд хүрнэ. Хүрэн хөрстэй газар тус аймгийн бэлчээрт ашиглагдахаас гадна тариаланд ихээхэн ашиглагдаж байна.

Цайвар хүрэн хөрс цайвар хүрэн буюу боровтор өнгөтэй, ялзмаг багатай, ялзмагт давхарга нь нимгэн, давсны хүчлийн нөлөөнд дээд үеэсээ бургиж буцалдаг, ургамлын бүрхэц сийрэг онцлогтой. Цайвар хүрэн хөрс $A-(A_{Ca})-B_{Ca}-BC_{Ca}-C_{Ca}$ гэсэн үе давхаргатай. Ялзмагт үеийн зузаан дунджаар 11 см, давсны хүчилд А давхаргын дороос эхэлж бургиж хөөсөрдөг. Үүнээс үзэхэд бүх үе давхарга нь карбонаттай байх явдал цөөнгүй. Ялзмагийн агууламж А давхаргад 0.5-1.5 % байх ба заримдаа B_{Ca} давхаргадаа 0.8-1.2 хүрч дээд үеэсээ илүү ялзмагжсан байх нь бий. Энэ нь ургамлын үндэсний бөөгнөрөл B_{Ca} их байдагтай холбоотой. Энэ хөрсөнд карбонатын угаагдал бараг ажиглагдахгүй шахам, их л сайндаа дээд талын 10 см орчим карбонатгүй байх жишээтэй. Хөрсний бүх үе давхарга шүлтлэг орчинтой боловч хялбар уусах давс, гөлтгөнө байхгүй. Карбонатын хуримтлал 3.4% байна. Энэ хөрсний байгалийн үржил шим тааруу, 1.7 сая тонн ялзмагийн нөөцтэй байна.

Нугын хүрэн хөрс уулын бэл хормой, ухаа толгодын хоорондох хотгорын ёроол, нуур, голын дэнж зэрэг нам хотос, хонхор газрыг дагаж тархсан байна. Энэ хөрсөн дээр үетэн-алаг өвст ургамлын бүрхэц 60-80% хүрнэ. Энэ хөрсөнд орчин тойрны өндөрлөг газраас гадаргын урсацаар ирж хуралдах ус чийгийн нөлөөгөөр улирлын чанартай түр зуурын нэмэгдэл чийг бий болж нугархаг шинж үүсэх нөхцөл бүрддэг. Жилийн дулаан улирлын ихэнхи хугацааны туршид, түүнчлэн хур дунадас багатай хуурай жилд энэ хөрсний чийгийн горим ердийн хүрэн хөрснийхээс үл ялгагдах бөгөөд гагцхүү хур бороотой үед л чийгийн хангамж нь түр хугацаанд нэмэгдэж хэсэг зуур илүүдэл чийгтэй болно. Үүнд удаан үргэлжлэх улирлын цэвдэг нөлөөлөхөөс гадна зарим тохиолдолд хөрсөн доорхи гүний усны хөөрөлтөөр тэжээл авч чийглэгдэх ч талтай. Энэ хөрсний доод давхаргад улирлын цэвдгийн ул мөр болох үелэнцэр-хайрсархаг бүтэц, мөн түр зуурын илүүдэл чийгтэйн шинж тэмдэг болох глейрхэг зэгэл саарал, хурц бор шар өнгийн толбо ажиглагдана. Ялзмагийн давхарга нь илүү бараавтар саарал өнгөтэй, доод хил зааг нь бүдэг, ялзмагийн халтартсан толбуудтай, төмрийн сааралдуу туяа зонхилдог зэрэг нь хүрэн хөрснөөс ялгагдах шинж юм. Энэ хөрсний ялзмаг хуримтлалын давхаргын зузаан дунджаар 27 см, нийт ялзмагт үеийн зузаан дунджаар 48 см, 30-60 см-ийн гүнээс доош нунтаг карбонатын хуримтлал ажиглагдах тул хөрсний дээд тал ихэнхидээ карбонатгүй байна. Ялзмагийн агууламж дээд үедээ дундажаар 3.2 хувь хүртэл хэлбэлзэнэ. Хөрсний урвалын орчин дээд үедээ саармаг, доошоогоо шүлтлэг шинжтэй, шингээгдсэн

сууриудын нийлбэр хэмжээ 100 грамм хөрсөнд 15-30 мг-экв, түүний бүрэлдэхүүнд кальцийн ион зонхилж, солилцоот натрийн агууламж маш бага хувийг эзэлдэг. Энэ хөрс нь шим тэжээлийн бодисоор харьцангуй баялаг, байгалийн үржил шимээр сайн тул тус аймгийн газар тариаланд өргөн ашиглагдаж байна. Ялзмагийн нийт нөөц 29.6 сая тонн байна.

в/ Голын хөндийн хөрс. Тус аймгийн нутгаар сүлжин урсах голууд нь уулынх учраас урсгалын эхэн ба дунд хэсэг нь хавцал маягийн нарийн хөндийгээр урсаж татам төдий л хөгжөөгүй, харин голуудын адаг орчмын уудам хөндийд татмын дэнжүүд сайн ялгарсан байдаг. Ийм газруудад голын татмын хөрс буюу аллювийн нугын хөрс бий болсон байх бөгөөд 12.2 хувийг эзэлдэг, орон зайн хувьд алаг цоог тархалттай, чийгшилтийн байдал нь голын татмын хөрсний олон янзын хэв шинж бүрэлдэн тогтоход нөлөөлжээ. Жишээлбэл: хамгийн чийгтэй хаяа татамд аллювийн намгийн хөрс, төв татамд аллювийн нугын хөрс, харьцангуй хуурай хөвөө татамд аллювийн ширэгт хөрс бий болсон байна.

Аллювийн нугын болон нугын карбонатлаг хөрсүүд нь голын хөндийн арай хуурайдуу хэсгээр тархдаг. Энэ хөрсүүдийг тариаланд ашиглаж байна. Аллювийн нугын мараалаг, хужирлаг, намгархаг хөрсүүд нь хадлан бэлчээрт тохиромжтой. Голын хөндийн хөрснүүдийн ихэнхи хэсэг нь Зүүнбүрэн, Цагааннуур, Сайхан, Орхонтуул, Мандал, Ерөө сумдын нутгаар тархжээ.

Аллювийн нугын хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 13 см, ялзмагийн агууламж А давхаргад 2.7-4.9 %, хөрсний урвалын орчин сулхан шүлтлэг, гүн рүүгээ шүлтлэг нь ихсэж байна. Шингээгдсэн сууриудын нийлбэрт кальцийн агууламж давамгайлж 30-45 мг-экв 100 грамм хөрсөнд агуулагддаг. Энэ хөрсний ялзмагийн нийт нөөц 24.1 сая. тонн байна.

Тариалангийн газарт тархсан хөрсний төлөв байдал. Тус аймгийн тариаланд ашиглаж байгаа газруудад уулын хар хүрэн, хүрэн, нугын хүрэн, тал хөндийн хар хүрэн, хүрэн, аллювийн нугын хөрсний янз дүрсүүд голлон тархсан байна.

Эдгээр хөрсүүдийг агро-үйлдвэрлэлийн шинж чанараар нь авч үзвэл 15.4 хувь нь маш сайн, 60 хувь нь сайн, 24.5 хувь нь дунд зэрэг, үлдсэн нь муу ангилалд багтана.

Тариалангийн газрын элэгдэл, эвдрэлд орсон байдлаар нь авч үзвэл:

1. Сул орсон – 62.0 хувь
3. Дунд зэрэг орсон – 22.8 хувь
4. Хүчтэй орсон – 15.2 хувь байна.

Эргэлтийн талбайн 45.6 хувь нь элэгдэл, эвдрэлд орсны 38.0 хувь нь дунд зэргээс дээш түвшинд нэрвэгджээ. Аймгийн 22.8 мянган га тариалангийн талбайн хөрс хүчтэй элэгдэж эвдэрсэний улмаас 87 сая тонн үржил шимт хөрс ба түүний хамт 2.2 сая тонн ялзмаг алдагджээ /Д.Аваадорж, Г.Элдэв, 1990/.

Тус аймгийн Алтанбулаг суманд 1175 га, Жавхлантад 737 га, Хүдэрт 14 га, Сайханд 800 га, Орхонд 2820 га буюу нийт 5546 га тариалангийн талбай элсэжсэн байна.

Тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэлээр Сэлэнгэ аймаг улсын дундажтай харьцуулахад арай бага юм. Гэвч тариалан эрхэлж ирсэн хугацаа бусдаас илүү учир тариалангийн газрын элэгдэл эвдрэлд ашиглалтын хугацааны нөлөөллийг тэргүүн ээлжинд тавихаас өөр аргагүй гэсэн дүгнэлт хийж болмоор юм. Гэхдээ хөрсний элэгдэл, эвдрэлийн тархалтын хэмжээ, эвдрэлийн зэрэглэлээр сумдын талбайнууд харилцан адилгүй байна.

Алтанбулаг, Жавхлант, Орхон, Сайхан, Шаамар, Цагааннуур, Хушаат сумдын хөрсний 64 хувь нь элэгдэл, эвдрэлд оржээ. Гэвч Цагааннуур, Хушаат зэрэг сумдын элэгдэл, эвдрэлд орсон талбайн 82-98 хувь нь сул зэрэглэлтэй байхад, Алтанбулагийн талбайн 83 хувь, Баянголын 65, Жавхлантын 51 хувь, Түшигийн 66, Мандалын талбайн 72.8 хувь нь дунд болон хүчтэй нэрвэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн нутагт нэлээд тариалангийн талбай нарсан ойн элсэн хөрстэй хил залган орших бөгөөд гарал зүйн хувьд ч төсөөтэй байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тариалангийн талбайн хөрс нь салхиар хийссэн төдийгүй бас усаар угаагдсан байдалтай байна. Энэ нь Ерөө, Хүдэр, Баруунбүрэн, Зүүнбүрэнгийн нийт 822 га талбайд ажиглагдсан байна.

Хүснэгт 5.13. Сэлэнгэ аймгийн тариалангийн газрын хөрсний элэгдэл, эвдрэл

Сумын нэр	Судалгаанд хамрагдсан талбай, мян.га	Элэгдэл, эвдрэлд орсон		Эвдрэлийн зэрэглэл%		
		га	хувь	сул	дунд	хүчтэй
Алтанбулаг	13.5	9.4	69.6	17.0	29.8	53.2
Баянгол	11.8	2.3	19.5	34.8	30.4	34.8
Жавхлант	17.8	10.9	61.2	49.5	30.3	20.2
Баруунбүрэн	21.0	0.4	1.9			100.0
Ерөө	23.9	5.2	21.7	84.6	11.5	3.9
Зүүнбүрэн	20.2	8.4	41.6	63.1	31.0	5.9
Мандал	17.5	6.5	37.1	27.7	36.9	35.4
Түшиг	13.9	4.8	34.5	33.3	43.8	22.9
Цагааннуур	42.0	31.1	74.0	81.6	17.4	1.0

Сайхан	26.1	18.0	69.0	71.1	21.7	7.2
Орхон	27.1	18.9	69.7	47.6	22.8	29.6
Орхонтуул	24.4	3.7	15.2	45.9	40.6	13.5
Хүдэр	9.3	0.5	5.3	80.0		20.0
Сант	6.6	0.3	4.5	66.7	33.3	
Шаамар	4.3	3.2	74.4	37.5	46.9	15.6
Хушаат	21.5	13.7	63.7	98.0	1.0	1.0
Дүн	300.9	137.3	45.6	62.0	22.8	15.2

Ургамлан бүрхэвч. Ургамалжилтын үндсэн хэлбэр нь уулын хээр, түүний хээржсэн хувилбарууд болно.

Өндөр уулсаар нь ой зонхилох бөгөөд хус, улиангар заримдаа бага зэрэг холилдон ургасан өвслөг ургамалт шинэсэн ойтой.

Орхоны голын хажуугийн цутгал намагжсан татам нь шугам торлог ихтэй. Хээржсэн нугаас гадна өлөнгө, цахилдаг бүхий марзлаг нуга, дэрс тохиолддог. Харин Сэлэнгийн саваар хэсэг, хэсэг газар элс даган навчит ойн төгөлтэй. Уулсын дээд бие болон нуруудын хавтгай хяраар байх ой нь тайгын шинжтэй бөгөөд тодорхой хэмжээний хуштай.

Уулын хээр нь уулсын өмнөд хэсэг, хөндийгээр байх ба зүйлийн бүрдэл нь алаг цоог бөгөөд ботууль, туужууны өвс, саман ерхөг зэрэг үетнээс гадна алаг өвс нэлээд элбэг. Харин уулсын нөгөө талаар хуурай хээрийн бүлгэмдэл болох хазаар өвс-хялганат, зүр өвс-хялганат, хялгана-навтуулт хээр тааралдана.

Уулсын хоорондын хөндийд үетэн, үетэн-улалжит нуга, нам бургаснаас бүрдсэн шугуй бий. Өндөрлөг уулсаар дундаж өндөр уулын ширэгт-тайгын ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг шинэсэн, хус-шинэсэн, хус-нарсан ойн бэлчээртэй. 13-15 ц/га тэжээлийн нөөцтэй, 700-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганат нугат хээрийн бэлчээр нь 9-11 ц/га тэжээлийн нөөцтэй бөгөөд тэжээлийн нэгж нь 650-700 кг/га байдаг. Нунтаг карбонатлаг сайр чулуурхаг хүрэн хөрстэй бэлчээрт алаг өвс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-хялганат хээрийн бэлчээр нь 5-8 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй.

Томоохон голын сав дагуу намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт-улалжит, татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий нугын алаг өвст нугын бэлчээр нь 26-29 ц/га тэжээлийн нөөцтэй, 1900-2100 кг/га тэжээлийн нэгжтэй. Ойн бараан ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст хус улиангар

ургасан дундаж өндөрлөгтэй уулын ойн бэлчээр нь 12-15 ц/га тэжээлийн нөөц, 800-850 кг/га тэжээлийн нөөцтэй.

Нам уулсын бэлээр хар шороон, нугат хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй боролзгоно бүхий улалж-үетэнт, сайр чулуурхаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт нугат хээрийн бэлчээрт 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-500 кг/га тэжээлийн нэгжтэй.

Уулсын хоорондын өргөн, нарийн хөндийгээр хүрэн хөрстэй, алаг өвс-хялганат, харгана-хялганат, хазаар өвс-хялганат хээрийн бэлчээртэй. Энэ бэлчээр нь 20-22 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1500 кг/га тэжээлийн нэгжтэй.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, хадлан, бэлчээрийн талбай ашиглалтын төлөвлөлт. Сүүлийн жилүүдэд тус аймгийн нэлээд суманд үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд тохиромж муутай болж, цаашид тэжээлийн үйлдвэрлэлд шилжих, түүнтэй эрчимжсэн мал аж ахуй, ялангуяа махны, мах-сүүний, сүү-махны үхэр, нарийн, нарийвтар ноост хонины аж ахуй хослуулан эрхлэх боломж, шаардлага урган гарч байна.

Аймгийн үхэр, хонь, ямааны тоо өсөх хандлагатай байна. 2005 оны эцэст 73.7 мянган үхэр, 277.6 мянган хонь, 238.7 мянган ямаа тоологдсон нь өмнөх жилүүдээсээ өссөн байна.

Аймгийн хэмжээгээр 2005 онд 3169 малчин өрх байгаагийн 35.9 хувь нь цахилгаан гэрэлтэй, 33.3 хувь нь телевизортой, 16.1 хувь нь автомашинтай, 8.8 хувь нь мотоциклтэй, 7.6 хувь нь трактортой болсон байгаа нь бусад аймгуудаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5.14. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол үзүүлэлтүүд

	2002	2003	2004	2005
Малчин өрхийн тоо	3 244	2 921	2 893	3 169
Малчдын тоо	7 055	5 997	6 422	6 707
Малын тоо, мян.тол.: тэмээ	0.8	0.7	0.5	0.4
үүнээс ингэ	-	0.2	0.2	0.2
Адуу	47.6	42.9	39.5	37.1
үүнээс гүү	-	13.6	12.0	11.0
Үхэр	94.1	71.5	68.4	73.7
үүнээс үнээ	-	29.2	28.4	29.5
Хонь	316.7	266.2	253.6	277.6
үүнээс эм хонь	-	129.7	121.2	132.2
Ямаа	224.3	205.6	215.5	238.7
үүнээс эм ямаа	-	100.4	98.7	109.7

ДҮН	683.5	586.9	577.5	627.5
ХЭЭЛТЭГЧИЙН ДҮН	-	273.1	260.5	282.6

Хүснэгт 5.15. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005

	Мах, амьдын жингээр, тонн	Мах, нядал- гааны жингээр, тонн	Ноос, ноолуур, тонн	Сүү, мян.л	Арьс, шир, ш	Үйлд- вэрлэсэн бүтээг- дэхүүн, сая.төг
Махны үхэр	866.1	433.0			1840	1641.5
Монгол үхэр	4702.1	2351.1		8922.1	15111	10588.1
Нарийн ноост хонь	219.8	105.5	34.3		4886	291.3
Монгол хонь	4138.5	1986.5	372.2	1300.9	91996	4964.8
Ямаа	3141.3	1445.0	100.6	2274.8	80203	7273.5
Адуу	1453.2	726.6		1242.9	4638	2148.4
Тэмээ	10.0	5.0	1.8		20	13.6
Гахай	30.0	16.5				45.0
ДҮН	14561.0	7069.2	508.9	14896.1	198694	26966.3

2005 онд аймгийн хэмжээгээр 7.1 мян.т буюу нэг хүнд 70.8 кг мах, 14.9 сая литр сүү буюу нэг хүнд 149 литр сүү, 100.6 тонн ноолуур, 372.2 тонн бүдүүн ноос, 34.3 тонн нарийн ноос, 17 мянган үхрийн шир, 96 мянган хонины нэхий, 80 мянган ямааны арьс, нийт 27.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн буюу нэг малчин өрх 8.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 64 хувийг өрхийн хэрэглээнд, 36 хувийг гадагш борлуулсан тооцоо байна. Нэг хүнд мах, сүү үйлдвэрлэлтээр улсын дундажтай ойролцоо байна (улсын дундажаар нэг хүнд мах 75.4 кг, сүү 130.8 литр).

Цаашид аймгийн бэлчээр, тэжээл үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн ашиглах, махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн боломжтой сумуудад, тухайлбал Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Хушаат, Түшиг, Цагааннуур, Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Жавхлант сумдад махны үхрийг өсгөх шаардлагатай байна. Сүргийн эргэлтийн тооцоогоор цаг уурын хэвийн нөхцөлд махны чиглэлийн үхрийн хээлтэгчийн тоог жилд 10%, нарийн ноост эм хонины тоог 13% хүртэл өсгөж болно. Энэ тохиолдолд махны чиглэлийн нийт үхрийн тоо 4.6 хувь өсөхийн зэрэгцээ оны эхний 1000 толгойгоос жил бүр нядалгааны жингээр 48.0 тонн мах үйлдвэрлэх боломжтой.

Хүснэгт 5.16. Эрчимжсэн ба нутгийн үхэр өсгөх төлөвлөгөө

	Махны, мах- сүүний, сүү- махны үхрийн толгойн тоо	Үйлд- вэрлэх мах, няд. жингээр, тонн	Монгол үхрийн толгойн тоо	Үйлд- вэрлэх мах, няд. жингээр, тонн	Үйлд- вэрлэх үхрийн мах, бүгд, тонн	Жилийн өсөл- тийн хувь	2006 онтой харь- цуулсан хувь
2006	8005	384.2	65700	2351.1	2735.3		
2007	8373	401.9	67014	2398.1	2800.0	102.4	102.4

2008	8758	420.4	68354	2446.1	2866.5	102.4	104.8
2009	9161	439.7	69721	2495.0	2934.7	102.4	107.3
2010	9583	460.0	71116	2544.9	3004.8	102.4	109.9
2011	10024	481.1	72538	2595.8	3076.9	102.4	112.5
2012	10485	503.3	73989	2647.7	3151.0	102.4	115.2
2013	10967	526.4	75469	2700.6	3227.1	102.4	118.0
2014	11471	550.6	76978	2754.7	3305.3	102.4	120.8
2015	11999	576.0	78518	2809.8	3385.7	102.4	123.8
2016	12551	602.4	80088	2865.9	3468.4	102.4	126.8
2017	13128	630.2	81690	2923.3	3553.4	102.5	129.9
2018	13732	659.1	83323	2981.7	3640.9	102.5	133.1
2019	14364	689.5	84990	3041.4	3730.8	102.5	136.4
2020	15025	721.2	86690	3102.2	3823.4	102.5	139.8
2021	15716	754.4	88424	3164.2	3918.6	102.5	143.3

Эрчимтэй мал аж ахуйн өсөлтийн боломжийг хангахын тулд монгол малын өсөлтийг хязгаартай, гэхдээ хүн амын өсөлтийн хурдаас хоцроохгүйгээр (ядаж жилд 2%) өсгөх шаардлагатай. Ямааны тоо толгойг их нэмэгдүүлэхгүй байвал сайн юм.

Сүргийн эргэлтээс дүгнэлт хийхэд нарийн, нарийвтар ноост хонийг өсгөхийн тулд эм хонины тоог жилд хамгийн их нь 13 хувь өсгөх боломжтойн зэрэгцээ энэ тохиолдолд сүргийн нийт хонины тоо 6.6 хувиар нэмэгдэх тооцоо гарч байгаа юм. Сүргийн ийм эргэлттэй байхад оны эхний 1000 толгойгоос нядалгааны жингээр 6.75 тонн мах, 2453 кг нарийн ноос үйлдвэрлэх боломжтой.

Хүснэгт 5.17. Эрчимжсэн ба нутгийн хонь өсгөх төлөвлөгөө

	Нарийн ноост толгойн тоо	Үйлд-вэрлэх мах, няд. жингээр, тонн	Үйлд-вэрлэх нарийн ноос, тонн	Монгол хонины толгойн тоо	Үйлд-вэрлэх мах, няд. жингээр, тонн	Үйлд-вэрлэх хонины мах, бүгд, тонн	Жилийн өсөлтийн хувь
2006	14006	94.5	34.4	263600	2069.3	2163.8	
2007	14930	100.8	36.6	268872	2110.6	2211.4	102.2
2008	15916	107.4	39.0	274249	2152.9	2260.3	102.2
2009	16966	114.5	41.6	279734	2195.9	2310.4	102.2
2010	18086	122.1	44.4	285329	2239.8	2361.9	102.2
2011	19280	130.1	47.3	291036	2284.6	2414.8	102.2
2012	20552	138.7	50.4	296856	2330.3	2469.0	102.2
2013	21909	147.9	53.7	302794	2376.9	2524.8	102.3
2014	23355	157.6	57.3	308849	2424.5	2582.1	102.3
2015	24896	168.0	61.1	315026	2473.0	2641.0	102.3
2016	26539	179.1	65.1	321327	2522.4	2701.6	102.3
2017	28291	191.0	69.4	327753	2572.9	2763.8	102.3
2018	30158	203.6	74.0	334309	2624.3	2827.9	102.3
2019	32148	217.0	78.9	340995	2676.8	2893.8	102.3

2020	34270	231.3	84.1	347815	2730.3	2961.7	102.3
2021	36532	246.6	89.6	354771	2785.0	3031.5	102.4

Тэжээлийн хэрэгцээг тооцоходоо одоо байгаа махны чиглэлийн үхрийг түлхүү буюу жилд 4.6 хувиар өсгөх, нарийн, нарийвтар ноост хонийг 6.6 хувь, монгол үхэр, хонийг хүн амын өсөлтийн хурдаас доогуургүй буюу жилд 2.0 хувь, ямааг 1.0 хувь, гахайг 5.0 хувь, харин адуу, тэмээг өсгөхгүй байхаар тооцлоо. Оны эхний бүтцийн нэг толгой малд жилд шаардагдах тэжээлийн шимт чанарын (тэжээлийн нэгжийн) нормыг профессор Х.Гэндарамын боловсруулсан нормативаар авч тооцоход Сэлэнгэ аймгийн бүх төрлийн малд 2006 онд 359.0 мянган тонн тэжээлийн нэгж шаардагдаж байна. Ийм хэмжээний тэжээлийг мал байгалийн бэлчээрээс ба нэмэгдэл тэжээлийн хэлбэрээр авч, энергээ нөхөж байгаа юм.

Малын тоо толгойг өсгөж, махны хэрэгцээг эрчимжсэн аргаар нэмэгдүүлнэ гэж төлөвлөж байгаа учраас энэхүү тэжээлийн хэрэгцээ өссөөр 2021 онд 459.7 мянган тонн тэжээлийн нэгж шаардагдана. Энэ хэрэгцээ нь тус аймгаас одоо нийлүүлж чадах тэжээлийн чадавхитай тэнцэж байна гэсэн тооцоо гарлаа. Иймээс аймгийн тэжээлийн нөөцийн ашиглалтын хувь одоо 77.9 хувь байгаа нь аажим нэмэгдсээр 99.7 хувь болно гэсэн үг. Энэхүү тооцоонд таримал бэлчээр бий болгох, олон наст ба буурцагт ургамлаар бэлчээр, хадлангийн талбайг сэргээх, цас, мөс, үерийн усыг нөөцөлж хадлан, бэлчээрийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийн тооцоо ороогүй, зөвхөн одоо байгаа тэжээлийн нөөцөд нь өгсөн үнэлгээ болно.

Хүснэгт 5.18. Тэжээлийн хэрэгцээний төлөвлөгөө, малын төрлөөр, тонн тэжээлийн нэгж

	Мажны үхэр	Монгол үхэр	Нарийн ноост хонь	Монгол хонь	Ямаа	Адуу	Тэмээ	Гахай	Тэжээлийн хэрэгцээ, бүгд	Тэжээлийн нөөцийн ашиглалтын хувь
2006	16010	85410	6303	92260	81158	74200	1000	624	358971	77.9
2007	16746	87118	6719	94105	81970	74200	1000	655	364520	79.1
2008	17517	88861	7162	95987	82789	74200	1000	688	370212	80.3
2009	18323	90638	7635	97907	83617	74200	1000	722	376051	81.6
2010	19165	92451	8139	99865	84453	74200	1000	758	382042	82.9
2011	20047	94300	8676	101862	85298	74200	1000	796	388190	84.2
2012	20969	96186	9248	103900	86151	74200	1000	836	394502	85.6
2013	21934	98109	9859	105978	87012	74200	1000	878	400983	87.0
2014	22943	100071	10510	108097	87882	74200	1000	922	407639	88.4
2015	23998	102073	11203	110259	88761	74200	1000	968	414478	89.9
2016	25102	104114	11943	112464	89649	74200	1000	1016	421505	91.4
2017	26257	106197	12731	114714	90545	74200	1000	1067	428727	93.0
2018	27464	108321	13571	117008	91451	74200	1000	1121	436154	94.6

2019	28728	110487	14467	119348	92365	74200	1000	1177	443791	96.3
2020	30049	112697	15422	121735	93289	74200	1000	1235	451647	98.0
2021	31432	114951	16439	124170	94222	74200	1000	1297	459732	99.7

**Хүснэгт 5.19. Тэжээл нийлүүлэлтийн чадавхийн тооцоо,
эдэлбэрийн төрлөөр, тонн тэжээлийн нэгж**

	Талбай, га	Бэлчээр, хадлангийн хянан баталгаагаар тогтоосон дундаж ургац, ногоон масс, ц/га	Нийт масс, тонн	Тэжээллэг чанар, тонн тэжээлийн нэгж
Х-6 тойргийн бэлчээр	674781	4.9	331806.2	149312.8
Х-6 тойргийн ойн бэлчээр	160746	2.0	32149.2	14467.1
Х-7 тойргийн бэлчээр	1012172	4.3	432790.7	194755.8
БЭЛЧЭЭРИЙН ДҮН	1847699		796746.1	358535.7
Х-6 тойргийн хадлан	75876	9.5	72081.8	37482.5
Х-7 тойргийн хадлан	113813	7.7	87636.3	45570.9
ХАДЛАНГИЙН ДҮН	189689		159718.1	83053.4
Сүрэл			40000.0	7200.0
Няцалсан будаа, үр тарианы хаягдал			8000.0	9760.0
Төмс, ногооны хаягдал			6000.0	2400.0
ТАРИМАЛ ТЭЖЭЭЛИЙН ДҮН				19360.0
ТЭЖЭЭЛ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЧАДАВХИ				460949.2

Аймгийн тэжээл нийлүүлэлтийн чадавхи 461 мянган тонн тэжээлийн нэгж байгаа бөгөөд түүний 77.8 хувийг бэлчээрээс, 18.0 хувийг байгалийн хадлангаас, 4.2 хувийг тариалангийн дайвар бүтээгдэхүүн, хаягдлаас хангана гэж үзсэн болно.

Хадлан, бэлчээрийн талбайн сайжруулалт хийн, түүнийг журамтай, сэлгээтэй ашигласан тохиолдолд аймгийн тэжээл нийлүүлэлтийн чадавхи үүнээс ч илүү сайжрах боломжтой.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ОЙН САНГИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Ойн сангийн газрын хэмжээ. Ойн сан бүхий газарт ой модоор бүрхэгдсэн газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан нөхөн сэргээлтийн мод үржүүлгийн талбай, ой тэлэн ургах боломжтой нөөц газар хамаарна.

Тус аймаг нь 1607.5 мянган га ой сангийн газартай бөгөөд энэ талбайн 90.1 хувь нь ой модоор бүрхэгдсэн талбай, 7.3 хувь нь ойн сангийн бусад газар буюу ойн цоорхой, зурвас, 1.3 хувь нь ой модыг нь огтолсон газар, мөн 1.3 хувь нь ой тэлэн ургах нөөц газар байна.

Хүснэгт 6.1. Ойн сан бүхий газар, га

	Ой модоор бүрхэгдсэн газар	Ой модыг нь огтолсон газар	Мод үржүүлгийн газар	Ой тэлэн ургах нөөц газар	Ойн сангийн бусад газар	Бүгд
Алтанбулаг	123381	2160	5	-	17190	142736
Баруунбүрэн	94013	426		8881	783	104103
Баянгол	21112	2808		2400		26320
Ерөө	464890	3793			31425	500108
Жавхлант	8227	312		7389	2100	18028
Зүүнбүрэн	15493				773	16266
Мандал	28053	4755			24672	309957
Орхон	2738	-				2738
Орхонтуул	6454				463	6917
Сайхан	5734	206		220		6160
Сант	23915	24			6528	30467
Сүхбаатар		-				
Түшиг	100960	1100			11400	113460
Хушаат	27755	4105		2231		34091
Хүдэр	152394	949			9307	162650
Цагааннуур	98652	-			9967	108619
Шаамар	21669	-			3173	24842
Аймгийн дүн	1195440	20638	5	21121	117781	1607462

Ойн сангийн газрын хэмжээг сумаар авч үзвэл аймгийн нийт модтой газрын 31.1 хувь нь Ерөө суманд, 19.3 хувь нь Мандал суманд, 10.1 хувь нь Хүдэр суманд, 8.9 хувь нь Алтанбулаг суманд байна. Хамгийн их мод огтолсон газар Мандалд 4755 га, Хушаатад 4105, Ерөөд 3793, Баянголд 2808 га байна.

Ой тэлэн ургах боломжтой гэж үзэж байгаа нөөц газар Баруунбүрэнд 8881 га, Жавхлантад 7389, Хушаат, Баянгол сумдад 2231-2400 га байна. Алтанбулагт мод үржүүлгийн 5 га газар байгаа нь нэн сайшаалтай.

Ойн төрөл. Тус аймаг ховор мод бүхий холимог ойтой нь бусад аймгуудаас онцлог юм. Ихэни аймагт шинэсэн ой зонхилдог байхад тус аймагт хуш, хус, нарс, гацуур зэрэг тэр болгон элбэг тохиолдоод байдаггүй ховор сайхан ойтой билээ. Аймгийн нийт ойн 30.1 хувийг хус, улиасан холимог ой, 28.1 хувийг нарсан ой, 25.3 хувийг шинэсэн ой, 15.3 хувийг хушин ой, 0.1 хувийг гацууран ой эзэлж байна. Ойг ийнхүү ангилахдаа зонхилох модоор нь тогтоосон нь мэдээж. Гэхдээ тус аймгийн ойд 17 төрлийн мод, 40-өөд зүйлийн том сөөг, 150-иад зүйлийн сөөг, 48 зүйлийн сөөгөнцөр, бараг 2000 зүйлийн нэг, хоёр, олон наст өвслөг ургамал бүртгэгдсэн байна.

Хүснэгт 6.2. Ойн төрөл

	Ойн талбай, га	Дүнд эзлэх хувь
Шинэсэн ой	407038	25.3
Нарсан ой	452308	28.1
Хушин ой	245862	15.3
Гацууран ой	2342	0.1
Хус, улиасан ой	484302	30.1
Холимог ширэнгэ	15610	1.0
ДҮН	1607462	100.0

Ойд учирдаг гол хохирол нь хүн ба байгалийн үүдэлтэй байх ба тэдгээрээс хамгийн ноцтой нь зөвшөөрөлгүй мод бэлтгэх, санаатайгаар таваарын чанарлаг идэр модуудыг огтлох, мөн ой модонд амралт зугаалга, ан хийх, самар түүх ажлаар явж байгаад түймэр тавих явдал юм.

Хүснэгт 6.3. Ойд учирсан хохирол

		2002	2003	2004	2005
Ойн түймрийн тоо	Улсын дүн	323	38	46	47
	Сэлэнгэ	34	14	12	-
	Дүнд эзлэх хувь	10.5	36.8	26.1	0
Ойгоос бэлтгэсэн мод, мян.куб м	Улсын дүн	568.3	576.5	531.2	606.0
	Сэлэнгэ	56.7	88.2	63.4	81.1
	Дүнд эзлэх хувь	10.0	15.3	11.9	13.4

Гадаадын нэгэн эксперт сүүлийн 10 жилд Монголд гарсан түймрийн хохирлыг олон улсын жишгээр тооцож, 20 тэрбум ам.доллар гэж гаргажээ. Манай улсын 2005

оны дотоодын нийт бүтээгдэхүүн 1.1 тэрбум ам.доллар гээд бодоход дээрх нь ямар их хохирол болохыг төсөөлөхөд бэрх юм.

Байгалийн үүдэлтэй өөр нэг ойн гамшиг нь хортон шавьж юм.

Ойн сангийн газрын төлөвлөлт. Тус аймгийн 16 сум, суурины 244.5 мянган га талбайд ногоон бүс, тариалангийн талбайн зурвас ой байгуулахаар төлөвлөж байна. Эдгээрээс хамгийн их талбайд ойжуулалт, ногоон бүс, зурвас байгуулах суурин газрууд нь Сүхбаатар, Баруунбүрэн, Түшиг, Цагааннуур, Түнхэл, Шаамар, Хүдэр, Ерөө, Хөтөл юм.

Хүснэгт 6.4. Ой нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ

	Ногоон бүс байгуулах талбай, га	Дүнд эзлэх хувь	Ойн хортон устгах талбай, га	Дүнд эзлэх хувь
Түшиг	15610	6.4		
Цагааннуур	15610	6.4	70246	30.5
Хушаат	11708	4.8	42928	18.6
Баруунбүрэн	19513	8.0		
Түнхэл	15610	6.4	42928	18.6
Мандал	11200	4.6	50734	22.0
Сант	10900	4.5	23415	10.2
Баянгол	11708	4.8		
Алтанбулаг	7805	3.2		
Зүүнбүрэн	11708	4.8		
Шаамар	15610	6.4		
Дулаанхаан	7805	3.2		
Хүдэр	15610	6.4		
Ерөө	15610	6.4		
Сүхбаатар	42928	17.6		
Хөтөл	15610	6.4		
ДҮН	244547	100.0	230252	100.0

5 сумын 230 гаруй мянган га ойн талбайд хортон устгах арга хэмжээ авна. Энэ нь хортон шавьжны уршгаар ой ихээр сүйдэж байгаа Цагааннуур, Мандал, Хушаат, Мандал, Сант сумдын ойн талбайг голчлон хамарна.

Ойн сангийн газрын талаар тавих тэргүүлэх зорилт: Ойн нөөцийг хамгаалах цогцолбор арга хэмжээ авч, нөхөн сэргээлтийг идэвхжүүлж, ашиглалтад тавих хяналтыг хүчтэй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх,
- Бүсийн ойн сангийн мэдээллийн сан, мониторингын сүлжээ байгуулах,

- Хэрэглээний зориулалтаар мод бэлтгэхийг бүрмөсөн хориглож, түлшний зориулалтаар нарийн хяналттайгаар, ой цэвэрлэгээний журмаар бэлтгэх,
- Сэлэнгэ, Орхон, Туул, Хараа, Ерөө голуудын дагуух мод, бургас, сөөгийг хамгаалах арга хэмжээ авах, нутгийн цаг уурт зохицсон модны төрлөөр ойн нөхөн сэргээлт хийх ажлыг эрчимжүүлэх,
- Хот, суурин газрыг цэцэрлэгжүүлэх,
- Гол, усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах,
- “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүс нутгийн нөөц, боломжийг бүрэн дайчлан ашиглах,
- Ойг түймэр, хортон, шавьж, мэрэгчдээс хамгаалах зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээг боловсруулан авч хэрэгжүүлэх,
- Тусгай хамгаалалттай газар нутагт ойн менежментийн төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гарах үр дүн: Ойн нөөцийн хамгаалалт сайжирч, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил наад зах нь ашигласан талбайн хэмжээнд хүрнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Монгол улсын тогтвортой хөгжил, экологийн аюулгүй байдлыг бүрдүүлэх үндэс нь байгаль хамгаалах, газрын нөөцийг зохистой ашиглах явдал мөн. Аливаа орны байгаль хамгаалах төрийн бодлогын цөмд тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал орж, дэлхий нийтийн хэмжээнд улс орны байгаль, соёлын өвийг хадгалан хамгаалах хамгийн зохистой хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Монгол орны байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хангах, экологийн амин чухал үйл явцыг дэмжих, биологийн төрөл зүйл болон түүх, соёлын дурсгал бүхий газар нутгийг хамгаалалтад авах явдал чухлаар тавигдаж байна.

Байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хангах, экологийн амин чухал үйл явцыг дэмжиж, байгалийн бүс, бүслүүрийн иж бүрдлийг төлөөлсөн ховор, ховордсон амьтан, ургамал болон түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх ач холбогдолтой төдийгүй, дэлхийн улс орнууд байгаль орчиндоо зохицсон тогтвортой хөгжих үзэл санааг баталгаажуулах гол үндсэн нөхцөл болно.

“Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-т ойрын 20 жилийн хугацаанд Тусгай хамгаалалттай газарт улсын нийт нутгийн 30-аас доошгүй хувийг хамруулах зорилтыг тавьсан юм. Одоогийн байдлаар тусгай хамгаалалтад авсан газруудын хамгаалалтын горимыг сайжруулах нь шинээр газар нутгийг хамгаалалтад авахаас ч чухал зүйл юм.

Тусгай хэрэгцээний газрын хэмжээ. Аймгийн дүнгээр тусгай хэрэгцээний газар 336.6 мянган га байгаагийн 51.6 хувь нь хилийн зурвас газар, 28.4 хувь нь дархан цаазат газар, 19.7 хувь нь улсын нөөцийн хадлангийн талбай, 0.1 хувь нь чөлөөт бүсийн газар, мөн 0.1 хувь нь сорилт, туршилтын талбай байна.

Тусгай хэрэгцээний газрыг сумаар авч үзэхэд гуравны нэг нь Ерөө суманд, 19.1 хувь нь Түшигт, 17.6 хувь нь Хүдэрт, 13.6 хувь нь Алтанбулаг суманд байдаг.

Сэлэнгэ аймгийн нутагт Ерөөгийн эхний, Тужийн нарсны гэсэн хоёр дархан цаазат газар байна.

Ерөөгийн эхний дархан цаазат газар: Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал сумдын нутагт хамаарах бөгөөд Минж, Ерөө голуудын усны хагалбарын районы далайн түвшнээс дээд 1100-1800 м өргөгдсөн бэсрэг уулстай, гацуур, хуш, жодоо зэрэг ойтой газар юм. Энэ дархан цаазат газарт Монгол оронд маш ховор жодоон тайгын хэв шинж тохиолддог бөгөөд эгэл исрэг, бяцхан жимст цангис, нүцгэн товь цэцэг, хар нэрс, их саадган цэцэг, даль, сурнаг зэрэг ховор ба ховордсон ургамлууд, Монгол

оронд ургадаг шилмүүст бүх том мод, зарим навчит моднууд холимог байдлаар ургадаг.

Хүснэгт 7.1. Тусгай хэрэгцээний газрын хэмжээ, га

	Бігд	Улсын тусгай хамгаалалттай газар, бігд	Дархан цаазат газар	Улсын хилийн зурвас газар	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	Шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиллалтын талбай	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	Чөлөөт бийсийн газар
Алтанбулаг	45855			45355				500
Баруунбүрэн	2					2		
Баянгол	1				1	0		
Ерєє	112143	74262	74262	23665		0	14216	
Жавхлант	2588						2588	
Зїйнбїрэн	1					1		
Мандал	21384	21354	21354			30		
Орхон	2					2		
Орхонтуул	4					4		
Сайхан	168				8	160		
Сант	1300						1300	
Сїхбаатар	90				90	0		
Тїшиг	64211			64209		2		
Хушаат	13101					1	13100	
Хїдэр	59268			40593		0	18675	
Цагааннуур	16524					124	16400	
ДҮН	336642	95616	95616	173822	99	326	66279	500

Тужийн нарсны дархан цаазат газар: Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар сумдын нутагт далайн түвшнээс 600-800 метрт өргөгдсөн, томоохон голын татмын элсэн хөрстэй тэгш тал газарт ургасан нарсан ой зонхилсон байна. Ийм ой Монгол оронд ховор байдгийн дотор Тужийн нарсны ойн экосистемийн хувьд илүү тогтвортой, даацтай байна. 1980-аад оноос хойш энэ бүс нутагт ойн түймэр олон удаа гарч байгаа бөгөөд мөн ахуйн хэрэгцээнд ил далд мод огтолж байгаа нь ихээхэн сөрөг нөлөө учруулсаар байна. Тужийн нарсны экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор 2002 онд тусгай хамгаалалтад авсан юм.

Цаашид Бөхлөө, Чагтаан нуруу орчмын 320000 га газрыг байгалийн нөөц газрын ангиллаар улсын хамгаалалтанд авахаар судалгаа хийж үндэслэл боловсруулж байна. Мөн түүхийн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт 20-оод газрыг орон нутгийн хамгаалалтад авахаар төөвлөж байна.

Алтанбулагийн “Худалдааны чөлөөт бүс”: Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд ХҮИИ зууны үеэс чөлөөт худалдаа, арилжаа хөгжиж эхэлсэн. XIX зууны сүүлчээр

Монгол, Орос, Хятадын худалдаа өргөжсөний дүнд Монгол орны эдийн засагт Хиагтын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, хилийн чухал боомт газар болж хувирсан байна. 1911-1917 онд Хиагт нь Монголоос Орос улстай хийсэн худалдааны эргэлтийн 50 гаруй хувийг гүйцэтгэж байсан ба Хиагтын дотоод зах зээл дээр зэргэлдээх газруудаас мал, түүхий эд, цагаан идээ, ангийн үс, тариалангийн бүтээгдэхүүнийг тогтмол борлуулдаг болсон байна. Үүний хамт Хиагтад худалдаа наймааны ажлыг дагнан эрхэлдэг наймаач нар хятад, оросын 50 гаруй пүүс, мухлагт ажиллах болсноор “Наймаачны хот” гэж нэрлэгдэж байв.

Өнгөрсөн 60-70 жилд Алтанбулагийн тээвэр, газар зүйн байрлал ихээхэн сайжирч, засаг захиргаа, аж ахуй, соёл, эмнэлэг, сургууль төвлөрсөн орчин үеийн суурин болж хувирав. Энэ сум нь эрчим хүч, холбооны нэгдсэн сүлжээтэй, экран ЧМ, Азиасат телевизийн станцтай, биеэ даасан дулааны станц бүхий дулаан хангамж, цэвэр, бохир усны нэгдсэн холболттой юм. Сумын нутагт түүх, соёлын дурсгалт газар олон бөгөөд Хонд, Гүн нуурын улсын амралт, хүүхдийн зуслан ажилладаг.

Алтанбулаг нь Улаанбаатараас 335 км, аймгийн төвөөс 28 км, ОХУ-ын Хиагт хүртэл 5 км, нийтдээ хатуу хучилттай замтай. Сүхбаатар хот байгуулагдсанаар Алтанбулагийн улс хоорондын худалдааны чиг үүрэг тийшээ шилжиж, зөвхөн орон нутгийн суурингын үүрэгтэй хөгжиж ирэв. Хэдий тийм боловч манай хөрш орнуудад нэвтэрдэг нийт 42 хилийн боомтоос нэвтрүүлэх чадвараараа Сүхбаатар, Замын-Үүдийн дараа ордог, бүх төрлийн авто хөсөг, явганаар хил нэвтрэх чухал гарц (Олон улсын хилийн боомт) хэвээр үлдсэн байна. 1980-аад оны байдлаар Орос Монголын хоорондын хил худалдааны 60 гаруй хувь Алтанбулагийн чиглэлд хийгдэж байв. 1999 оны байдлаар Монгол-ОХУ-ын хилийн боомтуудаар орсон нийт ачааны 37.5 хувь нь Алтанбулагийн боомтоор тээвэрлэгдсэн бөгөөд эдийн засгийн харилцаа өргөжиж байгаа өнөөгийн нөхцөлд Алтанбулагийн гарцаар орох, гарах ачаа, зорчигчдын тоо нэмэгдсээр байна.

Монгол, Оросын Холбооны Улсын Засгийн газрын 1994, 1995 оны дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол, ОХУ хоорондын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх, үүний дотор хоёр улсын хил дагуу гаалийн хөнгөлөлттэй бүс нутаг бий болгох, харилцан ашигтай нөхцлөөр тодорхой нутагт чөлөөт бүс байгуулах (юуны түрүүн Алтанбулаг, Хиагтын чиглэлд) асуудлыг хэлэлцэж, 1996 оноос энэ асуудлыг нарийвчлан судалж холбогдох арга хэмжээг авахаар тохиролцож байв. Монгол, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2000 оны 11 сарын 13-ны өдрийн протоколд Алтанбулаг, Хиагтад чөлөөт бүс байгуулах

боломжтойг дурдаад энэ зорилгоор, 2 боомтын холбосон автотээврийн олон улсын гарцыг барьж байгуулахаар заажээ.

Монгол Улсын улсын нөөцийн хадлангийн дийлэнх (60%) хувийг тус аймгийн Хүдэр, Шаамар, Зүүнбүрэн, Орхонтуул сумдаас бэлтгэсээр ирсэн, одоо ч бэлтгэж байгаа. Энэ нутгийн хүмүүсийн орлог олох нэгэн чухал эх үүсвэр учир хадлангийн талбайг сайжруулах, хамгаалах арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Улсын тусгай хамгаалалттай газрын талаар тавих тэргүүлэх зорилт: Аймгийн нутаг дэвсгэр дэх биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудлуудыг эдийн засгийн салбарын бодлого, бүтэц, зохион байгуулалттай уялдуулах асуудлыг онцгой анхаарч үзэх,
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр судалгааг өргөтгөх,
- Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдолыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах, дархан цаазат газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх хэв маягийг тогтоох,
- Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ховор ан амьтан, ургамлын судалгаа гаргаж, хэвийн өсөж үржих нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг өргөтгөх,
- Байгаль орчны доройтол, ургамал, амьтны хорогдолтой тэмцэх, нөхөн үржүүлэх, нутагшуулах ажлыг явуулахдаа үндэсний уламжлалт аргуудыг дэлхийн дэвшилтэт арга, технологитой хослуулах,
- Ховор амьтан үржиж төллөдөг, нүүдлийн болон суурин амьдардаг шувууд бүхий газрыг тусгай хамгаалалтад авах арга хэмжээ авах,
- Сэлэнгэ аймаг шиг ан элбэгтэй аймагт Монгол Улсын Ан агнуурын тухай хуулийг чанд мөрдөх, гаднын аймгийн олз хайсан, ялангуяа нохойгоор ан хийдэг анчдад хатуу хяналт тавих,
- Усны балансыг зохицуулах үүрэгтэй ой мод ба голын татмын бургас, улиасан шугуй болон бүх төрлийн сөөг, заримдаг сөөг ургамлуудыг түлшинд хэрэглэхийг бүрэн зогсоох, шахмал түлш үйлдвэрлэх,

- Бүс нутгийн экосистемийг төлөөлөх загвар талбай сонгон авч урт хугацааны мониторинг судалгаа явуулах

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бүрэлдэн, ашиглалт хамгаалалт сайжирна.

НАЙМДУГААР БҮЛЭГ
АМРАЛТ, РАШААН СУВИЛАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН БАЙРШИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Орчин үед дэлхий даяар улс төрийн уур амьсгал сайжрахын хэрээр улс орнуудаар аялах жуулчдын тоо нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийгээр аялах жуулчдын тоо 4.6 хувь өсөж, 2002 онд 900 сая гаруй болжээ. Зөвхөн Сэлэнгэ аймагт гэхэд л 2005 онд дотоодын 5000 гаруй, гадаадын 400 орчим жуулчид ирж, аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар аялсан. Энэ тоо цаашид ч өсөх хандлагатай байна. Аялал жуулчлалд оролцож байгаа улс орон, жуулчлалаар ирж байгаа хүмүүсийн эрэлт хэрэгцээ, сонирхол янз бүр байна. Иймээс аялал жуулчлалыг орон нутгийн онцлог, боломжтой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай.

Түүх, соёлын дурсгалт газрууд. Сэлэнгэ аймагт өвөрмөц тогтоц бүхий байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалт газар их байдаг. Аймгийн нутаг дэвсгэрээс олдсон олдворууд нь энэ нутагт одоогоос 400-500 мянган жилийн өмнөөс хүн амьдарч байсныг гэрчилдэг. Сүхбаатар хотын орчимд чулуун зэвсгийн дээд үед 40000-12000 жилийн өмнөх холбогдолтой олон дурсгалууд бий. Манай эриний өмнөх I зууны үеэс хүчирхэгжин Төв Азид ноёрхож байсан, Хүннү гүрний гол төвлөрөл, хожим 10-р зууны үеэс хүчирхэгжин мандаж байсан “Гурван мэргэд” аймаг ч энэ нутагт байжээ. XIY-XVIII дугаар зууны үеэс Хиагт, Хүдэр Зэлтэрээр олон улсын худалдаа явагдаж олон улсын худалдаа, эдийн засгийн гол зангилаа болж байсан юм. Сэлэнгэ аймгийн нутаг нь Их Монгол улсын үед Баруун хойд хязгаар байгаад Их Монгол улсын задралын үед Гэрсэн Жалайр хун тайжийн нутагт харьяалагдах болжээ. Богд хаант Монгол улсын үед Түшээт хан аймгийн Эрдэнэван, Баатар ван, Ахай гүний хошуунуудаас бүрддэг байсан ба хожим Эрдэнэвангийн хошуунаас тусгаарлаж Сумьяа бэйсийн хошуу гэж шинээр байгуулагдсан байна. Сэлэнгэ аймагт төмрийн үйлдвэрлэл, цэргийн зэвсгийн үйлдвэрлэл, газар тариаланг дээр үеэс эрхэлж байсан улбаа бий.

Тус аймаг эртний Монголын их хаад Амбагай, Хотол, Хабул, Есүхэй хаадын унаган нутаг юм. 1921 онд Ардын хувьсгалын анхны ялалт Сэлэнгэ аймагт болж Шивээ Хиагт, Шаамарын шар тохой, Улаанбургас, Ханын хөндийн тулалдаанууд түүхэнд тэмдэглэгдэн үлдэж, ардын журамт цэргийн байрлаж, бүтэц зохион байгуулалтаа шийдвэрлэж байсан Ханын хөндий, Номт, Эрээн арал, Алтан зэрэг газрууд түүх соёлын дурсгалт газар болон үлджээ. Алтанбулаг сум нь Ардын

хувьсгалын өлгий нутаг бөгөөд энэ суманд Ардын хувьсгалын цогцолбор музей байдаг.

Байгалийн үзэсгэлэнт болон амралт, рашаан сувиллын газрууд. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан онцлогтоо тулгуурлаж аялал жуулчлал хөгжүүлэх байгалийн үзэсгэлэнт газрууд олон бий. Байгалийн үзэсгэлэнт газруудад амрахаас гадна рашаан усанд орох, усан эмчилгээ хийж бие эрхтэнээ эрүүлжүүлэх өргөн боломж бүхий рашаан элбэгтэй. Тухайлбал: Шаамар суманд Дулаанхааны рашаан, Зүүнбүрэн суманд Мангирт Далтын рашаан, Хушаат суманд Асмалжин, Ар могойн рашаан, Сант суманд Хөндлөнгийн, Хүдэр суманд Ар номтын рашаан бий. Хондын рашаан амралтын газар нь Сэлэнгэ аймгийн нутагт далайн түвшнээс дээш 590 м өндөрт битүү нарс, хусан ойн дунд байрладаг, 5 га газар ашигладаг. Нэг ээлжинд өвөл 40 хүн, зун 200 хүн хүлээн авах хүчин чадалтай. Хондын рашаан нь дөрөвдөгч галавын үеийн шуурч тогтсон маш зузаан, 30 м өндөр элсэн дэнж дороос гардаг ус юм. Барагцаалбал 4 булаг нийлээд цагт 720 л ус гаргадаг. Гидрокарбонат, натри, кальцийн төрөлд багтдаг. Алтанбулаг сумын Хяраан нуурын лаг шаврыг үе мөчний өвчинд хэрэглэдэг. Нуурын эрдэсжилт 245 г/л карбонат-сульфат-натрийн найрлагатай. “Гүн нуур” жуулчны бааз Сэлэнгэ аймгийн төвөөс 40 км, Алтанбулаг сумын төвөөс 24 км зайд оршдог. 1982 оноос ажиллаж байгаа жуулчин хүлээн авах модон байртай, өвөл 120 хүн, дөрвөн гэрт нэг ээлжинд 32 хүн хүлээн авах бололцоотой. Гүн нуурын эрэгт битүү нарсан ойтой. Ойролцоо хүүхдийн зуслантай. Нийт 10 га газар ашигладаг.

Аялал, жуулчлал, амралтын чиглэлээр Алтанбулаг суманд Номт, Гүн-Нуур, Бат-Оюу ХХК-ийн амралт, Мандал суманд Арцат хүүхдийн амралт, ахмадын “Тарни” амралт, Шаамар суманд Цагдаагийн газрын харъяа амралт, Баруунбүрэн суманд Амарбаясгалант ергее ХХК, Бүрэн-Эрдэнэ Моностой ХХК, Хүдэр суманд Монгол Саппори зэрэг амралтын газрууд ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлийг байгалийн аялал жуулчлалын, бизнес аялал жуулчлалын, түүх соёлын дурсгалт газрын гэсэн 3 чиглэлээр төлөвлөв. Үүнд:

Байгалийн аялал жуулчлалын маршрут нь Улаанбаатар хотоос Алтанбулаг хүртэл, Алтанбулагаас Номт, Хонд, Гүн нуурын чиглэлд, Сүхбаатар хотоос Ээж мод,

Зулзагын гол, хүүхдийн зуслангийн чиглэлд, Баянголоос Тарнийн амралт, Улаанбаатараас Мандал, Хонин нугын чиглэлд,

Бизнес аялал жуулчлалын чиглэл нь Улаанбаатараас Алтанбулаг боомт хүртэл,

Түүх, соёлын дурсгалт газраар аялах маршрут нь Улаанбаатараас Баянгол сум, Дархан хот, Сант, Амарбаясгалант хийд, Ламын хийдийн балгас хүртэл тус тус байна.

Зүүнбүрэн сумын Боонгын тохой 2 давааны хооронд, Мандал суманд Бэрлэг, Ялбага, Ерөө сумын Бүхлээ Ялбага, Цагааннуур сумын Тамгын хоолойд байгалийн аялал жуулчлал сонирхогчдод загас барих боломж бий.

Аялал жуулчлалын газрын талаар тавих тэргүүлэх зорилт: Аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл: Байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах, аялалын маршрутуудыг гарган, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх,

- Байгалийн өвөрмөц сонин, давтагдашгүй тогтоц, түүх, соёлын дурсгалт газраар аялж байгалийн баялаг жимс жимсгэнэ түүх, спорт агнуур, усан аялал хийх боломж бүхий газруудыг хамруулан аялал жуулчлалын бичил бүсүүдийг байгуулж, хөгжүүлэх, тэдгээрийн экологийн даац, багтаамжид тохирсон аялал жуулчлалын бааз-отгуудыг байгуулах,
- Сэлэнгэ мөрөн болон Орхон голоор дамжин Сүхбаатар орчмын Орхон-Сэлэнгийн бэлчир орох усан замын аялалыг зохион байгуулах,
- Темер замын дагуу аялал хийх, сонирхолтой аялалын маршрутыг гаргаж аялалын чиглэл, хамрах хүрээг өргөжүүлэх,
- Аялал жуулчлал, амралт, рашаан сувиллын газруудын байршил, аялал жуулчлалын замнал, аяллын хэлбэр, зорилго зэргийг тодорхой тусгасан зураглал зохиож, сурталчлах,
- Уулын ба цанын спортыг хөгжүүлэх, усан аялал, ан агнуур, загасчлал хийх газруудыг нарийвчлан тогтоох,
- Рашаан, сувиллын газруудын хүчин чадлыг нь өргөжүүлэн, эмчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр тогтмол ажиллагаатай болгох,

- Рашаан сувиллын газруудын суурьшлын бүсийг рашааны ундарга багасгах, бохирдохоос сэргийлэх зорилгоор, ус, салхины доор байршуулах, бохирын цооногийг шаардлагын түвшинд доторлож, битүүмжлэх, орчны бохирдлоос сэргийлэх, ундаргыг нь хамгаалах, ариун цэврийн бүс тогтоох,
- Орхон голын эрэг дээр Усан сээрийн орчимд спорт агнуур хөгжүүлэх,
- Бүрэнгийн нуруу, Тужийн нарс, Хонин нуга зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Сэлэнгэ аймгийн үзэсгэлэнт байгалиар аялуулах төдийгүй гадаад, дотоодын жуулчдыг хил дамнуулан Байгаль нуур, Сибирийн үзэсгэлэнт газруудаар аялуулах аялалын маршрутыг гаргаж, аялал жуулчлалын хамтарсан аж ахуйн нэгжүүдийг дэмжих,

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын бичил бүсүүд тодорхой болж, аялалын үндсэн маршрутаар аялах амрагч, жуулчдын тоо олширч, аймгийн эдийн засгийн өсөлтөнд энэ салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдэнэ.

Сэлэнгэ аймагт үйлдвэрийн газрын нийт эзэлж байгаа талбай 327 га, уурхайн дэвсгэр газар 14696 га, ашигт малтмал олборлож байгаа уурхайн талбай 14515 га байна (Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан).

Сэлэнгэ аймаг алт, чулуун нүүрс, төмрийн хүдэр, мөнгө, вольфрам, зэс, молибден, шохой, гантиг, янз бүрийн будаг зэрэг ашигт малтмалаар нэн баялаг. Тус аймаг нь одоо нүүрс, алт, шохойн чулуу зэргийг үйлдвэрийн аргаар ашиглаж байна. Алтыг шороон орд болон хадан цагааны судалд наалдаж тогтсон алтны хүдрээс ялган авч байна. Алт нь зөвхөн алтны үндсэн орд ба шороон ордод байх төдийгүй зэс, мөнгө, цайрын ордуудад дагавар элемент хэлбэрээр тогтсон байдаг.

Сэлэнгэ аймгийн нутагт улсдаа дээгүүрт ордог стратегийн ач холбогдолтой томоохон орд болох Бороогийн алтны орд бий. Энэ орд нь Сэлэнгэ аймгийн Баруунхараагаас өмнө зүгт 15 км зайд, Улаанбаатар-Дарханы хар замын зүүн талд $48^{\circ}56'-48^{\circ}40'$, $106^{\circ}00'-116^{\circ}16'$ солбицолд оршино, 1407 га талбайтай. Алтны энэ орд нь мөнгийг дайвар байдлаар агуулдаг. Уг ордын талбай нь дунд Кембрий-доод Ордовикийн настай элсэн чулуу, алевролит, занарын үелэлээс тогтсон Хараагийн серийн хурдас түүнийг зүссэн доод Палеозойн настай габбро-гранодиорит-боржин, дээд Девоны настай боржин болон түрүү Мезозойн настай габбро, диабаз, диорит, гранит порфирын дэл судлуудаас тогтжээ. Алтны хүдэр агуулсан хүдрийн биет нь түрүү Мезозойн дэл судлуудтай орон зайн болоод гарал үүслийн нягт холбоотой хөгжиж байршсан ба хүдрийн биет болон эдгээр дэл судлууд нь нэг ижил уналт, суналтай тархсан. Хүдрийн биетийн гүнрүү эдгээр дэл судлуудын, ялангуяа диоритын дэл судлуудын хэмжээ эрс ихэсдэг. Бороогийн ордын хүдрийн биет нь бараг өргөргийн дагуу сунаж, хойд зүгрүү налуу (10° - 30°) унасан тектоникийн суларлын бүсэд байршдаг бөгөөд суналынхаа дагуу бараг 2 км урт, уналынхаа дагуу бараг 1 км үргэлжилдэг. Түүний зузаан нь 3.0-5.0 метрээс 34 метр хүртэл хэлбэлздэг. Ордын балансын нөөц М+С зэргээр 43 тонн, балансын бус – 11.1 тонн бөгөөд таамаг нөөц Р1 зэргээр 478 тонн гэж тооцоолсон. Тус ордыг түшиглүүлэн жилд 4 тонн алт олборлох уул уурхайн үйлдвэр байгуулж байна.

Их Даширын хойд жалгын алтны шороон орд: Энэ орд нь Бороо-Зуун модны хүдрийн дүүрэгт хамаарах бөгөөд 2500 м орчим урттай, 40-200 м өргөнтэй, Их Даширын томоохон шороон ордыг хойд талаар нь эмжиж тогтсон, гадаргуугийн болон гүний усны нөөц хязгаарлагдмал, рельефийн хувьд уулын ажилд тохиромж муутай, харин дэд бүтэц муугүй хөгжсөн онцлогтой. Шороон ордыг агуулагч сэвсгэр хурдас нь дөрөвдөгчийн настай элюви, пролювийн гаралтай хайрга-хайргархаг, шаварлаг элс юм. Уг ордын нөөцийн ихэнхи нь С1+Р1 зэргээр тогтоогдсон ба алт

агуулсан давхаргын зузаан 1.2-2.0 метр, хучдас хөрсний зузаан 4.0-5.5 м, алтны дундаж агуулга $330-1200 \text{ мг/м}^3$ –д хэлбэлзэнэ.

Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур, Жаргалант, Цээл Угтаалцайдам сумдын нутагт орших Бороо-Зуунмодны талбайд “Бороо Гоулд” ХХК урьд хийгдсэн геологи хайгуулын ажлын үр дүнг баталгаажуулж, нөөцийн үнэмшил хангалттай болохыг баталсан бөгөөд Бороогийн алтны үндсэн ордын нөөцийг 42560 кг гэж шинэчлэн тооцоолсон байна. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дахь үндсэн ордыг ашиглах уул уурхайн үйлдвэрийн эхний ээлж 2003 оноос ашиглалтад орж, 8-10 жил ашиглахаар Австрали-Канадын хөрөнгө оруулалттай Бороо гоулд компани уул уурхайн баяжуулах үйлдвэр байгуулан ажиллаж байна.

Ерөөгийн алтны шороон орд: Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн салбар, Ерөө голын цутгалан болох голын хөндий болон дунд зэргийн уулсын дундах хөндийд байрладаг бөгөөд уулын чулуулгийн тогтоц нь палеозойн настай хувирмал чулуу занар, элсэн чулуулгаас тогтоно. Алтны дундаж агуулга харилцан адилгүй маш хувирамтгай байдаг бөгөөд дундаж агуулга нь $0.310 \text{ мг/ м}^3 \cdot 0.310 \text{ мг/ м}^3$ –д хүрдэг.

Төмөртэйн төмрийн орд: Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт 2864 га талбайтай. Тус ордын нөөц А+В+С, зэрэглэлээр 158 сая тонн бөгөөд таамаг нөөц 350 сая тонн гэсэн тойм үнэлгээ бий. Төмрийн дундаж агуулга 51.15-54.5% байна. Ордыг ашиглахад 110 км төмөр зам тавьж 6-7 мянган хүнтэй тосгон шинээр буй болно. 1.5-1.6 сая тонн ган хайлуулах үйлдвэр байгуулах тооцоо хийгдсэн. Энэхүү цогцолборын хүрээнд жилд 600-700 мянган тонн коксжсон нүүрс нийлүүлэх хэрэгцээ бий. Мөн Баянголын төмрийн орд газрын нөөц нь тогтоогдсон. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд Төмөртэйн төмрийн ордын бүс газар гэсэн үйлдвэржилтийн шинэ бүс газар 2010 онд бий болно.

Улаан Овоогийн нүүрсний орд: Тус чулуун нүүрсний орд нь төмөр замын Шаамар өртөөнөөс 120 км, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс 7 км-т оршино. Гэхдээ энэ орд Зэлтэр голын сав газарт Жид, Бүтээлийн нурууны дунд, Тавтын тал хэмээх хөндийд нэн усжилт бүхий нөхцөлд оршдоогоороо онцлог. Дэд бүтэц хөгжөөгүй Орхон, Сэлэнгэ голууд дээгүүр төмөр замын гүүр тавих хэрэгцээтэй гэсэн бодит бэрхшээл бий.

Тус орд нь нүүрсний I, II давхаргаас тогтох бөгөөд давхаргуудын зузаан нь 62.79 м болно. Нүүрсний I давхарга нь ордын баруун талд тархан байрласан хамгийн доод давхарга юм. Энэ давхаргын зузаан нь 2-7.5 м хүртэл хэлбэлзэх бөгөөд дундаж зузаан нь 3.9 м болох ба энгийнээс нарийн бүтэцтэй чулуулгийн 0.56-0.77 м

зузаантай 3 үеэс тогтоно. Нүүрсний I давхарга нь нүүрсний II давхаргаас 9.6-33.7 м зузаантай элсэн чулууны үеэр тусгаарлагдсан болно.

Нүүрсний II давхарга нь үйлдвэрлэлийн ач холбогдолтой юм. Энэ давхаргын зузаан нь 29.8-63.9 м хүртэл хэлбэлзэх бөгөөд дундаж нь 53.9 м. Ордын нүүрсний давхаргууд нь бага үнслэгтэйд тооцогдох бөгөөд исэлдээгүй нүүрсэнд үнслэг 10-23.7%, исэлдсэн нүүрсэнд 7.9-14.7%, өгөршсөн нүүрсэнд 14.8-23.7% тус тус байна.

Чулуулгийн үенцэрийн бохирдлоос нүүрсний үнслэг 3.7% ихсэх хандлагатай. Нүүрс нь хагас гялалзсан хар өнгөтэй "Д" маркийн 06 ангилалд хамаарна. Нүүрсний дэгдэмхий бодисын хэмжээ 39.9-52.3%-ийн хооронд хэлбэлзэнэ. Нүүрсний чийглэгийн хэмжээ ордын дунджаар 10.5%, өгөршсөн нүүрсэнд 13.5% байна. Ажлын чийгийн хэмжээ исэлдээгүй нүүрсэнд 15.3%, исэлдсэн нүүрсэнд 14.5-19%, өгөршсөн нүүрсэнд 19.8-26.8% тус тус байна. Энэ ордын нүүрс нь хүхэр багатай бөгөөд хүхрийн агуулга 0.13-0.53% байна. Нүүрсний дулаан гаргах чадвар исэлдээгүй нүүрсэнд 7025-7533 ккал/кг, исэлдсэн нүүрсэнд 5133-5860 ккал/кг, өгөршсөн нүүрсэнд 4524-5376 ккал/кг тус тус байна.

Энэхүү ордын уул-геологийн болон уул-техникийн нөхцөл нь нүүрсийг ил аргаар авто тээвэртэй ашиглалтын систем хэрэглэн ашиглах боломжтой. Орд газар нь их усархаг учир усыг шүүрүүлэх ажилд цооногийн арга хэрэглэхэд тохиромжтой.

Дээрх орд газруудын доорхи талбай нь бэлчээр, хадлангийн эдэлбэр газраас үйлдвэржилтийн бүс газарт шилжинэ. Мөн үйлдвэржилтийн шинэ бүсийг даган хот суурин газар бий болно.

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр ажиллаж буй томоохон аж ахуйн нэгжүүд:

- ✓ "Гачуурт" ХХК. 1996 оноос Мандал суманд хайгуул болон уул уурхайн чиглэлээр алт олборлож байна. Жилд дунджаар 200-250 кг алт олборлодог. Зүүнбүрэн суманд Орхон гол дээр 1800 га усалтын систем байгуулсан.
- ✓ "Бороо-гоулд" ХХК. 1995 оноос хойш Баянгол суманд хайгуул болон уул уурхайн чиглэлээр алт олборлон жилдээ 25-100 кг-ыг олборлодог байсан ба одоогоор Канадын компанитай хамтран цаашид алт олборлох өндөр хвчин чадалтай үйлдвэр барьж байгаа ба үйлдвэрийн эхний ээлж жилдээ 1 тонн гаруй алт олборлох юм.
- ✓ "Золотая Виктория" ХХК. 1998 оноос Ереэ сумын нутагт хайгуул-уул уурхайн чиглэлээр ажиллаж байна. Алт олборлолт явуулж жилдээ 200-400 кг алт олборлож байна.

- ✓ "Ундрам сэд" ХХК.Баянгол суманд хайгуул уул-уурхайн чиглэлээр Бороогийн алтны уурхайн хажууд алт олборлолт явуулдаг ба жилдээ 80-100 кг алт олборлодог.
- ✓ "Мон-Зол" ХХК.1996 оноос Мандал суманд геологи хайгуул уул уурхай, үйлдвэр худалдааны чиглэлээр вйл ажиллагаа явуулдаг. Жилд дунджаар 50-80 кг алт олборлодог.

Ашигт малтмал, уул уурхай, үйлдвэржилтийн салбарыг хөгжүүлэх талаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дараах зорилтууд тусгагдсан болно.

- Татвар, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх,
- Уул уурхайн үйлдвэрлэлээс орох экспортын орлогыг нэмэгдүүлэх,
- Эрдэнэт үйлдвэрт технологийн шинэчлэлт хийж, баяжмал боловсруулалтын түвшинг гүнзгийрүүлэн, үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Катодын зэсийн үйлдвэрлэлийг 10-15 мян.тоннд хүргэх ,
- Алт олборлолтыг 1.5 дахин нэмэгдүүлэх,
- Бүсчилсэн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн алслагдсан районуудад геологи хайгуулын болон олборлолтын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг нь тогтоосон орд газруудыг ашиглалтанд оруулахад дэмжлэг үзүүлэх,
- Одоо ажиллаж буй уул уурхайн үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх зэрэг болно.

Уул уурхайг хөгжүүлэх хүрээнд тавих тэргүүлэх зорилт: Эрдэс түүхий эдийн нөөцийг ашиглах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого баримталж, нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглалтанд оруулах замаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын орд газруудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулах, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэн, сонирхлыг татах нөхцөл бүрдүүлэх,

- Төмөртэйн төмрийн ордыг ашиглаж эхлэх,
- Түшиг сумын Улаан Овоо, Хүдэр сумын Цогт голын нүүрсний уурхайг ашиглалтанд оруулах.

Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд тавих тэргүүлэх зорилт:

Хөдөө аж ахуй, түүхий эдийн нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

- Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж үйлдвэрлэлийг сэргээх,
- Аж үйлдвэрийн салбарын техник, технологийг шинэчлэх, гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэр, цех байгуулах,
- Мандал суманд элсэн чихрийн үйлдвэр ашиглалтанд оруулах.

Бизнесийг дэмжих, зах зээлийг либеральчлах хүрээнд тавих тэргүүлэх зорилт:

Чөлөөт бүс, хилийн боомтуудын үйл ажиллагааг улам сайжруулж, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх.

- ✓ Аймгийн хүн амын хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, худалдааны чөлөөт бүс байгуулна.
- ✓ Уул уурхайн томоохон ордуудыг түшиглэн үйлдвэрийн цогцолбор байгуулах асуудлыг дэд бүтцийн хөгжилтэй нягт уялдуулах бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахуйц аж үйлдвэрийн бүс бий болгох,

Гарах үр дүн: Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд тэдгээр салбарын эзлэх хувийн жин өснө.